



Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комисс

ХҮНИЙ ЭРХ

ОНОЛ, АРГА ЗҮЙН СЭТГҮҮЛ

UIN.MN
СУДАЛГААНЫ САН

“Хүний эрх, эрх чөлөөг орон даяар,
цаг ямагт, хүн бүрт”

[19 дэх жилдээ]

2020/01

Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комисс

ХҮНИЙ ЭРХ

Онол, арга зүйн сэтгүүл

“Хүний эрх, эрх чөлөөг орон даяар,
цаг ямагт, хүн бүрт”

[19 дэх жилдээ]

2020/01

ХҮНИЙ ЭРХ сэтгүүл
2020/01 (55)
Улсын бүртгэлийн дугаар 244
19 дэх жилдээ

- П.Оюунчимэг *Ерөнхий редактор (Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүн, Хууль зүйн ухааны доктор, дэд профессор)*
- З.Өнөржаргал *Хариуцлагатай нарийн бичгийн дарга (Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын Ахлах референт)*

UIN.MN
СУДАЛГААНЫ САН

**© Сэтгүүлд нийтлэгдсэн бүтээл нь Хүний эрхийн
Үндэсний Комиссын бодлогыг илэрхийлэхгүй,
зөвхөн зохиогчийн үзэл бодол болно.**

ӨГҮҮЛЭЛ, НИЙТЛЭЛ

<i>Г.Агар-Эрдэнэ</i> Ковид-19 ба ахмад настны эрх	5
<i>Д.Бямбажав (Ph.D)</i> Хүний эрхэд нөлөөлөх байдлын үнэлгээ хийх арга зүй: Тавантолгойн бүлэг ордын үнэлгээний туршлага, сургамж	18
<i>Г.Ганбаясгах</i> <i>Э.Хишигбаяр</i> Биеэ үнэлэлт, бэлгийн мөлжлөгийн талаарх олон нийтийн үзэл хандлага, тулгамдаж буй асуудал	36
<i>Э.Гэрэлт-Од (Ph.D)</i> Сонгогчийн эрх нь эрх зүйн болон институцийн асуудал болох нь	43
<i>Д.Мягмарсүрэн</i> Цар тахлын нөхцөлд иргэний эрх, үүргийн уялдааг хангах нь	58
<i>Б.Нямжав</i> Хүүхдийн эрхийг хангахад анхан шатны нэгжид тулгамдаж буй зарим асуудал	70

МОНГОЛ ХЭЛЭЭР ЗӨВХӨН МАНАЙ ХУУДАСНАА

Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүний эрхийн Дээд Комиссарын Газраас гаргасан Ковид-19 удирдамж	82
Коронавирусын цар тахалтай холбоотой Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх Дэд хорооноос Урьдчилан сэргийлэх үндэсний механизм болон оролцогч улс орнуудад гаргасан зөвлөмжүүд	97
Эмнести Интернэшнл байгууллагын олон нийтэд хандсан мэдэгдэл "Улс орнуудын Ковид-19 вирусын халдварт өвчний эсрэг авч буй арга хэмжээ болон хүний эрхийг хангах үүрэг, хариуцлага: Эхний ажиглалт" (Хэсэгчлэн оруулав)	104

ЗОЧНЫ ЯРИА

<i>Монгол Улсын Ерөнхий прокурорын орлогч, төрийн хууль цаазын шадар зөвлөх М.Чинбаттай хийсэн ярилцлага</i> "Хүний эрх, эрх чөлөөг хамгаалах нь прокурорын хуулиар хүлээсэн үүрэг мөн"	113
---	-----

CONTENT

ARTICLES

<i>Agar-Erdene .G</i> Covid-19 and rights of older persons	5
<i>Byambajav .D. (Ph.D)</i> A framework for conducting human rights impact assessment: Lessons from an assessment of Tavantolgoi mines.	18
<i>Ganbayasakh .G</i> <i>Khishigbayar .E</i> Public perception about prostitution and sexual exploitation and pressing issues	36
<i>Gerelt-Od .E</i> Voter's rights as legal and institutional issues	43
<i>Myagmarsuren .D</i> The coherence of civil rights and responsibilities in the covid-19 pandemic	58
<i>Nyamjav .B</i> Some challenges in protecting children's rights for primary units.	70

ONLY IN MONGOLIAN

Unites Nations Human rights office of the High Comissioner Covid-19 Guidance	82
Subcommittee on prevention of torture and other cruel, Inhuman or degrading treatment or punishment.	97
Advice of the Subcommittee on Prevention of Torture to States Parties and National Preventive Mechanisms relating to the Coronavirus Pandemic Amnesty international public statement (Abstract).	104

GUEST INTERVIEW

<i>Interview with Mr. M.Chinbat, Deputy to the State Prosecutor General, State Deputy Legal Counselor</i> "Protecting human rights and freedoms is a prosecutor's legal duty"	113
--	-----





Г.АГАР-ЭРДЭНЭ

Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын
Хүний эрхийн боловсрол, судалгааны хэлтсийн дарга,
хууль зүйн магистр

КОВИД-19 БА АХМАД НАСТНЫ ЭРХ COVID-19 AND RIGHTS OF OLDER PERSONS

Хураангуй: Хүний эрхийн Түгээмэл Тунхаглалд хүн бүр уг тунхаглалд заасан эрхээ ямарваа ялгаварлан гадуурхалтаас ангид эдлэх ёстойг баталгаажуулсан билээ. Энэ ёсоор Ковид-19 цар тахлын үед ч ахмад настнууд эрхээ бусадтай адил тэгш, ямар нэгэн ялгаваргүй эдлэх ёстой. Хэрэв ахмад настныг насаар нь ялгаварлах, тэднийг үл ойшоох бодлого хэрэгжүүлбэл Ковид-19 цар тахлыг бүх нийтээр давж гарахад улам хүндрэлтэй болох бөгөөд эсрэгээрээ тэдний эрхийг хангахад чиглэсэн үйл ажиллагаа нь цар тахлыг даван туулахад амжилт авчрах гол түлхүүр болох учиртай юм.

Түлхүүр үг: Ахмад настны эрх, ялгаварлан гадуурхалт, Ковид-19.

Abstract: The Universal Declaration of Human Rights guarantees that everyone has the right to exercise his or her rights without discrimination. Similarly, even during the Covid-19 pandemic, older persons should be able to exercise their rights equally and without discrimination. If a policy of age discrimination and disregard for older persons is implemented, it will be more difficult to overcome Covid-19 as a whole, and conversely, efforts to protect their rights will be the key to success in overcoming the pandemic.

Keywords: Rights of older persons, discrimination, Covid-19.

Оршил

Дэлхийг хамарсан Ковид-19 цар тахлын дэгдэлт нь хүний эрхийн салбарт шинэ сорилт, бэрхшээл болж байна. НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн дарга Антонио Гутереш цар тахал хүний эрхийн хямралыг өдөөж байгааг анхааруулж, хямралын үед хүний эрхийг хойш тавих ёсгүйг сануулжээ¹. Төрийн үндсэн үүрэг нь хүний эрхийг хангаж, хамгаалах явдал хэдий ч урьд өмнө тохиолдож байгаагүй хямралын үед цаг мөчтэй уралдан авч буй хариу арга хэмжээ, гаргаж буй шийдвэр нь хүний эрхийг хөндөгдөхөд хүргэж байна.

Тэгвэл энэ цар тахалд ахмад настнууд хамгийн ихээр өртөж байна. Энэ хэрээр тэдний эрх, эрх чөлөө, амь нас, эрүүл мэндийн асуудал хөндөгдөж байгаа бөгөөд Европ тивд Ковид-19 вирусын улмаас нас барагсдын 95 хувь нь ахмад настнууд байгааг Дэлхийн эрүүл мэндийн байгууллагаас мэдээлжээ². Цар тахал анх гарсан БНХАУ-д нас барагсдын 80 хувь нь 60-аас дээш насныхан байв³. Улмаар ахмад настнуудын хувьд хамгийн чухал болох бие даан амьдрах, эрүүл мэндээ хамгаалуулах, нийгмийн халамж үйлчилгээнд хамрагдах зэрэг эрх нь зөрчигдөх, ялгаварлан гадуурхалтад өртөх тохиолдол олонтаа гарч байгааг хүний эрхийн байгууллагууд, хүний эрх хамгаалагчид мэдээлж байна.

Товчхондоо НҮБ-ын Хүний эрхийн Түгээмэл Тунхаглалд хүн бүр эрх, эрх чөлөөгөө нас, эрүүл мэндийн байдлаас үл хамааран ямарваа ялгаварлан гадуурхалтгүйгээр эдлэх ёстой гэсэн ч бодит байдал дээр адил тэгш хэрэгжиж чадахгүй байна. Ахмад настнууд Ковид-19 вирусээр өвчлөх, амь насаа алдах өндөр эрсдэл бүхий бүлэгт хамаарч байгаагаас шалтгаалан ялгаварлан гадуурхах хандлага, үйл ажиллагаанд өртөх болжээ. Иймд энэхүү өгүүллээр Ковид-19 цар тахлын үед ахмад настнуудыг ялгаварлан гадуурхалт, үл хайрхах явдлын бай болгоход хүргэж болзошгүй зарим нөхцөл байдлын талаар болон эдгээрийг шийдвэрлэхэд улс орнуудын хэрэгжүүлж буй сайн туршлагуудаас хуваалцахыг зорив.

Нэг. Ахмад настнуудад тулгарч буй хүний эрхийн зарим асуудал

Ахмад настан, хүүхэд, эмэгтэй, гей, лесби, хөгжлийн бэрхшээлтэй эсэхээс үл хамааран хүн бүр эрхээ адил тэгш эдлэх ёстойг олон улсын хүний эрхийн хэм хэмжээгээр баталгаажуулсан. Гэхдээ нийгмийн эдгээр бүлгийнхэн, тухайлбал ахмад настнууд эрхээ эдлэхэд шаардлагатай нийгмийн хэрэгцээт үйлчилгээг

1 Antonio Guterres, 'We are all in this Together: Human Rights and COVID-19 Response and Recovery' (24 April, 2020). <https://www.un.org/en/un-coronavirus-communications-team/we-are-all-together-human-rights-and-covid-19-response-and>

2 Time 'Over 95% of People who Died of Coronavirus in Europe Were Over 60, says WHO' (2 April, 2020). <https://time.com/5814330/who-europe-over-60/>

3 United Nations, Department of Economic and Social Affairs, 'A Defining Moment for Informed, Inclusive and Targeted Response' (Issue Brief: Older persons and Covid-19, April 2020). <https://www.un.org/development/desa/ageing/wp-content/uploads/sites/24/2020/04/POLICY-BRIEF-ON-COVID19-AND-OLDER-PERSONS.pdf>

авахад нь нэмэлт тусламж, дэмжлэг хэрэгтэй байдаг⁴. Өөрөөр хэлбэл Ковид-19 цар тахлын үед төрөөс нийгмийн хамгааллын нэмэлт арга хэмжээг авч, ахмад настнууд зэрэг хямралд өртөх эрсдэл өндөр хүмүүст дэмжлэг үзүүлэх ёстой юм. Хэрэв ийм хямралын үед зайлшгүй шаардлагатай тусламж, үйлчилгээг орхигдуулбал хүний эрхийн зөрчилд тооцогдоно.

Нөгөө талдаа Ковид-19 нь зөвхөн ахмад настнуудын өвчин биш бөгөөд бүх насны хүмүүс уг вирусээр халдварлаж байгааг Дэлхийн эрүүл мэндийн байгууллагаас зарласан билээ. Иймд ахмад настнуудыг эрсдлийн үндсэн бүлэгт хамааруулах нь тодорхой дэмжлэг авах шаардлагатай бусад бүлгийнхнийг (хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, зүрх, судасны, уушигны, чихрийн шижин, цусны даралт ихсэх зэрэг өвчинтэй хүмүүс гэх мэт) ард нь үлдээх эрсдэлтэй гэдгийг ч анхаарч тусламж, үйлчилгээг харилцан тэнцвэртэй, аль нэг бүлгийнхнийг орхигдуулахгүй хүргэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим байх ёстой юм⁵. 2020 оны 3 дугаар сарын 16-ны өдөр НҮБ-ын Тусгай илтгэгч болон экспертүүд, ажлын хэсгийн ахлагч нар хамтарсан мэдэгдэлдээ Ковид-19 цар тахлын үед төр засгийн авч хэрэгжүүлж буй үйл ажиллагаа хүний эрхийн хэрэгжилтийг дордуулах ёсгүй гээд “Өнөөгийн хямралын маш ноцтой бөгөөд энэхүү аюул заналхийллийн хариуд олон улсын эрх зүйгээр онц байдлын үеийн эрх хэмжээг хэрэгжүүлэхийг зөвшөөрдөгийг мэдэж байгаа ч коронавирусын эсрэг яаралтай хариу арга хэмжээ нь пропорциональ, зайлшгүй шаардлагатай бөгөөд ялгаварлан гадуурхахгүй байх ёстойг сануулж байна.”⁶ гэжээ.

Зорчих хөдөлгөөний хязгаарлалт, хөл хорио

Чөлөөтэй зорчих нь хүний үндсэн эрхийн нэг юм⁷. Гэхдээ энэхүү эрхэд тодорхой нөхцөлд хуулиар хязгаарлалт тогтоож болохыг Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактад “Хуульд заасан бөгөөд үндэсний аюулгүй байдал, нийгмийн хэв журам, эрүүл мэнд, ёс суртахуун буюу бусдын эрх, эрх чөлөө болон энэхүү пактаар хүлээн зөвшөөрсөн бусад эрхийг хамгаалахад шаардлагатай хязгаарлалтаас бусдаар дээр дурдсан эрхийг хязгаарлаж болохгүй.” гэж зохицуулжээ. Хүний эрхийн хязгаарлалт нь ардчилсан нийгмийн үнэт зүйлсийн хүрээнд тодорхойлогдсон, бусад хүний эрх, эрх чөлөөг хангахад чиглэсэн байх ёстой бөгөөд ийнхүү хязгаарласан нь ямар нэг ялгаварлан гадуурхалтын нөхцөл байдалд хүргэж болохгүй гэдэг нь мөн суурь зарчим юм. Тус пактын 4 дүгээр зүйлд “Улс үндэстний амьдралд аюул

4 UN OHCHR, 'No exceptions with COVID-19: Everyone has the right to life-saving interventions' (26 March 2020). <https://www.ohchr.org/EN/NewsEvents/Pages/DisplayNews.aspx?NewsID=25746&LangID=E>

5 Julia Mastroianni, 'Real people won't die: Rhetoric around who is at risk of coronavirus infection sparks debate over ageism, ableism' (03 March 2020). <https://nationalpost.com/news/world/real-people-wont-die-why-the-rhetoric-around-who-is-at-risk-for-coronavirus-is-so-harmful>

6 UN OHCHR, 'COVID-19: States should not abuse emergency measures to suppress human rights' (16 March 2020). <https://www.ohchr.org/EN/NewsEvents/Pages/DisplayNews.aspx?NewsID=25722&LangID=E>

7 International Covenant on Civil and Political Rights, opened for signature 16 December 1966, 999 UNTS 3 (entered into force 23 March 1976) Article 12.

занал тулгарч, энэ тухай албан ёсоор зарлаж нийтийг хамарсан онц байдал тогтоосон үед энэхүү пактад оролцогч улс уг пактаар хүлээсэн үүргээсээ тухайн нөхцөл байдлын хурцадмал шинжид дүйх хэмжээгээр ухарсан арга хэмжээ авч болох бөгөөд тэр нь олон улсын эрх зүйгээр хүлээсэн бусад үүрэгт нь харшлах ёсгүйгээс гадна зөвхөн арьс үндэс, арьсны өнгө, хүйс, хэл, шашин шүтлэг буюу нийгмийн гарлаар алагчилах явдалд хүргэхгүй байх ёстой.” гэж заасан байна⁸.

Тэгвэл зарим улс орнууд чөлөөтэй зорчих эрхийг хязгаарлахдаа насаар нь ангилж, ахмад настнуудыг гэртээ байхыг даалгаж, хэрэв зөрчвөл өндөр хэмжээний торгууль, шийтгэл хүлээлгэхээр журамлажээ. Тухайлбал Босни Герцеговин Улс 65-аас дээш настнуудыг гэрээсээ гарахыг хэдэн 7 хоногоор хориглож, хүнсний дэлгүүр, эмийн сан орохгүй байх, хогоо хаяхгүй байхыг үүрэг болгосон байна. Үүнийг зөрчсөн 200 гаруй ахмад настныг торгожээ. Арга хэмжээний зорилго нь халдвар авах эрсдэл өндөр хүмүүсийг хамгаалахад чиглэсэн боловч ялгаварлан гадуурхалтын нэг хэлбэр юм. Тодорхой насны бүлэг зааж, хариуцлага хүлээлгэсэн нь тэгш эрхийн зарчимд харшилжээ. Тус улсын Засгийн газар 2020 оны 4 дүгээр сарын 3-ны өдөр ахмад настнуудыг Даваагаас Баасан гаригт өглөө 7 цагаас өдөр 12 цаг хүртэл гэрээсээ гарахыг зөвшөөрч журамдаа өөрчлөлт оруулсан байна⁹. Зорчих хөдөлгөөнийг хязгаарлах үйл ажиллагааг хувьчлан хэрэгжүүлэхээр зааж болохоос насаар ангилах нь энэ цар тахлын үед ялгаварлан гадуурхалтад тооцогдоно гэдгийг хүний эрхийн олон улсын хэм хэмжээнд тодорхой заажээ.

Нийгмийн харилцаанд зай барих (Social distancing)

Ганц бие, ойрын төрөл садангүй, эсхүл үр хүүхдүүдээсээ хол оршин суудаг ахмад настнуудад хөл хорионы дэглэм онцгой нөлөөлөл үзүүлж эхэлжээ. “Нийгмийн харилцаанд зай барих” гэдэг нь бие махбодын хувьд эрсдэлгүй орон зайд байхыг хэлж буйгаас биш харилцаа холбоог хязгаарлах, таслахад хүргэж болохгүй гэдгийг анхаарах нь чухал юм¹⁰. Энэ цаг үед хүмүүс нийгмийн сүлжээг өргөнөөр ашиглаж байгаа боловч ахмад настай олон хүн компьютер, таблет эсвэл ухаалаг гар утас, интернэтгүй орчинд гэр бүл болон найз нөхөдтэйгээ зайнаас холбогдох чадвар, боломж хязгаарлагдмал байна. Тухайлбал интернэтийн хэрэглээнд насны ялгаа багасч байгаа хэдий ч АНУ-д 65 ба түүнээс дээш настай хүмүүсийн гуравны нэг нь интернэт огт ашигладаггүй гэсэн ба тэдний тал хувь нь гэртээ интернэтийн холболтгүй гэжээ¹¹.

8 ICCPR, Article 4.

9 Emina Cerimovic, Margaret Wurth and Bethany Brown ‘Bosnia and Herzegovina’s Coronavirus Curbs on Children and Older People Are Ill-Conceived’ (2 April 2020). <https://balkaninsight.com/2020/04/02/bosnia-and-herzegovinas-coronavirus-curbs-on-children-and-older-people-are-ill-conceived/>

10 United Nations ‘Rights and dignity’ of older people must be respected during COVID-19 and beyond (1 May 2020). <https://news.un.org/en/story/2020/05/1063052>

11 Monica Anderson and Andrew Perrin ‘Tech Adoption Climbs Among Older Adults’ (17 May 2017). <https://www.pewresearch.org/internet/2017/05/17/tech-adoption-climbs-among-older-adults/>

“Асрамжийн газарт эргэлт, уулзалт хийлгэхгүй гэх мэтээр нийгмийн харилцаанд зай барих арга хэмжээ нь зарим талаар нийгмээс тусгаарлагдахад хүргэж байна. Нийгмийн харилцаанд зай барих нь нийгмээс тусгаарлагдах явдлаар илэрч болохгүй. Биеийн махбодын хувьд зай барих нь маш чухал боловч нийгмийн харилцааг нэмэгдүүлэх бүтээлч, аюулгүй арга замыг олох шаардлагатай. Асрамжийн газар, алслагдмал газарт байгаа ахмад настнуудыг онлайнаар холбоо барих аргаар хангах ёстой.”¹² гэж НҮБ-ын Ахмад настны эрхийн асуудал хариуцсан бие даасан эксперт Р.Корнфелд-Матте онцолжээ.

Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ

Олон улсын хүний эрхийн хэм хэмжээгээр хүн бүрийн бие бялдрын болон сэтгэцийн эрүүл мэнд дээд түвшинд хүрсэн байх эрхийг хүлээн зөвшөөрөхийг улс орнуудад үүрэг болгосон. Үүнд өндөр настай, залуу ялгаагүй өвчилсөн тохиолдолд эмнэлгийн үйлчилгээ үзүүлэх, сувилах нөхцөлийг бүрдүүлэхийг төрд даалгажээ¹³.

Хүмүүсийн эрүүл мэнд, сайн сайхан байдлыг хангахын тулд нийгмийн харилцаа холбоо шаардлагатай тул төр засгаас уриалж буй хөл хорио, нийгмийн харилцаанд зай барих арга хэмжээний үеэр эрүүл мэндийн хэрэгцээг бүрэн хангахад мөн анхаарах ёстой. Ялангуяа хөл хорионы үед ахмад настнуудад гэнэтийн тусламж хэрэгтэй болсон тохиолдолд үйлчлэх түргэн тусламжийн үйлчилгээний бэлэн байдлыг хангах гэх мэт. Ихэнх улс орнуудын түргэн тусламжийн утас өндөр ачаалалтай байгаагаас цус харвалт, эсхүл зүрхний шигдээс гэх мэт яаралтай тусламж шаардлагатай ахмад настнууд цаг алдалгүй эмнэлгийн тусламж авах боломж цар тахлын үед тэр хэрээр хязгаарлагдах эрсдэлтэй юм.

Түүнчлэн цар тахлын үед эрүүл мэндийн эм, хэрэгслийн хомсдлоос шалтгаалж зарим хөгжиж буй орнуудад ахмад настнуудад амьсгалын аппарат хүрэлцэхгүй, эсхүл залуучуудад илүү хэрэглүүлэх тохиолдол гарч байгаад хүний эрхийн мэргэжилтнүүд санаа зовниж байна¹⁴. Гэтэл 65 ба түүнээс дээш насны хүмүүсийн 65-аас дээш хувь нь одоогоор буурай хөгжилтэй бүс нутагт оршин сууж буй бөгөөд өндөр орлоготой ахмад настнуудтай харьцуулахад эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ авах эрхээ эдлэхэд илүү их бэрхшээлтэй тулгарч байна¹⁵.

12 UN OHCHR, 'Unacceptable' – UN expert urges better protection of older persons facing the highest risk of the COVID-19 pandemic' (27 March 2020). <https://www.ohchr.org/EN/NewsEvents/Pages/DisplayNews.aspx?NewsID=25748&LangID=E>

13 International Covenant on Economic, Social and Cultural Rights, opened for signature 16 December 1966, 993 UNTS 3 (entered into force 3 January 1976) Article 12.

14 Denis McClean, 'COVID-19: Battling stigma and discrimination against older persons' (3 April 2020). <https://www.preventionweb.net/news/view/71195>

15 United Nations, Department of Economic and Social Affairs, Population Division (2020). World Population Ageing 2019 (ST/ESA/SER.A/444).

Асрамж, халамжийн газар, хорих байгууллага

Өөрийн дураар гарч явах боломжгүй, эрх чөлөө нь тодорхой хэмжээгээр хязгаарлагддаг төрийн болон хувийн аливаа институциудад байрлаж буй ахмад настнуудын хувьд Ковид-19 цар тахал энэ төрлийн байгууллагуудад буй бусад хүмүүстэй нэгэн адил өндөр эрсдлийг бий болгож байна. Тухайлбал ахмад настны асрамж, халамжийн газруудад амьдарч буй хүмүүсийн дунд халдвар тархах эрсдэл маш өндөр байгаа тул тусламж, үйлчилгээг цаг алдалгүй өгөхөд төрөөс онцгой анхаарах ёстой юм.

АНУ-ын Вашингтон муж улсын асрамжийн газарт 2020 оны 2 болон 3 дугаар саруудад 23 ахмад настан амь насаа алдсан байна¹⁶. Мөн 4 дүгээр сард 400 гаруй халдварын тохиолдол асрамжийн газарт нэмж бүртгэгджээ¹⁷. 2020 оны 3 дугаар сарын 31-ний өдөр Франц Улсын эрүүл мэндийн байгууллагаас тус улсын Гранд Эст дүүргийн асрамжийн газарт 570 ахмад настан халдварын улмаас амиа алдсан гэж мэдээлсэн байна¹⁸. Нийгмийн халамж, үйлчилгээг шуурхай хүргэж чадахгүй байгаагийн улмаас асрамжийн газарт буй ахмад настнууд амь насаа алдаж байгаа талаар Human Rights Watch байгууллага анхааруулжээ¹⁹. Их Британи Улсын баталсан Коронавирусын тухай хуулиар 2014 оны Халамж үйлчилгээний тухай хуульд заасан төрийн зарим үйлчилгээг түр түдгэлзүүлж болохоор заасан нь тусламж үйлчилгээ шаардлагатай олон ахмад настныг энэхүү тусламж үйлчилгээнээс ангид үлдэхэд хүргэж, эрсдлийг нэмэгдүүлж байна гэж зарим судлаачид үзсэн байна²⁰.

Дараагийн нэг онцгой объект болох хорих анги, цагдан хорих байранд буй ахмад настай ялтнууд, хоригдлуудын нөхцөл байдлыг тодорхойлж, эрсдлийн үнэлгээ хийсний үндсэн дээр хугацаанаас өмнө суллах, хорих ялыг өөр төрлийн ялаар солих гэх мэтээр цар тахлын нөхцөл байдалд тохирсон арга хэмжээ авах нь зүйтэйг олон улсын хүний эрхийн байгууллагуудаас уриалж байна²¹. Тухайлбал АНУ-д хорих ангид ял эдэлж буй ахмад настнуудын тоо ихээр нэмэгдэж байгаа учраас Ковид-19 цар тахлын үед тэдгээрт шаардлагатай эрүүл мэндийн үйлчилгээг хүргэхэд хүндрэл үүсчээ. НҮБ-ын Эрүүдэн шүүхийн эсрэг Дэд хорооноос гишүүн орнууддаа “Хоригдож байгаа хүмүүсийн дунд

16 Temet M. McMichael and Shauna Clark, 'COVID-19 in a Long-Term Care Facility-King County, Washington, February 27–March 9, 2020. (27 March 2020). <https://www.cdc.gov/mmwr/volumes/69/wr/mm6912e1.htm>

17 Jessie Hellmann, 'Coronavirus creates emergency in nursing homes' (1 April 2020). <https://thehill.com/home-news/state-watch/490715-coronavirus-creates-emergency-in-nursing-homes>

18 Financial Times, 'Tragedy unfolds as virus deaths rise in Europe's homes for elderly' (n.d.). <https://www.ft.com/content/58ece0fb-d297-495e-8889-da216410f2c3>

19 Human Rights Watch, 'Rights Risks to Older People in COVID-19 Response' (7 April 2020). <https://www.hrw.org/news/2020/04/07/rights-risks-older-people-covid-19-response>

20 Mary-Rachel McCabe and Jamie Burton, 'The Coronavirus Bill and Adult Social Care' (22 March 2020). <https://insights.doughtystreet.co.uk/post/102g29e/the-coronavirus-bill-and-adult-social-care>

21 Human Rights Watch, 'US: COVID-19 Threatens People Behind Bars' (12 March 2020). <https://www.hrw.org/news/2020/03/12/us-covid-19-threatens-people-behind-bars>

яаралтай эрсдэлийн үнэлгээ хийж, бүхий л эрсдэлтэй бүлгийг харгалзан хоригдож буй хүмүүсээс нэн эрсдэлтэй бүлгийг тодорхойлох"-ыг зөвлөсөн байна²².

Хэвлэл мэдээлэл, нийгмийн сүлжээ

Ковид-19 цар тахал эрчимжихийн хэрээр хэвлэл мэдээллийн хэрэгсэл, нийгмийн сүлжээгээр ахмад настнуудын талаар төрөл бүрийн мэдэгдэл, сэтгэгдлүүд хөврөх болжээ. Цар тахлыг амжилттай давж гарахын тулд урьд өмнөхөөсөө илүү эв нэгдэлтэй байх шаардлагатай байгаа ийм үед төрийн албан тушаалтан, эсхүл өөр бусад хүмүүсийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр хийж буй мэдэгдэл, мэдээлэл, ярилцлага нь гутаан доромжлол, ялгаварлан гадуурхалтын шинжийг агуулаагүй, хүний эрхийн өндөр мэдрэмж байх нь чухал. Ийм өнгө аястай үг хэллэг нь аль болох олон хүний амь нас, эрүүл мэндийг хамгаалахын төлөө төр засгаас гаргаж буй хүчин чармайлтад сөргөөр нөлөөлөх аюултай юм²³.

Нийгмийн сүлжээнд болон вэб сайтууд дахь мэдээний дор ахмад настныг шууд болон шууд бусаар ялгаварлан гадуурхсан шинжтэй сэтгэгдлүүд олноор бичигдэж байгаад хувь хүмүүс дүгнэлт хийж, бусдын эрх чөлөөг хүндэтгэх дадал, соёлыг эрхэмлэх нь зүйтэй юм. Тухайлан ахмад настнуудад чиглэсэн үзэн ядалтын үг хэллэг, ялгаварлан гадуурхах явдал нэмэгдэж байгааг хууль, хяналтын байгууллагууд анхаарах ёстой.

Хоёр. Сайн туршлагаудын жишээ

2020 оны 5 дугаар сарын 12-ны өдөр НҮБ-ын Хүний эрхийн дээд Комиссар болон Мишель Бачеле шинээр томилогдсон ахмад настны эрхийн асуудал хариуцсан бие даасан эксперт Клаудия Малер нар хамтран Ковид-19 ба ахмад настны эрхийн асуудлаар виртуал хэлэлцүүлэг зохион байгуулж, улс орнууд өөр өөрсдийн сайн туршлагаасаа харилцан солилцож ажиллахыг уриалсан билээ²⁴. Иймд энэхүү өгүүлэлд дурдсан хүний эрхийн зарим асуудалтай холбоотойгоор улс орнуудад хэрэгжүүлж буй сайн туршлагаас товч жагсаав.

- Дэлхийн эрүүл мэндийн байгууллагаас Ковид-19 өвчний шинж тэмдгийн талаар болон үүнээс өөрийгөө хэрхэн хамгаалах талаарх мэдээллийг агуулсан сэрэмжлүүлгийн мессежийг боловсруулжээ. Улсын болон орон нутгийн эрүүл мэндийн зарим байгууллагууд өвчний шинж

22 UN OHCHR, 'COVID-19: Measures needed to protect people deprived of liberty, UN torture prevention body says' (30 March 2020). <https://www.ohchr.org/EN/NewsEvents/Pages/DisplayNews.aspx?NewsID=25756&LangID=E>

23 UN, 'The Impact of COVID-19 on older persons' (May 2020). <https://unsdg.un.org/sites/default/files/2020-05/Policy-Brief-The-Impact-of-COVID-19-on-Older-Persons.pdf>

24 UN, OHCHR 'Virtual debate "Human Rights of older persons in the age of COVID-19 and beyond" with the High Commissioner for Human Rights and the new Independent Expert on the enjoyment of all human rights by older persons' (Statement, 12 May 2020). <https://www.ohchr.org/EN/NewsEvents/Pages/DisplayNews.aspx?NewsID=25879&LangID=E>

тэмдгийг өөрөө үнэлэх, нэмэлт мэдээлэл авах гар утасны аппликейшн боловсруулсан байна. Эдгээр нь эмнэлгийн мэргэжилтнүүдийг эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ хамгийн их хэрэгцээтэй хүмүүст анхаарлаа хандуулахад нь тусалж байна²⁵.

- Ирланд Улсын үндэсний шуудангийн үйлчилгээ эрхэлдэг "А Пост" компани цагийн хуваарь гаргаж, тус улсын Нийгмийн хамгааллын газартай хамтран өөрийгөө тусгаарлаж байгаа ахмад настнуудын тэтгэврийг тэднийг төлөөлөн авч, хүргэж өгөх "шуурхай агент"-ын үйлчилгээг нэвтрүүлсэн байна²⁶.
- Их Британи Улсын Засгийн газар цар тахлын үед сайн дурынханд хоол хүнс хүргэх, тусламж үзүүлэх үйлчилгээг 250,000 сайн дурын ажилтнаар гүйцэтгүүлэхээр уриалга гаргасан ч уг аянд 620,000 гаруй сайн дурын ажилтан нэгджээ²⁷.
- Хэд хэдэн фитнесын үйлчилгээ үзүүлэгчид ахмад настнууд, хүүхдүүдэд зориулсан онлайн аргаар дасгалын хичээлийг хийж байна²⁸.
- Их Британи Улс интернэт, үүрэн холбооны үйлчилгээ үзүүлэгчид цар тахлын үед нийгмийн сүлжээг тасалдуулахгүй байх үүднээс төлбөр, тооцоогоо хийхэд хүндрэлтэй байгаа хэрэглэгчдийн төлбөрийг хойшлуулах, хөнгөлөх зэргээр хамтран ажиллаж байна²⁹.
- Кипр Улсын Фафос хотын захиргаа "Ковид-19"-ийн улмаас гэртээ үлдэхийг зөвлөж буй ахмад настан болон хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст туслах зорилгоор дэлгүүр, эмийн сан явах хүсэлтийг утсаар хүлээж авах ажлын хэсгийг байгуулжээ³⁰.

25 WHO, 'WHO Director-General's opening remarks at the media briefing on COVID-19 - 20 March 2020' (20 March 2020). <https://www.who.int/dg/speeches/detail/who-director-general-s-opening-remarks-at-the-media-briefing-on-covid-19---20-march-2020>

26 AGE Platform Europe, 'COVID-19: good practices/ initiatives' (02 April 2020). <https://www.age-platform.eu/age-news/covid-19-good-practices-initiatives>

27 Alan McGuinness, 'Coronavirus: NHS looking for 250,000 volunteers as new hospital announced' (25 March 2020). <https://news.sky.com/story/coronavirus-250-000-strong-volunteer-force-sought-to-help-nhs-deal-with-crisis-11963068>

28 Ibid.

29 Ibid.

30 Ibid.

- Швед Улсын Ямтланд мужийн Берг хотын захиргаа 70-аас дээш насны хүмүүст долоо хоногт нэг удаа гэртээ хоол хүнсээ үнэгүй хүргүүлэх санал үйлчилгээг санаачилжээ³¹. Орон нутаг болон хүнсний дэлгүүрүүд хамтран хүргэлтийн зардлыг хариуцаж эхэлсэн байна.
- Бельги Улс асрамжийн газруудад амьдарч буй ахмад настан болон тэдний хамаатан садны хоорондын харилцааг нийгмийн сүлжээ, видео утсаар дамжуулан зохион байгуулж эхэлжээ³².

Гурав. Монгол Улсын хувьд

Монгол Улсын Үндсэн хуульд хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсролоор нь ялгаварлан гадуурхаж үл болохыг заасан. Монгол Улсад цар тахлын халдвар анх бүртгэгдсэнээс хойш төрөөс авч хэрэгжүүлж буй үйл ажиллагааны үеэр ахмад настны эрх, эрх чөлөө зөрчигдсөн, ялгаварлан гадуурхагдсан гэх мэдээлэл алга байна. УИХ 2020 оны 4 дүгээр сарын 29-ний өдөр Коронавируст халдвар "Ковид-19"-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийг батлахдаа ялгаварлан гадуурхахгүй, гутаан доромжлохгүй байх зарчмыг тус түр хуульд тусгажээ.

Хуулийн 11 дүгээр зүйлд цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх талаар эрх бүхий байгууллага, албан тушаалтнаас гаргах шийдвэр, арга хэмжээ нь Монгол Улсын Үндсэн хуулиар хамгаалсан иргэний үндсэн эрх, эрх чөлөөг хязгаарлах тохиолдолд ямар шаардлагыг хангасан байх талаар дурдахдаа "хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсролоор болон бусад шинжээр нь ялгаварлан гадуурхахгүй, нэр төрийг нь доромжлохгүй байх"³³-ыг үүрэг болгожээ.

Хуульд төрөөс авч хэрэгжүүлэх үйл ажиллагааг үе шаттай тусгасан бөгөөд ахмад настнуудад чиглэсэн тусгай зохицуулалтыг мөн оруулжээ. Тухайлбал цар тахлын үед арга хэмжээ авахдаа хүүхэд болон өндөр настай, хууч өвчтэй, эрүүл мэндийн тогтмол тусламж, үйлчилгээ шаардлагатай, хөгжлийн бэрхшээлтэй, жирэмсэн иргэдэд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, эмзэг бүлгийн иргэдэд санхүүгийн дэмжлэг үзүүлэх ажлыг Засгийн газраас авч хэрэгжүүлэхээр тусгасан

31 Maria Harning, 'Fri hemleverans av matkassar till alla över 70 år i Bergs kommun' (26 March 2020). <https://www.svt.se/nyheter/lokalt/jamtland/fri-hemleverans-av-matkassar-till-alla-over-70-i-bergs-kommun>

32 RTC, 'Opération LinkUp : des tablettes reconditionnées pour les patients covid-19' (23 April 2020). https://www.rtc.be/video/info/coronavirus/opration-linkup-des-tablettes-reconditionnees-pour-les-patients-covid-19_1505121.html

33 Коронавируст халдвар /Ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийг баталж нийгмийн эрүүл мэндийг хамгаалах зорилгоор бусад хууль, 11 дүгээр зүйлийн 11.1.5. <https://www.legalinfo.mn/law/details/15312?lawid=15312>

байна³⁴. Аж ахуйн нэгж, байгууллагад цар тахлын үед өндөр настай, хууч өвчтэй, эрүүл мэндийн тогтмол тусламж, үйлчилгээ шаардлагатай, хөгжлийн бэрхшээлтэй, жирэмсэн, эмзэг болон эрсдэлт бүлэгт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах үүргийг хүлээлгэсэн байна.

Тус хууль 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг дуустал үйлчлэх, шаардлагатай тохиолдолд 6 хүртэл сараар нэг удаа сунгаж болохоор батлагдсан бөгөөд ахмад настнуудад чиглэсэн эрүүл мэндийн бусад тусламж үйлчилгээ, нийгмийн халамжийн үйлчилгээ зэргийг 2017 онд баталсан Ахмад настны тухай хууль³⁵, бусад хуулийн хүрээнд нэг мөр хэрэгжүүлэхэд цар тахлын үед онцгой анхаарах нь зөв юм.

Энэхүү өгүүллийг бичиж байх үед Монгол Улсад Ковид-19 вирусээр өвчилсөн 197 тохиолдол бүртгэгдэж, эдгээрээс 111 хүн эдгэрээд байв³⁶. Эрүүл мэндийн яамны 2020 оны 6 дугаар сарын 17-ны өдрийн хэвлэлийн хурлын үеэр 2020 оны 5 дугаар сарын 16-ны өдөр Төв аймгийн Батсүмбэр сум дахь Ахмад настны үндэсний төвд ирсэн Монгол Улсын иргэнээс Ковид-19 вирус илэрсэн талаар мэдээлсэн юм³⁷. Уг иргэн ирсэн өдрөө тусгаарлагдаж, үүний дараа шинжилгээгээр вирусын халдвартай нь илэрсэн гэж мэдээлсэн ба тус төвд буй бусад ахмад настнуудыг вирусийн эрсдлээс хамгаалах ажлыг сайтар хэрэгжүүлж ажиллаж байна гэжээ. Монгол Улсад Ковид-19 вирусээр өвчлөгсдийн дунд хамгийн өндөр нь 65 настай иргэн байв.

Товч дүгнэлт

Ковид-19 цар тахлын үед ахмад настнууд эрхээ бусадтай адил тэгш, ямар нэгэн ялгаваргүй эдлэх ёстой. Хэрэв ахмад настныг насаар нь ялгаварлах, тэднийг үл ойшоох бодлого хэрэгжүүлбэл Ковид-19 цар тахлыг бүх нийтээр давж гарахад улам хүндрэлтэй болох бөгөөд эсрэгээрээ тэдний эрхийг хангахад чиглэсэн үйл ажиллагаа нь цар тахлыг даван туулахад амжилт авчрах гол түлхүүр болох учиртай юм.


Хүний эрхийг зайлшгүй шаардлагаар хязгаарлах тохиолдолд тэрхүү хязгаарлалт нь хүний эрхийн олон улсын суурь хэм хэмжээнд нийцсэн, эрсдлийнхээ хэр хэмжээнд тохирсон байхаас гадна хариу арга хэмжээ нь ахмад настнуудын бие даасан байдал, нэр төр, эрхэм чанарыг алдагдуулахад хүргэх ёсгүй юм.

34 *Коронавируст халдвар /Ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийг баталж, нийгмийн эрүүл мэндийг хамгаалах зорилгоор бусад хууль, 7 дугаар зүйлийн 7.1.22.* <https://www.legalinfo.mn/law/details/15312?lawid=15312>

35 *Ахмад настны тухай хууль.* <https://www.legalinfo.mn/law/details/12453?lawid=12453>

36 *Эрүүл мэндийн яам '2020 оны 6 дугаар сарын 17-ны өдрийн нөхцөл байдлын мэдээ' (17 June 2020).* <https://covid19.mohs.mn/p/cat/post/57/>

37 *Г.Өлзийхутаг 'ОХУ-аас илт эмнэл зүйн шинж тэмдэгтэй хүнийг явуулаагүй. Монголд ирэх замдаа халдвар авчихлаа гэх мэдээлэл худал' (iKon.mn, 20 May 2020).* <https://ikon.mn/n/ivym>



Ашигласан эх сурвалж:

1. AGE Platform Europe, 'COVID-19: good practices/ initiatives' (2 April 2020). <https://www.age-platform.eu/age-news/covid-19-good-practices-initiatives>
2. Alan McGuinness, 'Coronavirus: NHS looking for 250,000 volunteers as new hospital announced' (25 March 2020). <https://news.sky.com/story/coronavirus-250-000-strong-volunteer-force-sought-to-help-nhs-deal-with-crisis-11963068>
3. Antonio Guterres, 'We are all in this Together: Human Rights and COVID-19 Response and Recovery' (24 April, 2020). <https://www.un.org/en/un-coronavirus-communications-team/we-are-all-together-human-rights-and-covid-19-response-and>
4. Denis McClean, 'COVID-19: Battling stigma and discrimination against older persons' (3 April 2020). <https://www.preventionweb.net/news/view/71195>
5. Emina Cerimovic, Margaret Wurth and Bethany Brown 'Bosnia and Herzegovina's Coronavirus Curbs on Children and Older People Are Ill-Conceived' (2 April 2020). <https://balkaninsight.com/2020/04/02/bosnia-and-herzegovinas-coronavirus-curbs-on-children-and-older-people-are-ill-conceived/>
6. Financial Times, 'Tragedy unfolds as virus deaths rise in Europe's homes for elderly' (n.d.). <https://www.ft.com/content/58ece0fb-d297-495e-8889-da216410f2c3>
7. <https://www.ohchr.org/EN/NewsEvents/Pages/DisplayNews.aspx?NewsID=25748&LangID=E>
8. <https://www.ohchr.org/EN/NewsEvents/Pages/DisplayNews.aspx?NewsID=25879&LangID=E>
9. Human Rights Watch, 'Rights Risks to Older People in COVID-19 Response' (7 April 2020). <https://www.hrw.org/news/2020/04/07/rights-risks-older-people-covid-19-response>
10. Human Rights Watch, 'US: COVID-19 Threatens People Behind Bars' (12 March 2020). <https://www.hrw.org/news/2020/03/12/us-covid-19-threatens-people-behind-bars>
11. International Covenant on Civil and Political Rights, opened for signature 16 December 1966, 999 UNTS 3 (entered into force 23 March 1976).
12. International Covenant on Economic, Social and Cultural Rights, opened for signature 16 December 1966, 993 UNTS 3 (entered into force 3 January 1976).

13. Jessie Hellmann, 'Coronavirus creates emergency in nursing homes' (1 April 2020). <https://thehill.com/homenews/state-watch/490715-coronavirus-creates-emergency-in-nursing-homes>
14. Julia Mastroianni, 'Real people won't die: Rhetoric around who is at risk of coronavirus infection sparks debate over ageism, ableism' (03 March 2020). <https://nationalpost.com/news/world/real-people-wont-die-why-the-rhetoric-around-who-is-at-risk-for-coronavirus-is-so-harmful>
15. Maria Harning, 'Fri hemleverans av matkassar till alla över 70 år i Bergs kommun' (26 March 2020). <https://www.svt.se/nyheter/lokalt/jamtland/fri-hemleverans-av-matkassar-till-alla-over-70-i-bergs-kommun>
16. Mary-Rachel McCabe and Jamie Burton, 'The Coronavirus Bill and Adult Social Care' (22 March 2020). <https://insights.doughtystreet.co.uk/post/102g29e/the-coronavirus-bill-and-adult-social-care>
17. Monica Anderson and Andrew Perrin 'Tech Adoption Climbs Among Older Adults' (17 May 2017). <https://www.pewresearch.org/internet/2017/05/17/tech-adoption-climbs-among-older-adults/>
18. RTC, 'Opération LinkUp : des tablettes reconditionnées pour les patients covid-19' (23 April 2020). https://www.rtc.be/video/info/coronavirus/operation-linkup-des-tablettes-reconditionnees-pour-les-patients-covid-19_1505121.html
19. Temet M. McMichael and Shauna Clark, 'COVID-19 in a Long-Term Care Facility - King County, Washington, February 27–March 9, 2020' (27 March 2020). <https://www.cdc.gov/mmwr/volumes/69/wr/mm6912e1.htm>
20. Time 'Over 95% of People who Died of Coronavirus in Europe Were Over 60, says WHO' (2 April, 2020). <https://time.com/5814330/who-europe-over-60/>
21. UN OHCHR, 'COVID-19: Measures needed to protect people deprived of liberty, UN torture prevention body says' (30 March 2020). <https://www.ohchr.org/EN/NewsEvents/Pages/DisplayNews.aspx?NewsID=25756&LangID=E>
22. UN OHCHR, 'COVID-19: States should not abuse emergency measures to suppress human rights' (16 March 2020). <https://www.ohchr.org/EN/NewsEvents/Pages/DisplayNews.aspx?NewsID=25722&LangID=E>
23. UN OHCHR, 'No exceptions with COVID-19: Everyone has the right to life-saving interventions' (26 March 2020). <https://www.ohchr.org/EN/NewsEvents/Pages/DisplayNews.aspx?NewsID=25746&LangID=E>



24. UN OHCHR, 'Unacceptable' – UN expert urges better protection of older persons facing the highest risk of the COVID-19 pandemic' (27 March 2020).
25. UN, 'The Impact of COVID-19 on older persons' (May 2020). <https://unsdg.un.org/sites/default/files/2020-05/Policy-Brief-The-Impact-of-COVID-19-on-Older-Persons.pdf>
26. UN, OHCHR 'Virtual debate "Human Rights of older persons in the age of COVID-19 and beyond" with the High Commissioner for Human Rights and the new Independent Expert on the enjoyment of all human rights by older persons' (Statement, 12 May 2020).
27. United Nations 'Rights and dignity' of older people must be respected during COVID-19 and beyond (1 May 2020). <https://news.un.org/en/story/2020/05/1063052>
28. United Nations, Department of Economic and Social Affairs, 'A Defining Moment for Informed, Inclusive and Targeted Response' (Issue Brief: Older persons and Covid-19, April 2020). <https://www.un.org/development/desa/ageing/wp-content/uploads/sites/24/2020/04/POLICY-BRIEF-ON-COVID19-AND-OLDER-PERSONS.pdf>
29. United Nations, Department of Economic and Social Affairs, Population Division (2020). World Population Ageing 2019 (ST/ESA/SER.A/444)
30. WHO, 'WHO Director-General's opening remarks at the media briefing on COVID-19 - 20 March 2020' (20 March 2020). <https://www.who.int/dg/speeches/detail/who-director-general-s-opening-remarks-at-the-media-briefing-on-covid-19---20-march-2020>
31. Ахмад настны тухай хууль. <https://www.legalinfo.mn/law/details/12453?lawid=12453>
32. Г.Өлзийхутаг 'ОХУ-аас илт эмнэл зүйн шинж тэмдэгтэй хүнийг явуулаагүй. Монголд ирэх замдаа халдвар авчихлаа гэх мэдээлэл худал' (iKon.mn, 20 May 2020). <https://ikon.mn/n/1vym>
33. Коронавируст халдвар /Ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийг баталж нийгмийн эрүүл мэндийг хамгаалах зорилгоор бусад хууль. <https://www.legalinfo.mn/law/details/15312?lawid=15312>
34. Эрүүл мэндийн яам '2020 оны 5 дугаар сарын 24-ний өдрийн нөхцөл байдлын мэдээ' (24 May 2020). <https://covid19.mohs.mn/p/cat/post/57/>



Д.БЯМБАЖАВ

Бодлогын Инновацийн
Хүрээлэнгийн захирал, доктор

ХҮНИЙ ЭРХЭД НӨЛӨӨЛӨХ БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭ ХИЙХ АРГА ЗҮЙ: ТАВАНТОЛГОЙН БҮЛЭГ ОРДЫН ҮНЭЛГЭЭНИЙ ТУРШЛАГА, СУРГАМЖ

A FRAMEWORK FOR CONDUCTING HUMAN RIGHTS IMPACT ASSESSMENT: LESSONS FROM AN ASSESSMENT OF TAVANTOLGOI MINES

Хураангуй: Энэ өгүүлэлд 2018 онд Тавантолгойн бүлэг ордыг ашиглах, нүүрс тээвэрлэх үйл ажиллагаатай холбоотой олон жилийн турш хуримтлагдсан болон шинээр үүссэн нөхцөл байдлын хүний эрхэд нөлөөлөх байдлын үнэлгээ (ХЭНБҮ) хийсэн үнэлсэн арга зүйг танилцууллаа. ХЭНБҮ нь нийгмийн нөлөөллийн үнэлгээний арга зүйг өргөнөөр ашигладаг боловч нийтээр хүлээн зөвшөөрсөн олон улсын хүний эрхийн стандарт, хэм хэмжээг мөрдлөг болгодог онцлогтой. Бид энэ зарчимд үндэслэн ХЭНБҮ хийх арга зүйн хүрээг тодорхойлж, түүний дагуу энэ үнэлгээ хийж, холбогдох дүгнэлт, зөвлөмжүүдийг оролцогч талуудад танилцуулж ажилласан. Бид үндэсний ба олон улсын хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулж үнэлгээний үр дүнг олон нийт, сонирхогч талуудад хүргэж тодорхой үр дүнд хүрсэн болно. Цаашид ХЭНБҮ-г уул уурхайн болон бусад томоохон бизнесийн төслүүдэд тогтмол хийх нь хүний эрхийн зөрчлөөс сэргийлэхэд ач холбогдолтой. Чингэхдээ ХЭНБҮ-г талуудын хооронд харилцан ойлголцох, хамтын шийдэлд хүрч хүний эрхийн зөрчлөөс сэргийлэх, хүний эрхийг ханган ажиллах механизм гэж ойлгох нь түүний ач холбогдол, хэрэглээг нэмэгдүүлэхэд чухал юм.

Түлхүүр үг: Хүний эрх, Хүний эрхэд нөлөөлөх байдлын үнэлгээ (ХЭНБҮ), уул уурхай, Тавантолгой.

Abstract: This article presents the framework for conducting an assessment of cumulative and emergent human rights impacts of Tavantolgoi's coal mines and coal transportation in 2018. Although social impact assessment frameworks are widely used in human rights assessments (HRIA) their main point of reference is universal human rights norms and standards. Accordingly, we developed a framework for conducting the Tavantolgoi's HRIA, implemented the assessment, and engaged in stakeholder consultation and policy advocacy. We disseminated the assessment findings to the Mongolian public and relevant stakeholders via international and national media channels and achieved significant policy outcomes. Conducting HRIAs of mining and large-scale projects on a regular basis can be an important mechanism for prevention of human rights violations. Understanding HRIAs as a mechanism for human rights protection and enhancement through informed dialogue is crucial in its broader application.

Keywords: Human rights, Human Rights Impact Assessment (HRIA), mining, Tavantolgoi.

I. Оршил

Энэхүү өгүүлэлд 2018 онд ХЭҮК, Бодлогын Инновацийн Хүрээлэнгийн хамтран хэрэгжүүлсэн Тавантолгойн бүлэг ордоос нүүрс олборлох, тээвэрлэх үйл ажиллагааны хүний эрхэд нөлөөлөх байдлын үнэлгээг хийхэд ашигласан арга зүйг танилцуулж, түүний сургамж, ХЭНБҮ-г цаашид боловсронгуй болгох арга замуудыг авч үзэхийг зорилоо¹.

II. Хүний эрхэд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай ойлголт

2011 оны 6 дугаар сарын 16-ны өдөр НҮБ-ын Хүний эрхийн зөвлөл “Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хамгаал, Хүндэл, Эрхийг Сэргээ хэмээх бодлогын хүрээг хэрэгжүүлэх Бизнес ба хүний эрхийн удирдах зарчим”-ыг баталсан юм. “Бизнес ба хүний эрхийн удирдах зарчим” нь бизнесийн үйл ажиллагаанд “Хүний эрхэд нөлөөлөх байдлын үнэлгээ” (цаашид ХЭНБҮ гэх) хийх суурь үзэл баримтлал болдог.

“Бизнес ба хүний эрхийн удирдах зарчим” нь үндсэн 3 тулгуур зарчмаас бүрддэг (UN Human Rights Council, 2011). Үүнд:

1

Энэхүү ХЭНБҮ хийх ажлыг Уул уурхайн салбар дахь байгаль орчин, хүний эрхийг хамгаалах хууль эрх зүйн орчин, хэрэгжилтийн тогтолцоог сайжруулан, талуудын олон талт хамтын оролцоог дэмжин, хариуцлагын механизмыг бэхжүүлснээр тус салбар дахь байгаль орчны засаглал, хяналтын тогтолцоо бэхжүүлэх зорилго бүхий НҮБ-ын Хөгжлийн Хөтөлбөр, Швед Улсын Байгаль орчны агентлагийн хамтран хэрэгжүүлдэг “Уул уурхайн салбар дахь байгаль орчны засаглал” төслийн хүрээнд гүйцэтгэсэн болно.

- **Нэгдүгээр зарчим-Хамгаал.** Төр нь зохистой бодлого, зохицуулалтаар дамжуулан хүний эрхийг гуравдагч талууд зөрчихөөс хамгаалах үүрэгтэй. Үүнд бизнесийн байгууллага хүний эрхийг зөрчихөөс хамгаалах үүрэг ч хамаарна.
- **Хоёрдугаар зарчим-Хүндэл.** Аж ахуйн нэгж, байгууллага нь хүний эрхийг хүндэтгэх үүрэг хүлээнэ. Энэ нь “үл хохироох” гэдэг зарчимд тулгуурлана. Аж ахуйн нэгж, байгууллага нь эрсдлийн судалгаа, нөлөөллийн үнэлгээ, хуулийг чанд мөрдөх зэрэг үйл ажиллагаагаар дамжуулан хүний эрхийг зөрчихөөс сэргийлэх ёстой. Аж ахуйн нэгж, байгууллага шууд бус байдлаар хүний эрхийг зөрчсөн үйл ажиллагаанд оролцох, хамааралтай байх нь энэ зарчимд харшилна.
- **Гуравдугаар зарчим-Эрхийг сэргээ.** Эрх нь зөрчигдсөн иргэд буюу хохирогчид эрхээ хамгаалах шүүхийн ба шүүхийн бус тогтолцоог бий болгох шаардлагатай. Төр нь хуулийн хүрээнд хохирсон иргэдийн эрхийг хамгаалах, хохирлыг барагдуулах, гэм буруутай этгээдэд шүүх болон захиргааны аргаар хариуцлага тооцох ажлыг хариуцах ёстой. Мөн төрийн зүгээс хохирсон иргэдэд мэдээллийн болон бусад шаардлагатай туслалцааг үзүүлэх тогтолцоог бий болгож, компаниудаас иргэдийн гомдлыг хэлэлцэх, хохирлыг барагдуулах үр дүнтэй механизмыг бий болгохыг шаардаж, хяналт тавих хэрэгтэй. Компаниуд иргэдийн гомдол, саналыг хүлээн авч, яриа хэлэлцээрийн зарчмаар шийдвэрлэх механизмтай байх шаардлагатай.

ХЭНБҮ нь тодорхой бодлого, хөтөлбөр, төсөл, үйл ажиллагааг хэрэгжүүлэх явцад хүний эрхэд үзүүлэх нөлөөллийг тодорхойлох үйл явц юм. ХЭНБҮ-ний гол зорилго нь нөлөөллийг тодорхойлж, гарч болзошгүй сөрөг нөлөөг бууруулах, арилгах арга замуудыг илрүүлж, тодорхойлох байдлаар хүний эрхийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх явдал юм (Harrison, 2010).

ХЭНБҮ нь дараах зарчимд үндэслэдэг. Үүнд:

- ХЭНБҮ нь нийтээр хүлээн зөвшөөрсөн олон улсын хүний эрхийн стандарт, хэм хэмжээг мөрдлөг болгох;
- Үнэлгээний үйл явцад оролцогч талуудын оролцоо, тэгш эрхийг хангах;
- Ил тод байдлыг хангах;

ХЭНБҮ нь тухайн төслийн хэрэгжилтийн өмнөх (ex ante), хэрэгжилтийн дараах (ex post), эсвэл хэрэгжилтийн явцад тус тус байж болно (Иргэний Шийдэл, 2015). Хэрэгжилтийн өмнөх буюу “Ex ante” үнэлгээ нь тухайн төслийн үйл ажиллагааг төлөвлөх, боловсруулах, холбогдох байгууллагаар батлуулах үйл явцын нэг хэсэг буюу үүсэж болзошгүй нөлөөллийг тодорхойлох явдал юм. Хэрэгжилтийн дараах буюу “Ex post” үнэлгээ нь төслийн үйл ажиллагааны

УИН.МН
СУДАЛГААНЫ САН

хэрэгжилтийн явцад болон дараа нь гарсан бодит нөлөөллийг илрүүлж, засаж сайжруулах арга замуудыг тодорхойлоход чиглэдэг.

ХЭНБҮ-г хөндлөнгийн ба дотоод гэж ангилж үзэж болно. Дотоод нөлөөллийн үнэлгээ нь тухайн байгууллагын дотоод мониторинг, үнэлгээний нэг хэсэг болон хэрэгждэг. Өөрөөр хэлбэл байгууллагын үйл ажиллагааны хэм хэмжээ, менежментийн тогтолцооны нэгэн бүрэлдэхүүн хэсэг болон хэрэгжинэ гэсэн үг юм. Энэ нь ex ante болон ex post үнэлгээг аль алиныг агуулж болно. Мөн хөндлөнгийн байгууллага, шинжээчид хийсэн гадаад үнэлгээ байж болно.

III. Тавантолгой ба хүний эрхийн тулгамдсан асуудал

Тавантолгойн нүүрсний бүлэг ордоос нүүрс олборлох, тээвэрлэх үйл ажиллагаа өнгөрсөн 10 гаруй жил огцом нэмэгдэж, түүний улмаас байгаль орчин, нийгмийн өргөн хүрээтэй, ноцтой нөлөөллүүд үүсч буйг олон улсын болон үндэсний байгууллагууд, судлаачид баримтад үндэслэн анхааруулж ирсэн байна. Тавантолгойн бүлэг ордоос БНХАУ руу экспортлох нүүрсний хэмжээ 2009-2012 онд асар хурдацтай нэмэгдсэн хэдий ч 2013 оноос БНХАУ-ын нүүрсний зах зээлийн үнэ, эрэлт буурснаар тус орд газраас экспорлох нүүрсний хэмжээ эргэн буурсан байдаг. Харин 2016 оны 2 дугаар сараас нүүрсний үнэ огцом өсч, экспортын хэмжээ жилд 25 сая тоннд хүрсэн бөгөөд үүний ихэнх нь Тавантолгойн бүлэг ордоос олборлосон нүүрс эзэлж байв. Улмаар 2017 онд Монгол Улсын нүүрсний экспорт улам бүр өссөөр жилд 33 сая тоннд хүрчээ².

Энэ бүс нутагт өрнөж буй уул уурхайн олборлолт ба нүүрс тээвэрлэлтийн үйл ажиллагааны байгаль орчин (агаарын бохирдол, тоосжилт, бэлчээр, хөрсний эвдрэл, усны нөөц, хангамж гэх мэт), нийгмийн (эрүүл мэнд, амьжиргаа, соёл, нийгмийн харилцаа, төрийн үйлчилгээ гэх мэт) нөлөөлөлтэй харилцан уялдаатайгаар хүний эрхэд үзүүлж буй шууд ба дам нөлөөллийг тодорхойлох зорилгоор энэ ХЭНБҮ-г хэрэгжүүлсэн билээ.

Нөлөөлөлд өртөгч талуудыг орон нутгийн иргэд, малчид, нүүрс тээврийн жолооч ба ажилтнууд гэсэн үндсэн бүлгийн хүрээнд авч үзсэн бол нөлөөлөл үзүүлэгч талуудыг уул уурхайн компаниуд, тэдгээрийн гэрээт туслан гүйцэтгэгчид, нүүрс тээврийн компаниуд, бусад холбогдох төрийн байгууллагуудын хүрээнд авч үзэв.

Энэхүү үнэлгээ нь хүний эрхэд үзүүлэх аливаа сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, түүнийг бууруулах арга хэмжээг талуудын оролцоо, зөвлөлдөх уулзалтуудын үндсэн дээр тодорхойлж, хамтарсан шийдэлд хүрэхэд туслан оролцох зарчим баримталж ажиллалаа.


Мөн үнэлгээний тайланг эцэслэн Өмнөговь аймгийн Засаг дарга, Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга, захиргааны албан хаагчид, иргэд, иргэний нийгмийн байгууллагууд, Тавантолгойн бүлэг ордод нүүрс олборлох, тээвэрлэх үйл ажиллагаа эрхэлж буй бизнесийн байгууллагууд зэрэг оролцогч талуудад танилцуулах, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар зөвлөлдөх зорилго бүхий олон талт уулзалт, хэлэлцүүлгийг 2018 оны 10 дугаар сарын 18-ны өдөр Өмнөговь аймгийн Засаг даргын Тамгын газрын байранд зохион байгууллаа.

Улмаар илэрсэн хүний эрхийн зөрчил, түүнээс гарах сөрөг нөлөөллийг бууруулах арга замыг тодорхойлсон зөвлөмж, шаардлагыг Монгол Улсын Ерөнхий сайд У.Хүрэлсүх, Өмнөговь аймгийн Засаг дарга Н.Наранбаатар нар болон Авто тээврийн үндэсний төв, Эрдэнэс Монгол ХХК, Эрдэнэс Тавантолгой ХК, Энержи Ресурс ХХК зэрэг бизнесийн байгууллагуудын удирдлагад хүргүүлж ажилласан юм. Тиймээс энэ үнэлгээнд судалгааны ажлын зэрэгцээ оролцогч талуудын зөвлөлдөх уулзалтуудыг зохион байгуулж, баримт, мэдээлэлд үндэслэсэн хамтарсан шийдлүүдийг тодорхойлох ажил чухал үүрэгтэй байв.

IV. Тавантолгойн ХЭНБҮ-г хийхэд ашигласан арга зүй

A. Арга зүйн 3 шат

Үнэлгээг хийх арга зүй үндсэн 3 шат буюу бүрдэл хэсэгтэй байв. Үүнд:




Үе шат тус бүрийг дараах хэсэгт танилцуулав.

1. Нэгдүгээр шат

Нөхцөл байдлын дүн шинжилгээ хийх: Тавантолгойн бүлэг ордоос нүүрс олборлох, тээвэрлэх үйл ажиллагаа, түүний байгаль орчин, нийгэм, хүний эрхэд үзүүлэх нөлөөллийн талаарх өмнөх судалгаа, мэдээлэл, шинжээчдийн байр суурьд дүн шинжилгээ хийх замаар оролцогч талууд, ялангуяа эрх нь хөндөгдсөн болон нөлөө үзүүлэгч талууд, нөлөөллийн цар хүрээ, холбогдох бодлого, арга хэмжээ зэрэг асуудлыг судлав.

Энэхүү үнэлгээг хийхэд чухал ач холбогдолтой нэлээд судалгааны ажлууд өмнө хийгдсэн нь хүний эрхийн нөлөөллийн хүрээг оновчтой тодорхойлох, бодлогын шийдлүүдийг боловсруулахад үр дүнтэй байлаа.



Хүний эрхийн дүн шинжилгээ хийх: Нөхцөл байдлын дүн шинжилгээнд тулгуурлан гол анхаарах хүний эрхийн асуудлыг тодорхойлов.

Хүснэгт 1. Хүний эрхийн олон улсын болон үндэсний эрх зүйн баримт бичгүүд дэх хэм хэмжээ

(Өнгөөр энэ үнэлгээний явцад анхаарч авч үзэх эрхүүдийг тэмдэглэв)

д/д	Хүний эрх	Хүний эрхийн түгээмэл тунхаглал (зүйл)	Иргэний болон улс төрийн эрхийн олон улсын пакт (зүйл)	Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн олон улсын пакт (зүйл)	Монгол Улсын Үндсэн хууль (заалт)
1	Амьд явах эрх	3	6		16.1
2	Эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрх				16.2
3	Эрх чөлөөтэй байх, халдашгүй дархан байх эрх	3	9		16.13
4	Боолчлогдох, бусдын эрхшээлд байх, албадан хөдөлмөрлөхөөс ангид байх эрх	4	8		16.4
5	Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхээс ангид байх эрх	5	7		16.13
6	Эрх зүйн чадвартай байх эрхээ хүлээн зөвшөөрүүлэх эрх	6	16		14
7	Хуулийн өмнө адил тэгш байх, ямар ч алагчлалгүйгээр хуулиар хамгаалуулах эрх	7	14, 26		14
8	Дайныг аливаа хэлбэрээр сурталчилсан, алагчлан дайсагналцах болон хүчирхийллийг өдөөн турхирдаг үндсэрхэх үзлээр, арьс үндсээр болон шашин шүтлэгээр үзэн ядах байдлыг дэмжсэн аливаа ухуулга сурталчилгаанаас ангид байх эрх		20		
9	Эрх нь зөрчигдвөл эрхээ бүрэн сэргээн тогтоолгох эрх	8	9		16.12

10	Хараат бус шүүхээр шударгаар шүүлгэх эрх	10	9, 14		16.14
11	Үйлдэл, эс үйлдэхүйг гэмт хэрэгт шинээр тооцсон, оногдуулах ялыг хүндрүүлсэн, гэмт хэрэг үйлдсэн этгээдийн эрх зүйн байдлыг дордуулсан хуулийг буцаан хэрэглэхээс ангид байх эрх	11	15		
12	Хэний ч хувийн болон гэр бүлийн амьдралд хөндлөнгөөс дур мэдэн оролцох, орон байрны халдашгүй байдал, захидал харилцааных нь нууцад халдахаас ангид байх эрх	12	17		16.13
13	Чөлөөтэй зорчих, оршин суух газраа чөлөөтэй сонгох эрх	13	12		16.18
14	Хэн боловч мөрдөлт мөшгилтөөс зугтаж, өөр улсад орогнох боломжийг эрэлхийлэх болон орогнох эрх	14			
15	Иргэний харьяалалтай байх эрх	15			15
16	Хүүхэд асрамж, туслалцаа авах эрх	25	10, 24	10	16.11
17	Гэрлэх, өрх тусгаарлах эрх	16	23	10	16.11
18	Эд хөрөнгө өмчлөх эрх	17			16.3
19	Чөлөөтэй бодож сэтгэх, шашин шүтэх, эс шүтэх эрх	18	18		16.15
20	Өөрийн үзэл бодолтой байх, түүнийгээ чөлөөтэй илэрхийлэх эрх	19	19		16.16
21	Тайван хуран цуглах эрх	20	21		16.16
22	Эвлэлдэн нэгдэх эрх	20	22		16.10
23	Улсаа удирдахад шууд буюу чөлөөтэй сонгосон төлөөлөгчдөөрөө уламжлан оролцох эрх	21	25		16.9
24	Нийгмийн хангамж эдлэх, нийгмийн даатгалд хамрагдах эрх	22		9	16.5
25	Хөдөлмөрлөх эрх	23		6	16.4
26	Хөдөлмөрийн шударга, аятай нөхцөлөөр хангуулах эрх	23		6, 7	

УИХ-ЫН
СҮДАЛГААНЫ САН

27	Үйлдвэрчний эвлэл байгуулах буюу үйлдвэрчний эвлэлд нэгдэх, ажил хаях эрх	23	22	8	
28	Эрүүл мэнд, аж амьдралыг тэтгэхэд хүрэлцэхүйц амьжиргаатай байх эрх	25		11	
29	Эрүүл мэндээ хамгаалуулах эрх	25			16.2, 16.6
30	Сурч боловсрох эрх	26		13	16.7
31	Нийгмийнхээ соёлын амьдралд чөлөөтэй оролцох, шинжлэх ухааны дэвшилд оролцож үр шимийг нь хүртэх эрхтэй, өөрийн туурвисан бүтээлийн материаллаг болон ёс суртахууны эрх ашгаа хамгаалуулах эрх	27		15	16.8
32	Өөрөө засан тохинох эрх			1	
33	Эрх чөлөөгөө хасуулсан хүний хүнлэг бус харьцаанаас ангид байх эрх		10		
34	Гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлж чадаагүйг үндэслэл болгон эрх чөлөөг хасуулахгүй байх эрх		11		
35	Гадаадын иргэний албадан гаргахыг эсэргүүцсэн үндэслэл шалтгаанаа танилцуулах, эрх бүхий байгууллага буюу түүнээс тусгайлан томилсон этгээд буюу этгээдүүдээр хэргээ дахин хянуулах эрх		13		
36	Угсаатан, шашны болон хэлний цөөнхөд багтдаг хүмүүсийн соёлоо баримтлах, шашнаа шүтэх, шашныхаа зан үйлийг үйлдэх, түүнчлэн эх хэлээрээ ярих эрх		27		
37	Өргөдөл, гомдлоо гаргаж шийдвэрлүүлэх эрх	8	9		16.12
38	Ундны ус болон ариун цэврийн байгууламжаар хангагдах хүний эрх	НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 2010 оны 7 дугаар сарын 28-ны өдрийн 64/292 дугаар тогтоол			

2. Хоёрдугаар шат

Мэдээлэл цуглуулах, дүн шинжилгээ хийх: Үнэлгээний баг Улаанбаатар хот, Өмнөговь аймгийн Даланзадгад, Цогтцэций, Ханбогд сумд, Гашуунсухайтын боомт, Цагаанхад, БНХАУ-ын Баяннуур аймгийн Ганц модны боомт зэрэг газарт байх нүүрс олборлох, тээвэрлэх үйл ажиллагаанд холбогдох төрийн байгууллага, хувийн хэвшил болон иргэд, жолооч нартай уулзаж, холбогдох дүрэм журам, тайлан, мэдээлэл зэрэг бичиг баримттай танилцах, удирдлага, ажилтнууд, нөлөөлөлд өртөгч талуудтай ганцаарчилсан болон бүлгийн ярилцлага хийж, судалгаа, үнэлгээний ажлаа хийв.

Хүснэгт 2. Мэдээлэл цуглуулсан арга ба эх сурвалж

Мэдээлэл цуглуулсан арга	Эх сурвалж
Хоёрдогч эх сурвалжийн тойм	Байгууллагын баримт бичгүүд Үнэлгээний тайлан, төлөвлөгөө Судалгаа, статистикийн мэдээлэл Хэвлэлийн нийтлэл, сурвалжилга Агаарын чанар ба бусад мониторингийн мэдээлэл
Ярилцлага	Орон нутгийн удирдлага, иргэдийн төлөөлөл, малчид, нүүрс тээврийн жолооч нар, төрийн байгууллагын ажилтнууд, аж ахуйн нэгжүүдийн удирдлага, ажилтнуудын төлөөлөл
Асуулга судалгаа	Цогтцэций сумын төв болон Цагаан-Овоо багийн иргэдийн төлөөлөл Нүүрс тээврийн жолооч нар
Бүлгийн ярилцлага	Эмэгтэйчүүд, Цагаан-Овоо багийн иргэд, ахлах сургуулийн сурагчид, төрийн албан хаагчид, хувиараа хөдөлмөр эрхлэгчид, жолооч нар
Ажиглалт	Цогтцэций сумын төв ба Цагаан-Овоо баг, Тавантолгойн уурхай, нүүрс тээврийн зам, түүний дагуух зогсоолууд, бэлчээр, Ханбогд сумын төв ба Жавхлант баг, Цагаан хадны гаалийн хяналтын бүс, Гашуунсухайт боомт, Ганц мод боомт
Цахим сүлжээн дэх мэдээллийн дүн шинжилгээ	Нүүрс тээврийн жолооч нарын Фэйсбүүк группын хүний эрхийн нөлөөлөлд холбогдох мэдээлэл, Гашуунсухайт авто зам болон бусад холбогдох байгууллагын цахим сүлжээн дэх мэдээлэл

Түүнчлэн үнэлгээний урьдчилсан дүнг оролцогч талуудаар хэлэлцүүлэх үеэр илэрхийлсэн санал, шүүмжид дүн шинжилгээ хийсэн.

3. Гуравдугаар шат

Мэдээллийн нарийвчилсан дүн шинжилгээнд үндэслэн сэдэвчилсэн асуудал тус бүрийн тухайд хүний эрхийн зөрчил, эрсдлийг тодорхойлж, нэн яаралтай арга хэмжээ авах шаардлагаар нь эрэмбэлж дараах аргачлалыг баримтлав.

Хөндөгдөж буй хүний эрх бүрт тайлбар, сэдэвчилсэн асуудал бүрт анхаарах шаардлагатай нөлөөлөгч хүчин зүйлс, нөлөөлөл, эрсдлийн талаарх дүгнэлт боловсрууллаа.

Хүснэгт 3. Нөлөөлөл, эрсдлийн талаарх дүгнэлтийн хуудас

Хүний эрхийн үндэсний ба олон улсын баримт бичгүүд дэх заалт	Хүний эрхийн Түгээмэл Тунхаглал	Иргэний болон улс төрийн эрхийн олон улсын пакт	Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн олон улсын пакт	Монгол Улсын Үндсэн хууль
Хөндөгдөж буй эрх:				
Тухайн эрхийн товч тайлбар				
Нөлөөлөл, эрсдлийн талаарх дүгнэлт				

Хөндөгдөж буй хүний эрхэд үзүүлж нөлөөллийн эрчим, анхаарч үзэх эрэмбийг тодорхойлох, ингэхдээ дараах шалгууруудын дагуу 1-3 хүртэлх оноогоор үнэлсэн. Ингэхдээ олон улсын хүний эрхийн байгууллагуудын аргачлал, сүүлийн үеийн судалгааны ажлуудын үр дүнг харьцуулж үзсэн (IPIECA, 2013, The Danish Institute for Human Rights, 2017, Gotzmann, 2017).

Н - Нөлөөллийн ноцтой байдал (1-3)

- (3) Хүний амь нас, эрүүл мэндэд ноцтой хохирол учруулахуйц
- (2) Хүний амьдралын суурь нөхцөл, хэрэгцээг хязгаарласан, өмч хөрөнгөд хохирол учруулсан
- (1) Бусад нөлөөлөл

Х - Нөлөөллийн хамрах хүрээ (1-3)

- (3) Нөлөөлөлд хамаарахуйц хүмүүсийн 50-иас дээш хувь
- (2) Нөлөөлөлд хамаарахуйц хүмүүсийн 10-50 хувь

(1) Нөлөөлөлд хамаарахуйц хүмүүсийн 10 хүртэлх хувь

С - Эрхийг сэргээх боломж (1-3)

(3) Бэрхшээлтэй: Зөрчигдсөн эрхийг сэргээж, эрх нь зөрчигдөхөөс өмнөх нөхцөл байдлыг бий болгоход олон хүчин зүйлээс хамаарах, эрхийг сэргээсэн гэж хүлээн зөвшөөрөхгүй байх магадлал их, хохирлыг нөхөн олгох, орлуулах боломж муу

(2) Харьцангуй бололцоотой: Зөрчигдсөн эрхийг сэргээж, эрх нь зөрчигдөхөөс өмнөх нөхцөл байдлыг бий болгох нь харьцангуй цөөн хүчин зүйлсээс хамаарах, эрхийг сэргээсэн гэж хүлээн зөвшөөрөх магадлалтай, хохирлыг нөхөн олгох, орлуулах боломж бий

(1) Хялбар: Зөрчигдсөн эрхийг сэргээж, эрх нь зөрчигдөхөөс өмнөх нөхцөл байдлыг бий болгох нь олон хүчин зүйлсээс хамаарахгүй, эрхийг сэргээсэн гэж хүлээн зөвшөөрөх өндөр магадлалтай, хохирлыг нөхөн олгох, орлуулах боломж ихтэй

М - Эрхийн зөрчил ойрын хугацаанд дахин үүсэх магадлал (1-3)

(3) Эрхийн зөрчил давтагдах магадлал өндөр

(2) Эрхийн зөрчил давтагдах магадлал дунд

(1) Эрхийн зөрчил давтагдах магадлал бага

Хүснэгт 4. Хөндөгдөж буй эрхүүдийн эрэмбэ

Эрэмбэ	Хөндөгдөж буй эрхүүд	Н	Х	С	М
I					
II					
III					
IV					

Сэдэвчилсэн асуудал тус бүрээр болон үнэлгээний ерөнхий дүгнэлт, зөвлөмжийг үнэлгээний багийнхан боловсрууллаа.

Нэгдүгээрт нөлөөлөгч хүчин зүйлс, үйл ажиллагаа, эрсдлийн талаарх дүгнэлт хийв. Тавантолгой орчмын малчдын эрхэд нөлөөлөх байдлын үнэлгээгээр тодорхойлсон нөлөөлөл, эрсдлийн талаарх дүгнэлт, нөлөөллийн эрэмбийг жишээ болгон танилцуулья.

Хүснэгт 5. Нөлөөлөл, эрсдлийн талаарх дүгнэлтийн жишээ

Хөндөгдөж буй эрх: Эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрх				
Хүний эрхийн үндэсний ба олон улсын баримт бичгүүд дэх заалт	Хүний эрхийн Түгээмэл Тунхаглал	Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт	Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын пакт	Монгол Улсын Үндсэн хууль
				16.2 дахь заалт
Тухайн эрхийн товч тайлбар				
<p>Эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрх нь хүмүүс өдөр тутмын амьдралдаа амь бие, эрүүл мэнддээ халтай аливаа нөлөөлөлд өртөхгүй байх, түүнээс ангид байх боломжийг хэлнэ. Орчны бохирдол гэдэгт агаарын, усны, хөрсний гэх мэт органик бохирдлоос гадна дуу чимээний, хог хаягдлын, гэрлийн гэх мэт хүний үйл ажиллагаанаас үүдэлтэй органик бус бохирдлыг хамааруулдаг.</p>				
Нөлөөлөл, эрсдлийн талаарх дүгнэлт				
<p>Эрдэнэс Тавантолгойн Цанхийн уурхайн эдэлбэр газрын тойруулан ухсан суваг шуудуу нь бороо хуртай үед усаар дүүрч, түүнээс ус уухаар очсон мал унах, шаварт шигдэх байдлаар үхэх, гэмтэх тохиолдол гарч байна.</p> <p>Уурхайн орчимд олон тооны эзэнтэй, эзэнгүй нохой байдаг нь малчдад эрүүл мэнд, эд хөрөнгийн эрсдэл учруулж байна. Зам дагуух хөрсний эвдрэл, тоосжилт, мал дайрагдах, жолооч нар зориулалтын бус замаар явах, худаг усны орчим хөрс эвдэх, бохирдуулах асуудал гарч байна.</p>				

Хөндөгдөж буй эрх: Ундны ус болон ариун цэврийн байгууламжаар хангагдах хүний эрх	
Хүний эрхийн үндэсний ба олон улсын баримт бичгүүд дэх заалт	НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 2010 оны 7 дугаар сарын 28-ны өдрийн 64/292 дугаар тогтоол
Тухайн эрхийн товч тайлбар	
<p>Хүн бүр хангалттай хэмжээнд, аюулгүй, бие махбодийн хувьд хүртэх боломжтой усыг хүртээмжтэй байдлаар хувийн болон гэр бүлийнхээ хэрэгцээнд хэрэглэх эрх юм.</p>	
Нөлөөлөл, эрсдлийн талаарх дүгнэлт	
<p>Улаан нуур нь ухсан хонхор, нүх, овоолго, олборлолт зэрэг уул уурхайн үйл ажиллагааны улмаас 22 сайрын 10 сайрын ус хурах талбай эвдрэлд өртөж, Цанхын уурхайн хөрсний овоолго Улаан нуурын уурхайн талаас ирэх тэжээгдлийн урсацыг хааж шууд нөлөөлсөн байна. Үндэсний статистикийн хорооны мэдээллээр Өмнөговь аймгийн зүүн бүсийн ихэнх сумдын хувьд худгуудын тоо нэмэгдсэн бол Цогтцэций сумын хэмжээнд малчдын худгийн тоо сүүлийн жилүүдэд огцом буурсан байна.</p>	

Хөндөгдөж буй эрх: Эд хөрөнгө өмчлөх эрх				
Хүний эрхийн үндэсний ба олон улсын баримт бичгүүд дэх заалт	Хүний эрхийн Түгээмэл Тунхаглал	Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт	Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын пакт	Монгол Улсын Үндсэн хууль
	17 дугаар зүйл			16.3 дахь заалт
Тухайн эрхийн товч тайлбар				
Хүн бүр хөдлөх, үл хөдлөх хөрөнгө шударгаар олж авах, эзэмших, өмчлөх, өв залгамжлуулах эрхтэй. Хувийн өмчийг хууль бусаар хураах, дайчлан авахыг хориглоно. Төр, түүний эрх бүхий байгууллага нь нийгмийн зайлшгүй хэрэгцээг үндэслэн хувийн өмчийн эд хөрөнгийг дайчлан авбал нөхөх олговор, үнийг төлөх ёстой.				
Нөлөөлөл, эрсдлийн талаарх дүгнэлт				
2010 онд Цанхийн уурхайн нөлөөлөлд өртсөн 15 айл бүгд уурхайн тоос, дуу чимээ, хөрсний эвдрэлийн нөлөөллөөс холдон, өвөлжөө, хаваржаагаа орхин нүүсэн байдалтай байна. Нүүрс тээврийн жолооч нар зам дагуух малчдын худгаас ундны болон ахуйн зориулалтаар ус авдаг байна. Ингэхдээ малчдын худгийг эвддэг, худгийн хажууд машинаа угаадаг байна.				

Хөндөгдөж буй эрх: Өргөдөл, гомдлоо гаргаж шийдвэрлүүлэх эрх				
Хүний эрхийн үндэсний ба олон улсын баримт бичгүүд дэх заалт	Хүний эрхийн Түгээмэл Тунхаглал	Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт	Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын пакт	Монгол Улсын Үндсэн хууль
				16.12 дахь заалт
Тухайн эрхийн товч тайлбар				
Аливаа хүн төр, нийгмийн болон иргэдийн нийтлэг эрх ашигт хохирол учруулахаар оршин байгаа зөрчил, дутагдлыг арилгуулах буюу нийгмийн хэв журам, хууль зөрчсөн асуудлын талаар, мөн өөрийн болон бусдын эрх, эрх чөлөө зөрчигдсэн тохиолдолд өргөдөл гаргах эрхтэй, нөгөө талаас уг гомдол, өргөдлийг шийдвэрлэх, хариу өгөх үүргийг төрийн байгууллага, албан тушаалтан хуулиар хүлээдэг.				
Нөлөөлөл, эрсдлийн талаарх дүгнэлт				
Төрийн өмчит компани түрэмгийлсэн байдлаар малчдад ханддаг, малчид энэ компаниас биет ба биет бус нөлөөллийн нөхөн олговор, дэмжлэг туслалцаа авах боломжгүй гэдэг цөхөрсөн хандлага давамгайлж байна. Малчид малаа дайруулсан тохиолдолд хэнд хаана хандахаа мэдэхгүйгээр хохирч үлддэг.				

Хөндөгдөж буй эрх: Өөрийн үзэл бодолтой байх, түүнийгээ чөлөөтэй илэрхийлэх, мэдээлэл авах эрх				
Хүний эрхийн үндэсний ба олон улсын баримт бичгүүд дэх заалт	Хүний эрхийн Түгээмэл Тунхаглал	Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт	Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын пакт	Монгол Улсын Үндсэн хууль
	19 дүгээр зүйл	19 дүгээр зүйл		16.16 дахь заалт
Тухайн эрхийн товч тайлбар				
Энэ эрхэнд төрөл бүрийн мэдээлэл болон үзэл санааг улсын хил хязгаарыг үл харгалзан амаар, бичгээр эсхүл хэвлэлийн буюу уран сайхны аргаар эсхүл өөрийн сонгосон бусад аргаар эрж хайх, хүлээн авах, түгээх эрх чөлөө багтана.				
Нөлөөлөл, эрсдлийн талаарх дүгнэлт				
Өнөөгийн байдлаар энэ бүс нутагт хамгийн их ус ашиглаж буй Энержи Ресурс компанийн Нүүрс угаах үйлдвэрийн газрын доорх ус ашиглалт, түүнээс орчмын усны хүртээмжид үзүүлж буй нөлөөллийн талаарх мэдээлэл дутмаг байна. Эрдэнэс Тавантолгой компани нөлөөллийн бүс дэх малчдын худгийн усны түвшин, усны чанарын хяналт шинжилгээ хийдэг боловч хэмжилт хийх тогтсон цаг байдаггүй, иргэдийн оролцоо байхгүй, иргэдэд эргэж мэдээлэл өгдөггүй байна.				

Хоёрдугаарт хөндөгдөж буй хүний эрхэд үзүүлж нөлөөллийн эрчим, эрэмбийг дараах аргачлалаар тодорхойлов.

Хүснэгт 6. Хөндөгдөж буй эрхүүдийг эрэмбэлсэн жишээ

Эрэмбэ	Хөндөгдөж буй эрхүүд	Н	Х	С	М
I	Эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрх	2	3	2	3
	Мэдээлэл авах эрх	1	3	2	3
II	Ундны ус болон ариун цэврийн байгууламжаар хангагдах хүний эрх	1	3	2	2
	Өргөдөл, гомдлоо гаргаж шийдвэрлүүлэх эрх	2	1	3	2
	Эд хөрөнгө өмчлөх эрх	2	1	2	2

Дараах шалгуурын дагуу 1-3 хүртэлх эрэмбээр үнэлсэн болно.

Н - Нөлөөллийн ноцтой байдал (1-3)

Х - Нөлөөлийн хамрах хүрээ (1-3)

С - Эрхийг сэргээх боломж (1-3)

М - Эрхийн зөрчил ойрын хугацаанд дахин үүсэх магадлал (1-3)

Гуравдугаарт нэгдсэн болон сэдэвчилсэн асуудал тус бүрээр дүгнэлт боловсруулж, бодлогын зөвлөмжийг танилцуулав. Эдгээр зөвлөмж нь уг үнэлгээний явцад талуудын илэрхийлсэн санал, өмнө хийгдэж ирсэн ажлуудын амжилт болон дутагдалтай тал, олон улсын ба орон нутгийн ижил төстэй туршлага, судлаачдын мэдлэг туршлага зэрэг олон эх сурвалжийг дүгнэн авч үзсэн үр дүн байлаа.

Б. Үнэлгээний үр дүн

Энэ үнэлгээний үр дүнд Монгол Улсын Засгийн газар, холбогдох яамд, уул уурхайн компаниуд, орон нутгийн удирдлагын зүгээс тодорхой арга хэмжээг авч хэрэгжүүлсэн билээ. Тухайлбал “Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн нүүрс тээвэрлэлтэд үүсч байгаа хүндрэлтэй асуудлыг шийдвэрлэх тухай” Засгийн газрын 2019 оны 4 дүгээр сарын 17-ны өдрийн хуралдаанаас гаргасан 1 дүгээр албан даалгаврын дагуу жолооч нарыг эрүүл мэнд, нийгмийн даатгалд хамруулж, тээврийн замд амрах ариун цэврийн үйлчилгээ үзүүлэх, эрүүл мэндийн үзлэгт орох боломжоор хангах, шаардлага хангасан хоол хүнсээр үйлчлэх нөхцлийг бий болгох ажлыг эхлүүлсэн байна. Улмаар Монгол Улсын Засгийн газраас Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замыг богино хугацаанд барьж ашиглалтад оруулах ажил эхэлсэн, Цогтцэций сум орчмын авто замын ажлууд хийгдсэн, Авто тээврийн үндэсний төвөөс хяналт тавьж ажиллах байцаагчдынхаа тоог нэмэгдүүлснээр жолооч нарын бичиг баримтын зөрчил буурч, хуурамч үнэмлэхтэй, мэргэжлийн ур чадвар сул, туршлага багатай жолооч нар хууль бус тээвэрлэлт хийх явдал буурсан эерэг үр дүнгүүд гарсан.

Хүний эрхийн Үндэсний Комисс нь тухайн жилийн хүний эрхийн төлөв байдлыг тодорхойлон Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх илтгэлийг жил бүр УИХ-д өргөн барьдаг. 2018 оны ээлжит илтгэлд ХЭНБҮ хүрээнд хийсэн хяналт шалгалт, судалгаанд үндэслэн “Эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрх: Байгаль орчны хууль тогтоомжийн хэрэгжилт ба иргэдийн оролцоо”, “Нийслэлийн хот төлөвлөлттэй холбоотой хүний эрхийн зарим асуудал” 2 бүлгийг боловсруулж, УИХ-аас шийдвэр гаргуулахаар 6 саналыг хүргүүлжээ.

Илтгэлийг 2019 оны 5 дугаар сарын 17-ны өдрийн УИХ-ын чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцээд “Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх илтгэлийг хэлэлцсэнтэй холбогдуулан авах арга хэмжээний тухай” УИХ-ын 2019 оны 62 дугаар тогтоолыг баталсан. Үүний үр дүнд **Тогтоолын 1.3.а хэсэг:** эрүүл, аюулгүй орчинд амьдрах, орчны бохирдол, байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалуулах эрх, агаар, ус, хөрсний бохирдлыг арилгах, хот, суурин газрыг дахин хөгжүүлэх, дэд бүтцийн чиглэлээр баталсан хууль тогтоомжийн хэрэгжилтэд дүн шинжилгээ хийж, зохих арга хэмжээг авах; **Тогтоолын 1.3.б хэсэг:** ашигт малтмал хайх, ашиглах явцад эвдэрсэн газрыг нөхөн сэргээх стандартын дагуу хүний аюулгүй байдал болон хүрээлэн

байгаа орчинд үзүүлдэг сөрөг нөлөөллийг багасгаж, уул уурхайн хаалт, нөхөн сэргээлтийн ажлыг олон улсын жишигт нийцүүлэх, эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох зэрэг асуудлыг Засгийн газарт даалгасан нь бодлого, хууль зүйн шинжилгээний нөлөөллийн томоохон ажил болсон юм.

V. Дүгнэлт

Энэ өгүүлэлд 2018 онд Тавантолгойн бүлэг ордыг ашиглах, нүүрс тээвэрлэх үйл ажиллагаатай холбоотой олон жилийн турш хуримтлагдсан болон шинээр үүссэн хүний эрхийн нөхцөл байдлыг авч үзсэн, ХЭНБҮ хийсэн арга зүйг танилцууллаа. ХЭНБҮ нь нийгмийн нөлөөллийн үнэлгээний арга зүйг өргөнөөр ашигладаг боловч нийтээр хүлээн зөвшөөрсөн олон улсын хүний эрхийн стандарт, хэм хэмжээг мөрдлөг болгодог онцлогтой. Бид энэ зарчимд үндэслэн ХЭНБҮ хийх арга зүйн хүрээг тодорхойлж, түүний дагуу энэ үнэлгээ хийж, холбогдох дүгнэлт, зөвлөмжүүдийг оролцогч талуудад танилцуулж ажилласан. Бид үндэсний ба олон улсын хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулж үнэлгээний үр дүнг олон нийт, сонирхогч талуудад хүргэж тодорхой үр дүнд хүрсэн болно.

Дээрх үнэлгээнд үндэслэн цаашид ХЭНБҮ хийхэд арга зүйн хүрээг баримтлах, асуудлын онцлогоос хамааруулж уян хатан байдлаар боловсронгуй болгох нь үр дүнтэй юм. Үүнд:

- **Нөхцөл байдлын дүн шинжилгээ хийх:** Тухайн асуудлын талаарх өмнөх судалгаа, мэдээлэл, шинжээчдийн байр суурьд дүн шинжилгээ хийх замаар оролцогч талууд, ялангуяа эрх нь хөндөгдсөн болон нөлөө үзүүлэгч талууд, нөлөөллийн цар хүрээ, холбогдох бодлого, арга хэмжээ зэрэг асуудлыг судлах;
- **Хүний эрхийн дүн шинжилгээ хийх:** Нөхцөл байдлын дүн шинжилгээнд тулгуурлан гол анхаарах хүний эрхийн асуудлуудыг тодорхойлох;
- **Мэдээлэл цуглуулах, дүн шинжилгээ хийх:** Мэдээллийн олон эх сурвалжуудыг ашиглах, үүнд тоон ба чанарын, нийгмийн, газарзүйн, статистик, дуу дүрс зэрэг мэдээллийг хослуулах, харьцуулах, баримтжуулах, нягтлах;
- **Мэдээллийн нарийвчилсан дүн шинжилгээ хийх:** Нарийвчилсан дүн шинжилгээнд үндэслэн сэдэвчилсэн асуудал тус бүрийн тухайд хүний эрхийн зөрчил, эрсдлийг тодорхойлж, нэн яаралтай арга хэмжээ авах шаардлагаар нь эрэмблэх;

ХЭНБҮ хийхэд оролцогч талуудын оролцоо, тэгш эрхийг хангах, үнэлгээний явц, үр дүнгийн ил тод байдлыг хангах нь маш чухал юм. Үнэлгээг гол төлөв багаар хийх учраас багийн гишүүдийн хүний эрх, түүнийг үнэлэх тухай мэдлэг, чадварыг анхаарч үзэх нь чухал байдаг.

ХЭНБҮ-ний тайлан, дүгнэлт олон төрлийн эх сурвалжид тулгуурласан баримттай, эерэг ба сөрөг нөлөөллийг тодорхой хэмжсэн, асуудлын ач холбогдол, эрэмбэ, бодлогын шийдлийг тусгасан байх нь практик үр дүнтэй болно. Үнэлгээний дүгнэлт болон зөвлөмжүүд нь хууль эрх зүй, шинжлэх ухааны нарийн мэргэжлийн хэллэг ашиглаагүй, олон нийтэд ойлгомжтой, тодорхой байх нь үр дүнтэй.

Цаашид ХЭНБҮ-г уул уурхайн болон бусад томоохон бизнесийн төслийн үйл ажиллагаанд тогтмол хийх нь хүний эрхийн зөрчлөөс сэргийлэх, оролцогч талуудын хооронд зөвшилцөл бий болгох ач холбогдолтой. ХЭНБҮ-г талуудын хооронд харилцан ойлголцох, хамтын шийдэлд хүрч хүний эрхийн зөрчлөөс сэргийлэх, хүний эрхийг ханган ажиллах механизм гэж ойлгох нь төр, хувийн хэвшил, иргэний нийгмийн зүгээс түүний ач холбогдлыг илүү ухаарах, өргөнөөр хэрэглэж хэвшихэд чухал юм.

Судлаачдын зүгээс ХЭНБҮ хийх үе шат, нөлөөллийг хэмжих, эрэмбэ тогтоох шалгуурууд, давтан үнэлгээ хийх, харьцуулах зэрэг арга зүйн асуудлаар яриа хэлэлцүүлэг өрнүүлэх замаар ХЭНБҮ-г улам үр дүнтэй болгох шаардлагатай.

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

НОМ ЗҮЙ

I. Монгол эх сурвалж

Д.Бямбажав, Ж.Мэндээ, Ө.Пүрэвсүрэн "Тавантолгойн бүлэг ордын нүүрс олборлох, тээвэрлэх үйл ажиллагааны хүний эрхэд нөлөөлөх байдлын үнэлгээ", Бодлогын Инновацийн Хүрээлэн, ХЭҮК, НҮБХХ, УБ, (2018).

Иргэний Шийдэл. "Хүний Эрхэд Нөлөөлөх Байдлын Үнэлгээ: Үзэл баримтлал, туршлага, хэрэгцээ", Хүний эрх сэтгүүл, 2015/01, 5-15 дугаар хуудас.

II. Гадаад эх сурвалж

Harrison, James. "Measuring Human Rights: Reflections on the Practice of Human Rights Impact Assessment and Lessons for the Future." Warwick Law School Legal Studies Research Paper. 2010, Vol. 26.

IPIECA. Integrating human rights into environmental, social and health impact assessments A practical guide for the oil and gas industry. 2013.

Gotzmann, Nora. Human Rights Impact Assessment of Business Activities: Key Criteria for Establishing a Meaningful Practice. Business and Human Rights Journal. 2017 Volume 2, Issue 1. pp. 87-108.

Nomogaia, Human Rights Impact Assessment: A Toolkit for Practitioners Conducting Corporate HRIAs. 2012.

The Danish Institute for Human Rights. Human rights impact assessment guidance and toolbox. 2017.

UN Human Rights Council, "Guiding Principles on Business and Human Rights: Implementing the United Nations 'Protect, Respect and Remedy' Framework" 2011.

ОИН.МН
СУДАЛГААНЫ САН



Г.ГАНБАЯСГАХ

“Хүйсийн тэгш эрхийн төв”
ТББ-ын тэргүүн



Э.ХИШИГБАЯР

“Хүйсийн тэгш эрхийн төв” ТББ-ын
хөтөлбөрийн зохицуулагч

БИЕЭ ҮНЭЛЭЛТ, БЭЛГИЙН МӨЛЖЛӨГИЙН ТАЛААРХ ОЛОН НИЙТИЙН ҮЗЭЛ ХАНДЛАГА, ТУЛГАМДАЖ БУЙ АСУУДАЛ

PUBLIC PERCEPTION ABOUT PROSTITUTION AND SEXUAL EXPLOITATION AND PRESSING ISSUES

Хураангуй: Нийгэмд биеэ үнэлэгчдийг худалдан авч буй этгээд болон энэ худалдаагаар ашиг олж буй гэмт этгээдийн талаар төдийлөн асуудал болгон ярьдаггүй хэр нь биеэ үнэлэгч охид, эмэгтэйчүүдийг буруутгах, сөрөг байр сууринаас хандах, гэмт хэрэгтнүүдийг шийтгэхээсээ илүүтэй биеэ үнэлэгчдэд хуулийн хариуцлага тооцох тохиолдол байна. Гэтэл биеэ үнэлэлт болон бэлгийн мөлжлөгийн золиос болсон охид, эмэгтэйчүүдийн дийлэнх нь бага насандаа гэр бүлийн болон бэлгийн хүчирхийлэл, хүчингийн гэмт хэргийн золиос болсон байдаг. Мөн тэднийг худалдан авагчид “сексийн үйлчилгээ” худалдан авсан бус хүнийг нь худалдан авсан мэтээр аашилж, зодох, дээрэмдэх, хүчиндэх зэрэг ёс бус үйлдэл хийж хүний эрхийг зөрчиж байна. Иймээс биеэ үнэлж буй охид, эмэгтэйчүүдийг сайн дураараа энэ ажлыг хийж байгаа гэдэгт анхаарал хандуулахаасаа илүүтэй тэдний эрхийг хамгаалах, туслалцаа, үйлчилгээ үзүүлэхээс гадна энэ гэмт хэргийг үйлдэж буй этгээд, худалдан авагчидтай тэмцэх, мөн энэ асуудлаар олон нийтийн ойлголт мэдлэг, үзэл хандлагад нөлөөлөх шаардлагатай талаарх асуудлыг энэхүү илтгэлд хөндсөн болно.

Түлхүүр үг: Хүн худалдаалах гэмт хэрэг, бэлгийн мөлжлөг, биеэ үнэлэлт, хохирогч, олон нийт.

Summary: *The society does not focus much on clients of sex trade and sex trafficking and the criminals who profit from sex trade, but instead there is strong focus on women and girls who are engaged in sex trade and victims of sex trafficking, with an overall attitude of blaming women, treating them negatively and prosecuting them rather than perpetrators and criminals. The majority of girls and women who became victims of prostitution and sexual exploitation had been victims of domestic and sexual violence and rape at an early age and had not been psychologically rehabilitated, making it easier for criminals to “capture” them. Buyers also violate human rights of these women and girls by behaving as if they had bought a person, not sex service, so they beat, rob, and rape women. Therefore, this report is addressing the need to identify the causes, protect the violated rights, and provide assistance and services. Also, the report is stressing out that there is a need to fight the perpetrators and buyers, instead of sex workers, and to influence public awareness and attitudes on this issue.*

Keywords: *Human trafficking, sexual exploitation, prostitution, victim and the public.*

Нэг. Биеэ үнэлэлт, бэлгийн мөлжлөгийн талаарх олон нийтийн үзэл хандлага

Олон улсын хөдөлмөрийн байгууллагаас 2014 онд хийсэн судалгаагаар дэлхий дээр ойролцоогоор 21 сая хүн хөдөлмөр мөлжлөг болон боолчлолын золиос болж байгаа нь тогтоогдсон байна. Гэтэл нийгмийн байдлын талаар судалгаа хийдэг бусад эрдэмтэн судлаачид энэ тоог ойролцоогоор 27 сая гэж тогтоогоод байна¹. Эдгээр хүмүүсийн 70-80 хувь нь эмэгтэйчүүд, 50 орчим хувь нь хүүхэд байгаа талаар дээрх судалгаануудад онцлон тэмдэглэжээ². Боолчлогдож, хөдөлмөр мөлжлөгт өртөж байгаа эмэгтэйчүүдийн дийлэнх нь биеэ үнэлэх болон бусдын бэлгийн хэрэгцээг хангах зорилгоор зарагдаж байгаа бөгөөд тэдний дундаж нас нь 12-14 байгаа талаар судалгаанд мөн дурдсан байна³.

Биеэ үнэлэлт болон бэлгийн мөлжлөгийн золиос болсон охид, эмэгтэйчүүд нь ихэвчлэн хүүхэд байхдаа хулгайлагдаж, хүчин, ураг төрлийн бэлгийн хүчирхийлэл, бие махбодын болон бэлгийн хүчирхийлэлд өртөж байжээ. Бэлгийн мөлжлөгийн улмаас биеэ үнэлж байсан болон хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч болсон хүүхэд, эмэгтэйчүүдийн дийлэнх нь гэмтлийн дараах

1 АНУ-ын Төрийн Департамент, Хүн худалдаалах асуудлын нөхцөл байдлын тайлан, 2013 он.
<https://2009-2017.state.gov/j/tip/rls/tiprpt/2013//index.htm>

2 АНУ-ын Төрийн Департамент, Хүн худалдаалах асуудлын нөхцөл байдлын тайлан, 2014 он.
<https://2009-2017.state.gov/j/tip/rls/tiprpt/2014//index.htm>

3 *Public Attitudes Toward Prostitution and Sex Trafficking Awareness*, St. Catherine University of St. Thomas Abas, Katelyn E. Nichols, 2015 (Estes, & Weiner, 2001).

сэтгэл гутрал, сэтгэл санааны хямрал, сэтгэлийн түгшүүрт өртдөг бөгөөд энэ байдлаа даван гарахын тулд төрөл бүрийн тайвшруулах эмийн хамааралд ордог болох нь судалгаагаар тогтоогдсон⁴. Улмаар биеэ үнэлж байсан хохирогчдын дийлэнх олонх нь амиа хорлох, бусдад хорлогдох, түүнчлэн ХДХВ/ДОХ болон бусад бэлгийн замын халдварт өвчнөөр шаналж байдаг ажээ⁵.

Өнөө үед бэлгийн мөлжлөгийн гэмт хэрэг нь жил ирэх тутам өсөх хандлагатай байгаа бөгөөд энэ нь цаашлаад хүний эрхийг ноцтой зөрчсөн үйлдэл учраас энэ асуудлыг онцгойлон анхаарч үзэх нь чухал байна. Хүний наймаачид нь ашиг олохын тулд эмзэг бүлгийн иргэдийг илүүтэйгээр онилж, тэдэнд албадлага болон хүч хэрэглэх замаар хохирогчдын нэр хүндэд хэрцгийгээр халддаг. Ингэснээр тус гэмт хэргийн хохирогчид бусдын ашиг тусын тулд бие махбодын болон сэтгэлзүйн дарамтад ордог.

Бодит байдал дээр олон нийтийн дийлэнх нь биеэ үнэлэлт, бэлгийн мөлжлөгийн асуудлаар хангалтгүй ойлголттой байгаа бөгөөд хохирогчийг сайн дураараа энэ ажлыг хийж байгаа, амар хялбар аргаар амьдарч буй мэтээр буруутгадаг үзэл хандлага тэдний дунд байсаар байна.

Олон нийтийн санал сэтгэгдэл, тухайн асуудалд хандаж буй хандлага нь төрийн бодлогыг өөрчлөхөд ихээхэн нөлөө үзүүлдэг тул юуны өмнө биеэ үнэлэлт болон бэлгийн мөлжлөгийн талаарх тэдний үзэл, хандлага ямар болохыг олж тогтоох, тодруулах, тэдэнд энэ асуудлаар бодит мэдлэг, ойлголт өгөх хэрэгтэй байгаа юм.

Ингэснээр биеэ үнэлэлт болон бэлгийн мөлжлөгтэй холбоотой олон нийтийн хандлагыг хэрхэн дээшлүүлэх, үүнтэй холбогдуулан төрийн бодлогыг хэрхэн улам илүү үр дүнтэй, уян хатан болгож, эрэлтийг хэрхэн бууруулах боломжтой вэ? гэдгийг тодорхойлох боломжтой болно.

Хоёр: Монгол Улсын хүн худалдаалах гэмт хэрэг, биеэ үнэлэлттэй холбоотой асуудлаарх хууль эрх зүйн зохицуулалт, тулгамдаж буй асуудал

Дэлхий даяар хүний наймаатай тэмцэх, хохирогчдод туслалцаа үзүүлэх зорилгоор батлагдсан НҮБ-ын Палермо протоколыг⁶ 2019 оны 3 дугаар сарын 31-ний байдлаар 173 улс орон соёрхон баталж,

4 *Public Attitudes Toward Prostitution and Sex Trafficking Awareness, St. Catherine University of St. Thomas Abas, Katelyn E. Nichols, 2015 (Light, & Watts, 2010).*

5 *Public Attitudes Toward Prostitution and Sex Trafficking Awareness, St. Catherine University of St. Thomas Abas, Katelyn E. Nichols 2015, (Light, & Watts, 2010).*

6 *НҮБ-ын Ерөнхий Ассамблейгаас 2000 оны 11 дүгээр сарын 15-ны өдөр баталсан “Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг конвенц, түүний нэмэлт болох хүн, ялангуяа эмэгтэйчүүд, хүүхэд худалдаалахаас урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, шийтгэх тухай протокол”.*

168 улс хүний наймааны гэмт хэрэгтэй тэмцэх дотоодын хууль тогтоомжийг баталсан байна⁷.

Албан ёсоор мэдэгдэж байгаагаар 2001 онд хүн худалдаалах гэмт хэргийн 1 гаралт бүртгэгдэж байсан бол 2018 оны байдлаар цагдаагийн байгууллагад 160 гаруй хэрэг бүртгэгдэж, шалгагдсан ч шүүхээс 26 хэрэгт л ял шийтгэл оногдуулжээ. Гэвч энэ нь бодит байдлыг харуулсан тоо биш юм. “Хүйсийн тэгш эрхийн төв” ТББ 2003 онд хүний наймааны 3 хохирогчид туслалцаа үзүүлж байсан бол 2003-2019 оны байдлаар туслалцаа үзүүлсэн хохирогчийн тоо 749 болжээ.

Монгол Улс хүн худалдаалах гэмт хэргийн эсрэг олон улсын гэрээнүүдэд нэгдэн орсноор уг гэмт хэрэгтэй тууштай тэмцэх үүргийг дэлхийн хамтын нийгэмлэгийн өмнө хүлээсэн бөгөөд хүний наймаанд өртөх өндөр эрсдэлтэй орны тоонд багтаж буйн хувьд ийм төрлийн гэмт хэргийг илрүүлэх, таслан зогсоох, урьдчилан сэргийлэх ажлыг төрийн хууль тогтоох бодлогын хүрээнд зохицуулж, тодорхой алхмуудыг хийж эхлээд цөөнгүй жилийг үдэж байгаа ч хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх, таслан зогсоох нь тулгамдсан асуудлын нэг хэвээр байна. Хүн худалдаалахтай тэмцэх тухай (2012), Эрүүгийн хууль (2015), Зөрчлийн тухай (2015), Гэрч хохирогчийг хамгаалах тухай (2013) хуулиуд болон эдгээрийг дагаж гарсан журмуудын бодит хэрэгжилт, уялдаа холбоог хангах, биеэ үнэлэлт, бэлгийн мөлжлөгт өртсөн эмэгтэйчүүд нь хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч, золиос болох эрсдэл их байдагтай холбоотойгоор бэлгийн хүчирхийлэл, мөлжлөг, хүн худалдаалах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авахад шаардагдах суурь тоо мэдээлэл зайлшгүй шаардлагатай.

Монгол Улс хуулиараа биеэ үнэлэлтийг хориглодог. 2002 оныг хүртэл биеэ үнэлэлтийг эрүүгийн гэмт хэрэгт тооцдог байсан бол 2002-2017 оныг хүртэл захиргааны зөрчилд тооцон насанд хүрээгүй, насанд хүрснээс үл хамааран биеэ үнэлэгчийг 30 хүртэл хоногоор баривчилж шийтгэдэг байв. УИХ 2012 онд Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуулийг баталсантай холбогдон зарим хуулиудад нэмэлт өөрчлөлт орсны нэг нь Садар самуун явдалтай тэмцэх тухай хуульд “бусдын биеийг үнэлүүлэхийг хориглоно”⁸ гэсэн заалтыг оруулжээ. Энэ нь биеэ үнэлэлтийн асуудалд агуулгын том өөрчлөлтийг авчирсан гэж үздэг. Хэдийгээр биеэ үнэлэлтийг гэмт хэрэг гэж үзэхгүй болсон ч 2017 оноос эхлэн Зөрчлийн тухай хуулиар хариуцлага хүлээлгэдэг болсон. Зөрчлийн тухай хуулийн дагуу биеэ үнэлж олсон орлогыг нь хурааж, биеэ үнэлсэн болон үнэлүүлсэн этгээдүүдийг 50,000 төгрөгөөр торгодог⁹ болсон хэдий ч

7 <https://www.state.gov/wp-content/uploads/2019/06/2019-Trafficking-in-Persons-Report.pdf>

8 Садар самуун явдалтай тэмцэх тухай хуулийн 4 дүгээр зүйл 4.1 дэх хэсэгт “Биеэ үнэлэхийг хориглоно”, мөн зүйлийн 4.2 дахь хэсэгт “Бусдын биеийг үнэлүүлэхийг хориглоно” гэж тус тус заажээ.

9 Зөрчлийн тухайн хуулийн 6.18 дугаар зүйлийн 6.18.4 дэх хэсэгт “Биеэ үнэлэн бусадтай бэлгийн харьцаанд орсон, эсхүл бусдын биеийг үнэлэн бэлгийн харьцаанд орсон бол хууль бусаар олсон хөрөнгө, орлогыг хурааж хүнийг тавин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно” гэж заажээ.

энэ төрлийн гэмт хэргийн гаралт буураагүй хэвээр байна. Хэдийгээр хохирогчдын эрхийг хамгаалах, нөхөн сэргээхэд зориулсан олон хууль журмуудыг батлан гаргаж байгаа ч хууль тогтоомжийн хэрэгжилт хангагдахгүй, хохирогчдод зориулсан цогц системтэй үйлчилгээ хангалттай бус байна.

Өөрөөр хэлбэл энэ гэмт хэргийг таслан зогсоохын тулд зөвхөн биеэ үнэлэгчидтэй тэмцэх бус, гэмт хэргийг үйлдэж буй хүмүүс, худалдан авагчидтай тэмцэх, олон нийтийн анхаарлыг энэ асуудалд хандуулах, тэдний оролцоог нэмэгдүүлэх нь чухал юм.

Гурав: Биеэ үнэлэлт, бэлгийн мөлжлөгийн талаарх олон нийтийн үзэл, хандлагыг тандсан судалгааны хүрээнд

“Хүйсийн тэгш эрхийн төв” ТББ нь 2019 онд “Биеэ үнэлэлт болон бэлгийн мөлжлөгт өртөх эрсдэл” суурь судалгааг Улаанбаатар хот болон эрсдэл өндөр аймаг орон нутаг болох Дархан-Уул, Орхон, Дорнод, Дорноговь аймгийн Замын-Үүд суманд 700 хүнийг хамруулан хийв. Энэхүү судалгаа нь биеэ үнэлэлт, бэлгийн мөлжлөгийн талаарх олон нийтийн үзэл бодол, мэдлэг хандлагыг тодорхойлоход чиглэсэн болно.

Судалгааны үр дүнгээс үзвэл:

- Монгол Улсад биеэ үнэлэлт, бэлгийн мөлжлөг ямар нэг хэмжээгээр байдаг гэдгийг судалгаанд оролцогчид хүлээн зөвшөөрчээ. Тэд ихэнхдээ амар хялбар аргаар мөнгө олох, гэр бүлийн таагүй нөхцөл байдал, архидалт нөгөө талаас ажилгүйдэл, ядууралтай холбоотойгоор хүмүүс биеэ үнэлж байна гэж үзсэн бөгөөд биеэ үнэлэгчдийн дийлэнх нь охид, эмэгтэйчүүд байна гэжээ.
- Судалгаанд хамрагдсан хүмүүсийн 50 хувь нь биеэ үнэлэлт, бэлгийн мөлжлөгийг нэг ойлголт, үлдсэн 50 хувь нь 2 өөр асуудал гэж тайлбарлажээ.
- Судалгаанд хамрагдагчид биеэ үнэлэлтийг Монгол Улсад хууль ёсны асуудал болгохыг дэмжихгүй байгаагаас гадна насанд хүрэгчид бэлгийн харилцааг мөнгөөр худалдаж авах нь буруу гэж үзэж, биеэ үнэлэлт аль ч нийгэмд байх ёстой гэдэгтэй дийлэнх нь санал нийлэхгүй гэжээ.
- Судалгаанд хамрагдсан арван хүний тав нь биеэ үнэлэлтийн талаарх өнөөгийн хууль тогтоомжид заасан хариуцлагын арга хэмжээ оновчтой бус, хангалтгүй гэж хариулсан бол судалгаанд оролцогчдын 70.7 хувь нь биеэ үнэлэгчдийг худалдан авч буй хүмүүст хуулийн хариуцлага хүлээлгэх нь зүйтэй гэжээ.

- Мөн биеэ үнэлэлт болон бэлгийн мөлжлөгөөс урьдчилан сэргийлэхийн тулд үндэсний хэмжээнд олон нийтийг энэ гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, энэ гэмт хэргийн хохирогчдод үйлчилгээ үзүүлэх цогц, системтэй бодлого, хөтөлбөртэй байх хэрэгтэй гэжээ.

Эцэст нь хэлэхэд судалгаанд хамрагдсан хүмүүсийн 35.5 хувь нь биеэ үнэлэх, 53.8 хувь нь бэлгийн мөлжлөгийн хохирогчид, 37.3 хувь нь биеэ үнэлэгчдийг худалдан авч буй этгээдүүдэд хуулийн хариуцлага хүлээлгэх эсэх талаарх асуултад **"мэдэхгүй"** гэж хариулсан нь тухайн асуудлаар ямар нэг мэдлэг ойлголт аваагүй байгаатай холбоотой байна. Иймд биеэ үнэлэлт, бэлгийн мөлжлөгийн асуудлаар олон нийтэд мэдлэг, ойлголт, мэдлэг өгөх бүх төрлийн арга хэмжээ, үйл ажиллагааг зохион байгуулах шаардлагатай гэж үзэж байна.

Дүгнэлт, санал

Биеэ үнэлэлт, бэлгийн мөлжлөгийн талаарх олон нийтийн ойлголт, мэдлэг ямар байгаа нь биеэ үнэлэлт, бэлгийн мөлжлөгийн асуудлаар цаашид ямар бодлого, үйл ажиллагаа хэрэгжүүлэх вэ? гэдэг нь чухал байна.

Иймд энэ гэмт хэрэгтэй тэмцэхийн тулд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлэх нь зүйтэй байна. Үүнд:

- Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх бодлогыг боловсронгуй болгох, нөхцөл байдалтай уялдуулан өөрчлөлт, шинэчлэл хийх;
- Хохирогчдод туслалцаа, үйлчилгээ үзүүлдэг байгууллагын тоог нэмэгдүүлэх, үйлчилгээг чанартай болгох;
- Хохирогчдыг таньж мэдэх, олж илрүүлэх үйл ажиллагаа, сургалтыг илүү үр дүнтэй явуулах;
- Биеэ үнэлэлт, бэлгийн мөлжлөгийн гэмт хэргийг таслан зогсоох, бууруулахын тулд хохирогчдоос гадна гэмт хэрэгтэн, худалдан авагчидтай тэмцэх;
- Олон нийтийн мэдлэг, ойлголтыг дээшлүүлэх үйл ажиллагааг тогтвортой, өргөн хүрээнд явуулах.

Ялангуяа залуучууд энэ асуудлаар ойлголт, мэдлэгтэй болсноор энэ гэмт хэргийн хохирогч болохгүй байх, урьдчилан сэргийлэх арга барилд суралцах боломжтой болох юм. Нөгөө талаас олон нийтийн бэлгийн мөлжлөг, биеэ үнэлэлтийн асуудалд ханддаг хандлагыг өөрчлөхөд нөлөөлөх боломжтой билээ.

Ашигласан эх сурвалж:

1. Эрүүгийн хууль, (2015).
2. Зөрчлийн тухай хууль, (2017).
3. Садар самуун явдалтай тэмцэх тухай хууль, (1998).
4. Хүн худалдаалахтай тэмцэх тухай хууль, (2012).
5. “Хүйсийн тэгш эрхийн төв” ТББ-ын үйлчлүүлэгчдийн талаарх статистик мэдээлэл.
6. “Биеэ үнэлэлт болон бэлгийн мөлжлөгт өртөх эрсдэл” суурь судалгаа, 2019 он, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, “Хүйсийн тэгш эрхийн төв” ТББ.
7. Хүн худалдаалах гэмт хэрэг гарын авлага, 2009 он, “Хүйсийн тэгш эрхийн төв” ТББ.

UIH.MN
СУДАЛГААНЫ САН



Э.ГЭРЭЛТ-ОД

Монгол Улсын Боловсролын Их Сургуулийн
Нийгэм, Хүмүүнлэгийн ухааны сургуулийн
Нийгмийн ухааны тэнхимийн ахлах багш, доктор

СОНГОГЧИЙН ЭРХ НЬ ЭРХ ЗҮЙН БОЛОН ИНСТИТУЦИЙН АСУУДАЛ БОЛОХ НЬ

VOTER'S RIGHTS AS LEGAL AND INSTITUTIONAL ISSUES

Хураангуй: Монгол Улс нь хүний эрхийг дээдэлсэн, чөлөөт, ардчилсан сонгуультай болоод гучин жил өнгөрчээ. Энэ хугацаанд сонгуулийг бүх нийтийн байх, тэгш санал хураалт, ялгаарласан байх зарчмуудыг хангаж ирсэн үү, төр сонгогчийн эрхийг хамгаалах үүргээ хэрхэн гүйцэтгэж байгаа, ялангуяа хууль, эрх зүй орчинд гарч буй өөрчлөлт болон улс төрийн нам, хэвлэл мэдээллийн байгууллага сонгогчдын эрхийг хэрхэн зөрчиж байгааг энэхүү нийтлэлээр дэвшүүллээ.

Түлхүүр үг: Сонгогчийн эрх, сонгогчийн эрхийг хамгаалах нь, төр, улс төрийн нам, хэвлэл мэдээллийн үүрэг, цагаан сонголт.

Abstract: Mongolia have been holding free and democratic elections that respected human rights since thirty years ago. During this period, the elections were conducted in accordance with the principles of universal suffrage, equal suffrage, and discrimination, but we still have some conflicts of voter's rights. Especially state can't provide good legal environment and some institutions including political parties and media still have not matured.

Key words: Voter's rights, protection of voters' rights, the roles of state, political parties and media, and white choices.

I. Оршил

Монгол Улс 1990 оны ардчилсан хувьсгалын үр дүнд чөлөөт ардчилсан сонгууль явуулах боломжтой болсон. Чөлөөт, ардчилсан сонгуулийн амин сүнс нь сонгогчийн чөлөөтэй, нууцаар, шууд санал өгөх эрхтэй байдаг. Сонгогчийн эрх ардчилал, хүний эрх, эрх чөлөө, төр болон улс төрийн нам, хэвлэл мэдээллийн байгууллагатай холбогдох өргөн асуудал билээ. Харин сонгогчийн эрх ямар байгаа, төр энэ үүргээ хэр биелүүлж байгаа эсэх, хууль эрх зүйн орчин ямар байгаа, төлөвшөөгүй улс төрийн нам, хараат хэвлэл мэдээллийн байгууллагууд сонгогчийн эрхэд хэрхэн халдаж буй зөрчлүүдийг илрүүлэх, шийдвэрлэх арга замыг дэвшүүлэхийг зорилоо.

II. Сонгогчийн эрх ба стандарт

Сонгох эрх нь латин хэлний *suffrage*¹ (*Suffragium*) буюу саналаа өгөх эрх гэсэн утгатай. Хүн төрөлхтөн өөрсдийгөө захирч байгаа хүмүүсийг сонгохыг эртнээс хүсэж байсан ч энэ эрхээ дөнгөж 200 гаруй жилийн өмнөөс олж авсан. Учир нь иргэд эрхээ хамгаалуулах зорилгоор төрийн сонгуульд оролцож, өөрсдийн төрөө байгуулах эрхтэй. Иргэдийн байгуулсан төр иргэнээ хамгаалах, эрхийг нь хангах үүрэгтэй. Иймээс орчин үеийн төрийн үндсэн шинж бол хуульд захирагдах, сонгуулиар байгуулагдах, нийт иргэдийн эрхийг хамгаалах юм.

Сонгогч саналаа нууцаар, чөлөөтэй өгөх эрхтэй бөгөөд төр энэ эрхийг бүх нийтийн, тэгш байх ардчиллын зарчимд нийцүүлэх үүрэгтэй. Энэ зарчмыг олон улсын эрх зүй, Үндсэн хууль, болон бусад эрх зүйн хүрээнд стандартчилж хамгаалсан. Тухайлбал Хүний эрхийн Түгээмэл Тунхаглал (1948), Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт (1966), Эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхах бүх хэлбэрийг устах тухай конвенц (1979) зэрэг олон улсын болон бүс нутгийн эрх зүйгээр хамгаалж, баталгаажуулсан байна. Улс орнууд нь олон улсын гэрээнд нэгдэн орсноор олон хэм хэмжээ, зарчимд нийцүүлэн үндэсний эрх зүйн зохицуулалт, механизмаа сайжруулдаг билээ.

Монгол Улс нь хүний эрхийн олон улсын гэрээ, конвенцуудад нэгдэн орсон ч хүний эрх, тэр дундаа сонгогчийн эрхийн үнэ цэнийг сайтар ухаарахгүй байгаа нь харамсалтай. Магадгүй сонгуулийн ирц буурч, сонгогчид улс төрд, намуудад итгэхгүй байгаа, хэвлэл мэдээллийн байгууллагууд улс төрөөс хараат бусаар сонгогчдод үйлчлэхгүй байгаа нь эцэстээ ардчилсан засаглал хямрах, төрийн легитим шинжийг алдахад хүргэх аюултай. Сонгогчийн эрхийг хамгаалах нь угтаа сонгуулиар байгуулагдсан ардчилсан төрд иргэдийн итгэх итгэлийг нэмэгдүүлдэг ач холбогдолтой билээ.

1

Merriam-Webster dictionary <https://www.merriam-webster.com/dictionary/suffrage>

Хүний эрхийн Түгээмэл Тунхаглалын 21 дүгээр зүйлд “хүн бүр улс орноо удирдахад шууд буюу чөлөөтэй сонгосон төлөөлөгчдөөрөө уламжлан оролцох эрхтэй”², Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын 25 дугаар зүйлд “төрийн хэргийг явуулахад шууд болон чөлөөтэй сонгосон төлөөлөгчдөөрөө уламжлан оролцох; сонгуулийн бүх нийтийн тэгш эрхийн үндсэн дээр саналыг нууцаар хурааж, сонгогчид жинхэнэ хүсэл зоригоо чөлөөтэй илэрхийлэх боломжийг баталгаажуулсан, жинхэнэ ёсоор тогтмол явагддаг сонгуульд сонгох буюу сонгогдох эрхтэй”³ гэж тус тус заажээ. Сонгогчийн эрхийг хамгаалах нь төрийн үүрэг бөгөөд дээрх олон улсын хэм хэмжээг Монгол Улс хүлээн зөвшөөрч нэгдсэн орсны хувьд хэрэгжүүлэх үүрэгтэй юм.

1990 онд Монгол Улс чөлөөт, ардчилсан, олон намын тогтолцоонд шилжсэнээр сонгогчийн эрхийг хамгаалахын тулд Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 9 дэх заалтад “шууд буюу төлөөлөгчдийн байгууллагаараа уламжлан төрийг удирдах хэрэгт оролцох эрхтэй. Төрийн байгууллагад сонгох, сонгогдох эрхтэй. Сонгох эрхийг арван найман наснаас эдэлнэ. Сонгогдох насыг төрийн зохих байгууллага, албан тушаалд тавих шаардлагыг харгалзан хуулиар тогтооно”⁴ гэж тодорхойлжээ. Мөн Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль (2019)-ийн 3 дугаар зүйлийн 3.1.1-т сонгогч нь “18 нас хүрсэн гэж тухайн иргэний төрсөн он, сар, өдрөөс тоолоход сонгуулийн санал авах өдөр буюу түүнээс өмнө тухайн насанд хүрсэн”⁵ байхыг, Иргэний хууль (2002)-ийн 15 дугаар зүйлийн 15.1 дэх хэсэгт “Иргэний эрх зүйн бүрэн чадамж буюу иргэн өөрийн үйлдлээр өөртөө эрх олж авах, үүрэг бий болгох чадвар насанд хүрснээр буюу 18 наснаас бий болно”⁶ хэмээн эрх зүйн бүрэн чадамжтай Монгол Улсын сонгуулийн эрх бүхий иргэнийг сонгогч гэж тодорхойлсон байна.

Ардчилсан улсад сонгогчид сонгуульд үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсролоор ялгаварлагдахгүйгээр оролцох, мөн сонгууль нь бүх нийтийн байх бөгөөд сонгогч бүр оролцох эрхтэй. Харин төрөөс сонгогчийг хөндлөнгийн нөлөөгүйгээр хүсэл зоригоо илэрхийлж, саналаа нууцаар гаргах, удирдах дээд байгууллагаа байгуулахад оролцох эрхээр хангах үүрэг хүлээдэг. Үүнийг Монгол Улсын Үндсэн хуулийн Арван есдүгээр зүйлд “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна”⁷ гэж заасан.

2 Хүний эрхийн Түгээмэл Тунхаглал <https://www.legalinfo.mn/law/details/1271>

3 Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт <https://www.legalinfo.mn/law/details/1257>

4 Монгол Улсын Үндсэн хууль (1992) <https://www.legalinfo.mn/law/details/367>


5 Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль (2019) <https://www.legalinfo.mn/law/details/14869?lawid=14869>

6 Иргэний хууль (2002) <https://www.legalinfo.mn/law/details/299>

7 Монгол Улсын Үндсэн хууль (1992) <https://www.legalinfo.mn/law/details/367>

Өнөөдрийн байдлаар Монгол Улсын хүн амын тоо 3,302,174⁸ хүрсэн байна. Тэдний 2,120,854⁹ нь санал өгөх эрхтэй 18-аас дээш насны иргэн байна. Гэвч бүгд сонгуульд оролцож чадахгүй байна. Сонгогчид бүх нийтээрээ сонгуульд оролцож чадахгүй байгаа нь нэг талдаа сонгогчийн эрх боловч үүнд хууль, эрх зүйн орчин, улс төрийн намын төлөвшил, сонгуульд зуучийн үүрэгтэй оролцдог хэвлэл мэдээллийн байгууллагын бодлого, үйл ажиллагаа, нийгмийн хандлагатай шууд холбоотой. Өнгөрсөн хугацаанд Монголчууд чөлөөт, ардчилсан, шударга, шууд сонгуулиар УИХ, Ерөнхийлөгч, Орон нутгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлыг нийт хорь гаруй удаа сонгож байгуулжээ. Сонгогчдын оролцоо жил ирэх бүр буурсан үзүүлэлттэй байна.

График 1. Сонгуулийн ирц (1992-2016 он)



Сонгогчдын оролцоог нэмэгдүүлэх зорилгоор 2013 оны Ерөнхийлөгчийн сонгуулиар саналаа өгсөн сонгогч бүрт гар утасны 1,000 төгрөгийн нэгжийг урамшуулал болгон өгсөн. Гэвч сонгогчдын оролцоо нэмэгдээгүй. Тэгэхээр улс төрийн намын сонгуулийн мөрийн хөтөлбөр, эсхүл нэр дэвшигчид сонгогчдод таалагдаагүй байж болох юм.

Сонгуулиар сонгогчдын олонхын дэмжлэгийг авч, засаглалыг хэрэгжүүлж байсан Монгол Ардын Нам, Ардчилсан Намуудыг төлөвшөөгүй, хариуцлага хүлээдэггүй гэж үзэх хандлага түгээмэл байна. Тухайлбал 2018 оны Сантмарал сангийн Улс төрийн барометр судалгаанд оролцогчдын 87.3 хувь нь улс төрийн намууд олон түмний санаа бодлыг илэрхийлдэггүй, 72.7 хувь нь улс төрийн намд итгэдэггүй¹⁰ гэжээ. Мөн Улс төрийн боловсролын академийн Азийн Барометр судалгаагаар 2002 оноос хойш улс төрийн намуудад үл итгэх хандлага 40-81 хувь¹¹ болтлоо өссөн байна.

8 Хүн амын тоо, Үндэсний статистикийн хороо. <http://www.nso.mn/index.php> 2020 оны 1 дүгээр сард ашиглав.


9 Статистикийн мэдээллийн нэгдсэн сан. <http://www.1212.mn/> 2020 оны 1 дүгээр сард ашиглав.

10 Улс төрийн барометр (2018 он, 3 дугаар сар) №17(51).

11 Азийн барометр, Улс төрийн боловсролын академи, 2002, 2006, 2010, 2014 он.


Мөн 2016 оны Үндэсний статистикийн хорооны сонгуулийн дүнд хийсэн дээрх анализаас харахад залуу сонгогчдын оролцоо дөнгөж 50 хувьтай байсан бөгөөд нас ахих тусам сонгогчдын оролцоо ихэсдэг болохыг харуулж байна. Мөн эмэгтэйчүүдийн 76.6 хувь, эрэгтэйчүүдийн 70.6 хувь сонгуульд саналаа өгчээ.

График 2. УИХ-ын сонгуулийн оролцоо, насны бүлгээр, (2016 он)¹²



Сонгогчдийн оролцоо буурах нь намын төлөвшилтэй холбоотой бөгөөд УИХ-ын легитим шинжийг дордуулахад нөлөөлж байна. Мэдээж улс төрийн нам төлөвшихөд нөлөөлөх эрх зүйн шинэтгэл хийх нь намд итгэх итгэлийг нэмэгдүүлэх, улмаар намын гүйцэтгэх үүргийг тодорхойлох, намыг дотоод ардчилалтай байх, хөрөнгө, санхүүжилт нь ил тод байхыг шаардах цаг болсон. Энэ нь сонгогчдын улс төрийн намд итгэх итгэлийг нэмэгдүүлэх чухал алхам юм.

Мөн гадаадад байгаа сонгогчдын санал өгөх эрхийг нээх, сонгогчийн бүртгэлийг сайжруулах, сонгогчийн болон иргэний шилжилт хөдөлгөөнийг зохицуулах зэрэг оролцоо, төлөөллийг нэмэгдүүлэхэд анхаарч ажиллах ёстой. Учир нь сонгууль бүрт сонгогчийн бүртгэлийн асуудал маргаан дагуулдаг. Үүнд сонгогчийн нэрсийн жагсаалтыг хэрхэн гаргах, бүртгэлгүй сонгогчийг бүртгэх эсэх, өрхийн сонгогчийн тоог нэмж бичих зэрэг маргаан гарч байна.



12 2016 оны УИХ-ын сонгуулийн дүнд хийсэн шинжилгээ, Үндэсний статистикийн хороо, 2017 он. <http://1212.mn/BookLibraryDownload.aspx?url=Election2016.pdf&ln=Mn>

Хүснэгт 1. УИХ-ын сонгууль, сонгогчийн тоо (1992-2017 он)¹³


№	Сонгуулийн жил	Сонгуулийн насны иргэдийн тоо	Нэрийн жагсаалтад бичигдсэн сонгогчийн тоо	Нэрийн жагсаалтад бичигдээгүй сонгогчийн тоо	
				Тоо	Хувь
1	1992 он	1,202,704	1,085,129	117,575	9.78
2	1996 он	1,218,549	1,147,260	71,289	5.85
3	2000 он	1,364,862	1,247,033	117,829	8.63
4	2004 он	1,472,372	1,279,516	192,856	13.10
5	2008 он	1,607,825	1,542,617	65,208	4.06
6	2012 он	1,882,035	1,840,824	41,211	2.19
7	2016 он	1,998,823	1,911,047	87,776	4.39

Хүснэгт 2. Ерөнхийлөгчийн сонгууль, сонгогчийн тоо (1992-2017 он)¹⁴

№	Сонгуулийн жил	Сонгуулийн насны иргэдийн тоо	Нэрийн жагсаалтад бичигдсэн сонгогчийн тоо	Нэрийн жагсаалтад бичигдээгүй сонгогчийн тоо	
				Тоо	Хувь
1	1993 он	1,159,173	1,106,403	52,770	4.55
2	1997 он	1,241,819	1,155,228	86,591	6.97
3	2001 он	1,398,219	1,205,885	192,334	13.76
4	2005 он	1,578,967	1,241,268	337,699	21.39
5	2009 он	1,642,567	1,493,217	149,350	9.09
6	2013 он	1,998,586	1,864,273	134,313	6.72
7	2017 он	2,032,022	1,988,891	43,131	2.12
		2,032,022	1,990,797	41,225	2.03

Эндээс харахад зарим сонгогч сонгуульд оролцох эрхгүй, нэрсийн жагсаалтаас хасагдах явдал гарч байна.

График 3. Нэрсийн жагсаалтад бичигдээгүй сонгогчид (1992-2016 он)



¹³ Монгол Улсын Их хурлын сонгуулийн дүн (1992-2016), Сонгуулийн ерөнхий хороо, 2017 он.

¹⁴ Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн дүн (1993-2017), Сонгуулийн ерөнхий хороо, 2018 он.

2012 онд УИХ-ын сонгууль, 2013, 2017 оны Ерөнхийлөгчийн сонгуулиудад сонгогчийн нэрсийн жагсаалтад бичигдээгүй сонгогчдын тоо 6 хувиас доош болж буурсан. Энэ нь сонгуульд санал тоолох автомат машин хэрэглэсэн, гадаадад амьдарч буй сонгогчид саналаа өгч эхэлсэнтэй шууд холбоотой. Гэвч 2016 оны УИХ-ын сонгуульд мажоритар тогтолцоог хэрэглэснээс болж гадаадад амьдарч буй иргэд саналаа өгөх эрх хаагдсан. Өөрөөр хэлбэл 2016 оны УИХ-ын сонгуулиар гадаадад амьдарч буй 144,483¹⁵ сонгогч сонгуульд оролцож саналаа өгөх эрхээ эдэлж чадаагүй.

2020 оны УИХ-ын сонгууль мөн л мажоритар тогтолцооны олон мандаттай том тойргийн хувилбарыг хэрэглэх шийдвэрийг УИХ-аас гаргасан нь мөн л гадаадад амьдарч буй сонгогчдын сонгох эрхийг хориглосон шийдвэр болсон. Цаашид энэ асуудлыг шийдвэрлэх цорын ганц боломж нь сонгуулийн тогтолцооны шинэтгэл бөгөөд пропорционал элементийг хэрэглэх нь гадаадад амьдарч буй сонгогчдын эрхийг хангах боломж юм. Сонгуулийн тогтолцооны сонголт УИХ-д хамгийн олон суудалтай намын улс төрийн шийдвэр болсоор удаж байна. Өөрөөр хэлбэл төлөвшөөгүй улс төрийн намууд сонгогчийн эрхийг зөрчиж байна.

Монгол Улсад сонгогчийн эрх олон асуудал дээр зөрчигдөж байна. Тухайлбал:

- Санал өгөх байрны стандарт;
- Сонгогчийн нэрсийн жагсаалтыг буруу гаргах;
- Гадаадад байгаа иргэдийн санал өгөх эрхийг олгох;
- Мандатын тоо ялгаатай байх;
- Үнэн бодитой мэдээ, мэдээлэл авах;
- Сонгогчийн саналыг худалдаж авах зэрэг олон асуудал байна.

Дээрх асуудлыг багцалж үзэхэд эдгээр нь эрх зүйн болон институцийн төлөвшлийн асуудал болж байна.

III. Сонгогчийн эрх нь зүйн асуудал

Монгол Улс нь Үндсэн хууль болон бусад хуульд сонгогчийн эрхийг тунхагласан ч эрх зүйн орчныг сайжруулах шаардлагатай байна. Ялангуяа УИХ-ын 2003 оны 10 дугаар сарын 24-ний өдрийн 41 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсад хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөр”¹⁶-ийг баталсан ч өнөөдөр хүртэл бүрэн хэрэгжихгүй байна. Тухайлбал хөтөлбөрийн 2.2.1 дэх заалтад сонгогчийн эрхийг хамгаалахын тулд төрөөс дараах байдлаар эрх зүйн шинэтгэлийг хэрэгжүүлэх зорилт тавьж байжээ. Үүнд:

15 Гадаад улс орнуудад 144,483 иргэн ажиллаж, амьдарч байна гэв. <http://mminfo.mn/news/view/10731> 2020 оны 1 дүгээр сард уншив.

16 УИХ-ын 2003 оны 10 дугаар сарын 24-ний өдрийн 41 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсад хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөр”. <https://www.legalinfo.mn/annex/details/3225?lawid=6265>

- 2.2.1.1. Сонгуулийн тогтолцоо, үйл явцын (процессын) журмыг иргэдийн бие даасан оролцоог хангаж, чадварлаг УИХ бүрдүүлэхэд болон төлөөлөх ардчиллыг хөгжүүлэхэд чиглүүлэн боловсронгуй болгоно.

Сонгуулийн тогтолцооны шинэтгэлийг хийх нь УИХ-д суудалтай улс төрийн намуудын улс төрийн ашиг сонирхлоос үүдэн амжилт олохгүй байна. Монгол Улс 1992, 2008 онд сонгуулийн мажоритар тогтолцооны олон мандаттай том тойргийн хувилбарыг хэрэглэсэн. Энэ тогтолцоо нь засаг захиргааны нэгж, сонгогчдын тооноос хамааралтайгаар тойргийг 2-4 мандаттай байхаар тогтоосон нь УИХ дахь сонгогчийн төлөөлөл болон саналыг тэнцвэргүй болгосон байдаг. Өөрөөр хэлбэл сонгогч бүр ижил саналын эрхтэй байх зарчмыг алдагдуулсан нь сонгогчийн эрхийн нэгэн зөрчил юм. Мөн 1996, 2000, 2004, 2016 онд сонгуулийн мажоритар тогтолцооны нэг мандаттай жижиг тойргийн хувилбарыг хэрэглэсэн. Гэвч сонгуулийн мажоритар тогтолцоо нь нам, эвслийн нэр дэвшигчид сонгогчийн саналыг худалдан авах, намууд төлөвшихгүй байх, сонгогчид бодлого сонгох боломжгүй болгох, сонгогчийн санал гээгдэх сөрөг үр дагавартай байна. Харин 2012 онд сонгуулийн холимог тогтолцоог 28x48 хувилбараар хэрэглэсэн. Энэ нь 48 мандатыг олон мандаттай 26 тойргоос, 28 мандатыг улс нэг тойрог намын жагсаалтаар сонгосон. Холимог тогтолцоо нь мажоритар болон пропорционал тогтолцооны давуу болон сул талуудыг тэнцвэржүүлэх, харилцан нөхөх онцлогтой байсан юм. 2020 оны УИХ-ын сонгуулийг өмнө хэрэглэж байсан олон мандаттай том тойрог¹⁷-ийн мажоритар тогтолцоог хэрэглэхээр УИХ хуульчилсан. Сонгуулийн энэ тогтолцоо нь УИХ-ын 2003 оны 10 дугаар сарын 24-ний өдрийн 41 дүгээр тогтоолоор баталсан “Хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөр”-ийн 2.2.1.1 дэх заалт өнөөдрийг хүртэл хэрэгжихгүй байгааг илтгэж байна.

- 2.2.1.3. Сонгуулийн болон улс төрийн томилогдох албан тушаалд нэр дэвшигчдэд эмэгтэйчүүдийн эзлэх хувийг нэмэгдүүлэх бодлого баримтална.

2000 оноос эхлэн УИХ дахь эмэгтэйчүүдийн оролцоо, төлөөллийг нэмэгдүүлэх нь сонгогчдын эрхийн чухал асуудал бөгөөд Олон улсын болон дотоодын олон төрийн бус байгууллагууд ажиллаж ирсэн ч, намуудын санаачилга, манлайлал ямагт дутагдаж ирсэн. Учир нь 2005 оны Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд нэр дэвшихэд аль нэг хүйсийн төлөөлөл 30-аас доошгүй хувь байхыг хуульчилж чадсан ч, 2008 онд УИХ энэ заалтыг хэрэглэхгүйгээр цуцалсан. Мөн 2011 оны Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд 20 хувь, 2015 оны Сонгуулийн тухай хуульд 30 хувийг квотыг баталсан ч, 2016 онд 20 хувь болгон бууруулсан байна. 2019 оны шинэчилсэн Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд мөн л 20 хувиар нэр дэвших эрхийг баталлаа. Эндээс харахад улс төрийн шийдвэр гаргах төвшинд эмэгтэйчүүдийн эзлэх хувийг нэмэгдүүлэхийг эрх баригч намууд хүсэхгүй байна.

¹⁷ Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль, (2019).
<https://www.legalinfo.mn/law/details/14869?lawid=14869>

- 2.2.1.4. Олон намын тогтолцоо (УИХ-д бүлэгтэй намуудын тогтолцоо)-г төлөвшүүлэхэд нийцүүлэн улс төрийн нам байгуулж ажиллуулахад тавих шаардлагыг хуулиар шинэчлэн тогтооно.

Өнгөрсөн 30 жил Монголчуудын олж авсан нэг эрх бол улс төрийн эрх, эрх чөлөө. Энэ нь эвлэлдэн нэгдэх, нам байгуулах эрх, эрх чөлөө юм. Ямартаа ч өнөөдрийг хүртэл 50 орчим улс төрийн нам байгуулагдаж байсан. Өнөөдрийн байдлаар намууд нэгдэж, шинээр байгуулагдсанаар УДШ-д бүртгэлтэй 36 улс төрийн нам¹⁸ бүртгэлтэй байна. 1990, 2005 оны Улс төрийн намын тухай хуульд зааснаар намыг 801-ээс доошгүй гишүүнтэй байх¹⁹-ыг шаарддаг. Хуулийн энэ шаардлагыг 2019 оны 11 дүгээр сарын 14-ны өдөр УИХ-аар Үндсэн хуулийн нэмэлт өөрчлөлтийг батлахдаа Арван есдүгээр¹ зүйлийн 2 дахь заалтад “Намыг Монгол Улсын сонгуулийн эрх бүхий иргэдийн нэг хувиас доошгүй иргэн эвлэлдэн нэгдэж байгуулна”²⁰ гэж баталсан. Энэ нь одоогийн байдлаар 21,000-аас дээш гишүүнтэй байх явдал бөгөөд 2028 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс хэрэгжихээр хуульчилсан. Энэ нь 21,000 хүрэхгүй гишүүнтэй 29 намыг нэгдэхэд хүргэх, ирээдүйд иргэдэд эвлэлдэн нэгдэх эрхээ эдэлж шинээр улс төрийн нам байгуулахад саад болохуйц заалт юм.

- 2.2.1.5. Хүн амын шилжилт хөдөлгөөн болон бичиг баримтын зөрчилтэй зэрэг шалтгаанаар сонгуульд санал өгөхийг түдгэлзүүлэх, нэрсийн жагсаалтаас орхигдуулах зэргээр иргэдийн саналаа өгөх эрхийг хөсөрдүүлэхийг ноцтой зөрчилд тооцон хүлээлгэх хариуцлагыг чангатгах, уг зөрчлөөс сэргийлэх арга хэмжээ авна.

Сонгогчийн санал өгөх эрхийг хангах нь сонгууль бүх нийтийн байх зарчмын асуудал бөгөөд иргэний болон сонгогчийн шилжилт хөдөлгөөнийг хуулиар зохицуулж ирсэн. Гэтэл 2019 онд шинэчлэн баталсан Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулиар иргэний шилжилт хөдөлгөөнийг сонгуулийн жилийн 2 дугаар сарын 1-ний өдрөөр хаасан. Мөн сонгогчийн шилжилт хөдөлгөөнийг бүрэн хааж, зөвхөн сонгуулийн зохион байгуулалтад ажиллаж буй ажилтан, улс төрийн нам, нэр дэвшигчийн кампанит ажлын менежерийг шилжилт хийж болохоор хуульчилсан. Энэ нь өмнөх сонгуулийн хуулиудаар олгогдсон сонгууль бүх нийтийн байх, зарчмыг дордуулсан, сонгогчийн санал эрхийг хориглосон хууль болсон гэж үзэхээр байна.

Эдгээр эрх зүйн зохицуулалт нь сонгуулийн эрх зүйг дордуулахын зэрэгцээ, сонгогчийн эрхийг хуулиар зөрчиж байгаа үйлдэл юм. Энэ зөрчлийг арилгах, зөрчигдсөн эрхийг сэргээх үүрэг нь төрд байгаа ч төр нь ялсан намын талд

18 УДШ-д бүртгэлтэй улс төрийн намууд <http://www.supremecourt.mn/nam>

19 Улс төрийн намын тухай хууль (2005)-ийн 9 дүгээр зүйлийн 9.3.7. <https://www.legalinfo.mn/law/details/508>

20 Монгол Улсын Үндсэн хуулийн өөрчлөлтийг эсэргүүцсэн, шүүмжилсэн судлаачид, Европын Аюулгүй байдал, хамтын ажиллагааны байгууллагын саналыг үндэслэн 2028 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс хүчин төгөлдөр үйлчилж эхэлнэ. <https://www.montsame.mn/mn/read/207044>

шийдвэр гаргасаар удаж байна. Иймээс сонгогчийн эрхийн зөрчил нь институцийн асуудал болж байна.

I. Сонгогчийн эрх нь институцийн асуудал

Сонгогчийн эрхийг хамгаалахад төр, улс төрийн нам, хэвлэл мэдээллийн байгууллагууд чухал үүрэг хүлээх ёстой. Харамсалтай нь төр сонгогчийн эрхийг хамгаалахын тулд хууль эрх зүйн орчныг сайжруулах, хамгаалах үүргээ гүйцэтгэж чадахгүй байна. Мөн төрөөс улс төрийн намуудын төлөвшлийг хангах чиглэлд эрх зүйн шинэтгэл хийх цаг нь болжээ. Учир нь намууд иргэний өмнө ямар ч үүрэг гүйцэтгэдэггүй, дотоод ардчилал хангалтгүй, хөрөнгө, орлого нь ил тод биш байж ирсэн. Төлөвшөөгүй улс төрийн намууд сонгуульд ялалт байгуулахын тулд хууль бус санхүүжилт авдаг, хуурамч амлалт өгөх, сонгогчдын саналыг худалдан авах нь түгээмэл болсон. Эцэст нь намууд авилгад хамгийн их өртсөн институци болсон. Үүнийг 2006 оноос хойшхи Азийн сангийн судалгаа²¹-уудад “улс төрийн намууд”, “парламент”, “Засгийн газар” гэх мэт улс төрийн болон төрийн байгууллагуудад өгөх олон нийтийн үнэлгээ улам муудсаар өнөөдөр авилгад хамгийн их автсан байгууллагуудад тооцогдож байна. Намууд санхүүжилтийн түүний ил тод байдлыг хангах үүрэгтэй ч, тайлагнадаггүй, төрийн нөөц, хөрөнгийг ашигладаг, сонгуулийн үеэр сонгогчдын санал нөлөөлөх зорилгоор хувьцааны ашиг болгож бэлэн мөнгө тараах, тараахаар амлалт өгдөг. Энэ бүгд сонгогчийн саналыг худалдаж авах үйлдэл юм.

Монгол Улс 2019 оны хэвлэлийн эрх чөлөөний индексээр 70-д байсан бол 2020 онд 73-т эрэмбэлэгдэж ухарчээ. 2018 оны байдлаар 434²² хэвлэл мэдээллийн байгууллага ажиллаж байна. Тэдний 89 сонин, 80 сэтгүүл, 125 телевиз, 56 радио, 96 цахим сайт Харилцаа, холбооны зохицуулах хороонд бүртгэлтэй. Өнгөрсөн 30 жилийн турш хараат бус, чөлөөт хэвлэл мэдээллийг хөгжүүлэхээр чармайж байсан ч улс төрөөс хараат хэвлэл мэдээллийн байгууллагуудтай болжээ. Сонгуулийн үеэр энэ олон хэвлэл мэдээллийн байгууллагууд мөнгө олох зорилгоор нам, нэр дэвшигчдэд үйлчилдэг. Мөн нэлээдгүй нь улс төрчдийн эзэмшилд байна. Хэвлэл мэдээллийн байгууллагууд нам, нэр дэвшигчдээс хараат бус байж, сонгогчдод тэнцвэртэй мэдээлэл дамжуулах үүрэгтэй ч энэ үүргээ умартдаг. Тиймээс сонгогчид сонгуулийн үеэр хэвлэл мэдээллийн хэрэгсэлд итгэдэггүй, залхдаг.

21 Авлигын талаарх олон нийтийн ойлголт мэдлэг тогтоох судалгаа, Азийн сан, УБ, 2018 он.

22 Хэвлэл мэдээллийн хэрэгслийн тоо буурч, тэдний 78 хувийг компани, хувь хүн эзэмшиж байна. <https://montsame.mn/mn/read/88677>

Хэвлэл мэдээллийн байгууллагууд сонгуулийн үеэр улс төржсөн мэдээлэл цацдаг, хаалтын гэрээ хийдэг, далд сурталчилгаа цацдаг, төлбөрөө нэмдэг. Энэ нь эргээд хэвлэл мэдээллийн салбарыг улс төрөөс хараат болгож байна.

Би өнгөрсөн жилийн 6 дугаар сарын 28-ны өдөр болж өнгөрсөн хэргийн талаар хэвлэл мэдээллийн хэрэгслээр ярихаас жаахан айгаад байна. Хэвлэл мэдээллийн хэрэгсэл гэдэг нийгэмд ямар хүчтэй нөлөөлдөг зэвсэг юм бэ гэдгийг өөрөөрөө мэдэрлээ. Сэтгүүлч хүн мэдээллийг тэнцвэртэй хүргээгүйн хор уршиг нийгэмд хэрхэн нөлөөлдөг вэ гэдгийг олон нийтэд хүргэмээр байна²³.

Үндсэндээ сонгогчийн эрхийг улс төрийн намууд, хэвлэл мэдээллийн байгууллагууд зөрчиж байгаа бөгөөд төр сонгогчийн эрхийг хамгаалах үүргээ гүйцэтгэхгүй байна.

Монгол Улс Европын аюулгүй байдал, хамтын ажиллагааны байгууллагын гишүүн орны хувьд олон улсын ажиглагчид 2013 оноос хойш УИХ-ын болон Ерөнхийлөгчийн сонгуулиудыг ажиглаж үнэлгээ өгсөн. Европын аюулгүй байдал, хамтын ажиллагааны байгууллага нь гишүүн орнуудын засаглал, сонгуулийн үйл явц нь хүний эрхийн зөрчилгүй байхыг үүрэг болгодог бөгөөд олон улсын үүрэг, стандартууд болон дотоодын хууль тогтоомжуудыг дагаж мөрдөж байгаа эсэх, сайжруулах эсэхэд зөвлөмж өгдөг.

Монгол Улс сонгогчын эрхийг зөрчих явдал гарч байгаа тул дараах зүйлсийг анхаарч сайжруулахыг үүрэг болгосон²⁴. Үүнд:

- 5 дугаар сард Сонгуулийн тухай хуульд оруулсан нэмэлт өөрчлөлтийн дагуу УИХ-ын сонгуульд гадаадад суугаа иргэдээс санал авахыг хүчингүй болгож, гадаадад амьдарч буй Монгол Улсын 150,000 орчим иргэдийн сонгуульд оролцох эрхийг хасав.
- Европын аюулгүй байдал, хамтын ажиллагааны байгууллагын Сонгуулийн ажиглалтын хорооноос сонгогчдын саналыг худалдаж авах гэсэн сэжиг бүхий цөөнгүй тохиолдлуудын талаар мэдээлсэн бөгөөд энэ талаар албан ёсны хэд хэдэн гомдол гарсан.
- Үндэсний аудитын газар үр дүнтэй хяналтыг хэрэгжүүлэх нөхцөл боломжийг олгоход чиглэсэн хууль эрх зүйн чухал заалтуудыг одоо ч боловсруулаагүй.

23 Өдрийн сонин, 2013.04.24. <http://dnn.mn/archive/36877/>

24 Европын аюулгүй байдал, хамтын ажиллагааны байгууллагын Ардчилсан институт, хүний эрхийн газраас томилогдсон Олон улсын сонгуулийг ажиглах хорооны тайлан, 2016 он. <https://www.osce.org/mn/odihr/elections/mongolia/249581?download=true>

- Европын аюулгүй байдал, хамтын ажиллагааны байгууллагын Ардчилсан институци, хүний эрхийн газраас өгсөн өмнөх зөвлөмжүүдийн заримыг тусгасан байна, ялангуяа өргөдөл гомдол гаргах үйл явц болон хөгжлийн бэрхшээлтэй сонгогчдын эрхтэй холбоотой зөвлөмжүүдийг тусгасан хэдий ч ихэнх зөвлөмжүүд нь тусгагдаагүй орхигдсон байна.
- Зарим нэр дэвшигчдээс нам нь нэр дэвшүүлэхийн тулд намдаа хандив авах, нэр дэвшигч, сонгуулийн тойрог тус бүрд зардлын хязгаар ялгаатай, сонгуулийн сурталчилгааны санхүүжилтийн зарцуулалтыг зөвхөн сонгууль дууссаны дараа шалгах боломжтой.
- Хэвлэл мэдээллийн хэрэгсэл сонгуулийн мэдээ мэдээллийг өргөн хүрээтэй нэвтрүүлсэн ч зуучлагчийн үүргээ орхигдуулсан. Улс төрийн сурталчилгааны төлбөртэй болон төлбөргүй нэвтрүүлгүүд нь редакцийн хараат бус байдлыг алдагдуулсан. Тиймээс сонгогчдод бие даасан бөгөөд дүн шинжилгээ хийх мэдээ сурвалжлага хомс байлаа.
- Сонгуулийн сурталчилгаа нь ажилгүйдлийг бууруулах, орлого нэмэгдүүлэх, авлигатай тэмцэх болон нийгмийн аюулгүй байдлыг сайжруулах гэх мэт намуудын амлалт болон эдийн засгийн, нийгмийн халамжийн асуудал дээр төвлөрсөн ба томоохон улс төрийн намуудын хооронд үзэл суртлын илэрхий ялгаа байхгүй байна.
- Хэвлэл мэдээллийн салбар нь ил тод ажиллаж байгаа хэдий ч улс төрийн ашиг сонирхлоос үүдэн хараат бус байдал дутагдаж байна. Хэвлэл мэдээлэл болон улс төрийн тоглогчид хоорондоо холбоотой байдаг ба хэвлэл мэдээллийн байгууллагын өмчлөл бүдэг, тодорхой бус зэрэг хамаарна.

Сонгогчийн эрхийг хамгаалах асуудалд төр засаг хойрго ханддаг, улс төрийн сонирхлоор ханддаг, сонгогчийн гомдлыг шийдвэрлэдэггүй, улс төрийн намын санхүүжилт тодорхойгүй, нягтлах боломжгүй, санал худалдаж авдаг, ухаалаг сонголт хийхэд тусалдаггүй, хэвлэл мэдээллийн байгууллагууд сонгогчдод үнэн зөв мэдээллээр хангах үүргээ хэрэгжүүлдэггүй, улс төрийн бүрэн хараат байдаг, үндэсний олон нийтийн телевиз олон нийтэд үйлчлээгүй зэрэг зөрчлүүд гарсныг дэлхийд зарласан. Иймээс цаашид эдгээр зөрчлийг шийдвэрлэх, олон улсын стандартад нийцүүлэх нь сонгогчийн эрхийг хамгаалах алхам болох юм. Үүнийг хэрэгжүүлэх нь төрийн үндсэн үүрэг болно. Түүнчлэн улс төрийн намын төлөвшлийг дэмжихүйц эрх зүйн шинэтгэл хийх хэрэгтэй. Үүнд:

1. Сонгуулийн эрх зүйн шинэтгэл хийх

- Сонгуулийн пропорционал тогтолцоог хэрэглэх;
- Гадаадад байгаа сонгогчдыг саналаа өгөх боломжоор хангах;
- Сонгогчийн шилжилт хөдөлгөөнийг нээх, урьдчилж саналаа өгөх боломжоор хангах;

2. Намын эрх зүйн орчинг шинэчлэх

- Намууд үүргээ хэрэгжүүлдэг болгох;
- Намууд дүрмээ сахиж хэрэгжүүлдэг соёлд сургах;
- Дотоод ардчилал сайжрах;
- Төрийн санхүүжилтийг шударга хуваарилах;
- Намуудын хөрөнгө, орлогыг ил тод болгох;
- Хууль зөрчсөн улс төрийн намуудад хариуцлага тооцдог байх;

3. Хэвлэл мэдээллийн байгууллагын хараат бус байдлыг хангах

- Олон нийтийн телевизийг улс төрөөс чөлөөлөх;
- Арилжааны телевизээр төлбөртэй сурталчилгаа цацахыг хориглох;

4. Улс төрийн санхүүжилтийн орчинг өөрчлөх

- Бага мөнгөөр сонгуулийн сурталчилгаа явуулдаг болох;
- Төрөөс намуудад өгөх хэсэгчилсэн санхүүжилтын арга, зарчмыг өөрчлөх;
- Аж ахуйн нэгж, байгууллагаас хандив авахыг хориглох;
- Нэр дэвшигч өөрийн мөнгөө сонгуульд зарцуулахыг хориглох;

Товч дүгнэлт

Сонгогчийн эрх бол ардчиллын үнэт зүйл бөгөөд үүнийг олон улсын эрх зүй, Үндсэн хууль, бусад хууль тогтоомжийн хүрээнд хамгаалдаг. Харин бид энэ эрхийн үнэ цэнийг сайтар ухаарахгүй байна.

Өнөөдөр сонгогчид улс төр, намуудад итгэхгүй байгаа, хэвлэл мэдээллийн байгууллагууд улс төрөөс хараат бусаар сонгогчдод үйлчлэхгүй байгаа нь цаашлаад ардчилсан засаглал хямрах, УИХ легитим шинжийг алдахад хүргэх аюултай. Сонгогчийн эрхийг хамгаалах нь сонгуулиар байгуулагдсан ардчилсан төрд итгэх итгэлийг нэмэгдүүлдэг ач холбогдолтой болно.

Сонгогчийн эрхийн зөрчил нь дан ганц эрх зүйн асуудал биш институцийн төлөвшлийн асуудал болсон байна. Иймээс төр сонгогчийн эрхийг хамгаалах, олон улсын стандартад нийцүүлэн сонгуулийг зохион байгуулах, эрх зүйн шинэтгэл хийх хэрэгтэй. Мөн УИХ-ын 2003 оны 10 дугаар сарын 24-ний өдрийн 41 дүгээр тогтоолоор баталсан "Монгол Улсад хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөр" хэрэгжүүлэхэд санаачилга гаргах хэрэгтэй.

Сонгогчдын боловсрол сайн биш байна. Тэд сонгуулийг мөнгө гэж хардаг, залуу сонгогчдын оролцоо сул байна. Сонгуулийн хуулийн шинэчлэлтэй холбоотой сонгогчийн эрхийг хамгаалсан дуу хоолой сул байна.

Монгол Улсад сонгогчдын эрхийг улс төрийн намууд, хэвлэл мэдээллийн байгууллагууд зөрчиж байна. Учир нь намууд нь клиентелист болж, хэвлэл мэдээллийн байгууллагууд улс төрөөс хараат болсон. Иймд нам төлөвшихөд нөлөөлөх эрх зүйн шинэтгэл хийх нь намд итгэх итгэлийг нэмэгдүүлэх, улмаар намын гүйцэтгэх үүргийг тодорхойлох, намыг дотоод ардчилалтай байх, хөрөнгө, санхүүжилт нь ил тод байхыг шаардах цаг болсон. Энэ нь сонгогчдын улс төрийн намд итгэх итгэлийг нэмэгдүүлэх чухал холбогдолтой юм.

Хэрэв бид сонгогчдын эрхийг хамгаалах дээрх шинэтгэлийг хийж чадвал сонгууль зүй ёсны болно.

Ашигласан эх сурвалж

Монгол Улсын Үндсэн хууль, (1992). <https://www.legalinfo.mn/law/details/367>

Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт. <https://www.legalinfo.mn/law/details/1257>

Иргэний хууль, (2002). <https://www.legalinfo.mn/law/details/299>

Монгол Улсын Их хурлын сонгуулийн тухай хууль, (2019). <https://www.legalinfo.mn/law/details/14869?lawid=14869>


Хүний эрхийн Түгээмэл Тунхаглал. <https://www.legalinfo.mn/law/details/1271>

2016 оны УИХ-ын сонгуулийн дүнд хийсэн шинжилгээ, Үндэсний статистикийн хороо, 2017 он. <http://1212.mn/BookLibraryDownload.ashx?url=Election2016.pdf&ln=Mn>

Гадаад улс орнуудад 144.483 иргэн ажиллаж, амьдарч байна гэв. <http://mminfo.mn/news/view/10731>

Merriam-Webster dictionary. <https://www.merriam-webster.com/dictionary/suffrage>

Авлигын талаарх олон нийтийн ойлголт мэдлэг тогтоох судалгаа, Азийн сан. УБ, 2018 он.



Азийн баромтер судалгаа. Улс төрийн боловсролын академи, 2002, 2006, 2010, 2014 он.

Европын аюулгүй байдал, хамтын ажиллагааны байгууллагын Ардчилсан институт, хүний эрхийн газраас томилогдсон Олон улсын сонгуулийг ажиглах хорооны тайлан, 2016 он. <https://www.osce.org/mn/odihr/elections/mongolia/249581?download=true>

УИХ-ын 2003 оны 10 дугаар сарын 24-ний өдрийн 41 дүгээр тогтоолоор баталсан "Монгол Улсад хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөр". <https://www.legalinfo.mn/annex/details/3225?lawid=6265>

Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн дүн (1993-2017), Сонгуулийн ерөнхий хороо, УБ, 2018 он.

Монгол Улсын Их Хурлын сонгуулийн дүн (1992-2016) Сонгуулийн ерөнхий хороо, УБ, 2017 он.

НҮБ-ын Хөгжлийн Хөтөлбөрийн Сонгуулийн зохион байгуулалтыг дэмжих нь төслийн үнэлгээний ярилцлагаас, 2012 он, 8 сар.

Олон улсын сонгуулийг ажиглах хорооны урьдчилсан үр дүн ба дүгнэлтийн тайлан. 2017 он. <https://www.osce.org/mn/odihr/327166?download=true>

Өдрийн сонин. 2013.04.24. <http://dnn.mn/archive/36877/>

Үндэсний статистикийн хорооны Статистикийн мэдээллийн нэгдсэн сан. <http://www.1212.mn/>

Улс төрийн барометр, (2018 он 3 дугаар сар), №17(51).

УДШ-д бүртгэлтэй улс төрийн намууд. www.supremecourt.mn/nam

Хүн амын тоо. Үндэсний статистикийн хороо. <http://www.nso.mn/index.php>

UIH.MN
СУДАЛГААНЫ САН



Д.МЯГМАРСҮРЭН

Олон улсын Улаанбаатарын их сургуулийн,
Нийгмийн ажлын тэнхимийн ахлах багш

ЦАР ТАХЛЫН НӨХЦӨЛД ИРГЭНИЙ ЭРХ, ҮҮРГИЙН УЯЛДААГ ХАНГАХ НЬ

THE COHERENCE OF CIVIL RIGHTS AND RESPONSIBILITIES IN THE COVID-19 PANDEMIC

Хураангуй: Зохиогч өгүүлэлдээ Ковид-19 халдварын цар тахалтай тэмцэх, түүний тархалтыг таслан зогсоохтой холбогдон гарч буй хүний эрх болон иргэний үүрэг хариуцлагад тулгамдаж буй асуудал, үзэл баримтлалын өөрчлөлт, нийгэмд өрнөж буй хэлэлцүүлгийг тоймлон авч үзжээ. Хэдийгээр бүх нийтийг хамарсан халдварт өвчин гарч, хорио цээрийн дэглэм тогтоосноор тодорхой хууль, үндэслэл журмын дагуу хүний эрхийг хязгаарлахыг зөвшөөрдөг ч “хүний эрх” нь нийгмийн харилцааны суурь үнэт зүйл хэвээр байж, түүнийг хангаж, хамгаалах арга хэмжээ авч ажиллах талаар хүний эрхийн олон улсын эрх зүйн хэм хэмжээ, баримт бичгүүдэд тусгасан байдгийг авч үзжээ. Улмаар УИХ-аас 2020 онд баталсан “Коронавируст халдвар /Ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай” хуульд иргэний эрх, мөн иргэн, аж ахуйн нэгж, төрийн эрх бүхий байгууллагуудын хүлээх үүргийг тодорхойлсныг тоймлон, судлаачийн хувьд байр сууриа илэрхийлжээ. Эцэст нь дэлхий нийтээр нэг талаас нийгмийн эрүүл мэндийг хамгаалах, нөгөө талаар, хүний эрхийг зөрчихгүй байх хүндхэн сорилттой тулгарч буй цаг үед иргэний эрх, үүргийн уялдааг хангаж, иргэний боловсрол олгоход анхаарах нь чухал болохыг дүгнэсэн байна.

Түлхүүр үг: Коронавируст халдвар /Ковид-19/, иргэний боловсрол, эрх, үүрэг хариуцлага.

Abstract: *In this article, the author outlines overview of human rights concerns posed by the Covid-19 pandemic and public health threat that could justify restrictions on certain human rights, such as freedom of movement, free expressions etc. International human rights law recognizes that in the context of health threats and public emergencies, these restrictions can be justified when they are strictly necessary, based on scientific evidence and neither arbitrary nor discriminatory in application. Besides the number of academic debates, author highlights the importance of coherence of civil rights and responsibilities in the Covid-19 pandemic. Also, the article discusses Mongolian new law on Covid-19 prevention, fight, and mitigation of its socioeconomic impact, which clearly states the responsibilities and prohibitions of citizens, business entities and organizations. Finally, the article concluded in importance of citizenship education and coherence of rights and responsibilities to make a positive difference to their communities (and the wider world) during the coronavirus outbreak.*

Keywords: Coronavirus pandemic (Covid-19), Citizenship education, rights and responsibilities.

Оршил

Ковид-19 буюу коронавируст халдвар нь дэлхий нийтэд улс төрийн, эдийн засгийн, эрүүл мэндийн, технологийн зэрэг олон төрлийн шийдэл, хариу арга хэмжээг нэн яаралтай авч, хэрэгжүүлэхийг шаардсан ноцтой үр дагавар бүхий цар тахал болоод байна. Үүнтэй холбогдон олон улсын харилцаа, эрх зүй, ёс зүйн болон хүний эрхийн олон асуудал үүсэн гарч, өргөн хүрээний хэлэлцүүлэг, маргаан өрнөж байна. Иймд энэхүү өгүүллийн хүрээнд Ковид-19 халдварын цар тахалтай тэмцэх, халдварын тархалтыг таслан зогсоохтой холбогдон гарч буй хүний эрх, ёс зүй болон иргэний боловсролын талаарх үзэл баримтлалын өөрчлөлт, нийгмийн шийдлийг хамтдаа эрэлхийлэхийг зорьж байна.

Дэлхийн нийтийг хамарсан цар тахал өвчний үед эн түүрүүнд авч үзэх хүний эрхийн асуудал нь хүний амьдралын суурь үнэт зүйл болох амьд явах эрхийг хангах явдал юм. Улмаар хүний эрх, эрх чөлөө харилцан хамааралтай байх зарчмын дагуу эрүүл, аюулгүй орчинд амьдрах, эрүүл мэндээ хамгаалуулах, эмнэлгийн тусламж үйлчилгээ авах, амьжиргааны зохистой түвшинд амьдрах, аж ахуй эрхлэх, сурч боловсрох, хөдөлмөрлөх, чөлөөтэй зорчих, үзэл бодлоо илэрхийлэх зэрэг бусад олон эрх, эрх чөлөө хөндөгдөж байна. Эдгээр эрх, эрх чөлөө нь зөвхөн нэг хүний эрхийн тухай бус тухайн нийгмийн, улс орны, улмаар дэлхий нийтийн асуудал болсон тул “хамтын эрх”-ийн агуулгаар авч үзэж болох талтай юм.

I. Цар тахал буюу онцгой нөхцөл

Аливаа бүлэг, нийгэм, ард түмэн нь “хувь хүн” гэх нэгжээс бүрдэх тул цар тахлын нөхцөл байдалд хувь хүний эрх болон үүрэг хариуцлагыг хэрхэн тэнцвэржүүлэх асуудлыг хөндөж үзье. Нийгмийн хөгжлийн өнөөгийн түвшинд, ойрын хугацаанд тохиолдож байгаагүй үл мэдэгдэх олон зүйлс бүхий хямралын үед улс төр, шинжлэх ухаан, ёс зүй, хууль эрхзүйн сэдвээр олон тооны хэлэлцүүлэг, маргаан өрнөж байна. Дэлхийн нийтийг хамарсан цар тахлын нөхцөл байдалтай уялдуулан НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн дарга, Хүний эрхийн Дээд Комиссарын Газар, гэрээний хороод, төрөлжсөн агентлагууд, Эмнести Интернэшнл, Хүний эрхийн хяналт (Human Rights Watch) зэрэг олон байгууллагаас хүний эрхийг ханган хамгаалахад онцгойлон анхаарахыг шаардсан зөвлөмж, уриалга олонтоо гаргаад байна. Тухайлбал “Түр хугацаагаар хөл хорио, тусгаарлалтад оруулсан хүмүүсийн эрх, эрх чөлөөг шууд хязгаарлаж болохгүй, гагцхүү хуулийн зохих үндэслэл болон шинжлэх ухааны нотолгоонд үндэслэж тодорхой хязгаарлалт бүхий хөл хорио тогтоох нь зохимжтой”, “Ямар нэгэн байдлаар хөл хорионд орсон хүмүүсийг “хоригдол, гэмтэн” мэт хандаж харьцаж үл болно.”, “хөл хорионд орсон хэн бүхэн зохисгүй харьцахаас ангид байх, хөл хорионд орсон шалтгааны талаар мэдээлэл авах эрх, хараат бус эмнэлгийн зөвлөмж авах эрх, хууль зүйн туслалцаа авах эрх, тухайн хүнтэй хамаарал бүхий гуравдагч этгээдүүд түүнийг хөл хорионд орсон талаар мэдэгдсэн байх зэрэг эрхийг хязгаарлаж болохгүй” зэргээр хүний эрхийн талаар баримтлах хэм хэмжээг тодорхойлжээ¹. Эндээс харахад бүх нийтийг хамарсан халдварт өвчин гарч, хорио цээрийн дэглэм тогтоосон тохиолдолд ч “хүний эрх” нь нийгмийн харилцааны суурь үнэт зүйл хэвээр байхыг НҮБ болон түүний тогтолцоонд хамаарах байгууллага, гэрээний хороод бататгаж байна.

Үүний зэрэгцээ НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн дарга, НҮБ-ын Хүний эрхийн зөвлөлийн Ерөнхийлөгч, Хүний эрхийн Дээд Комиссар зэрэг албан тушаалтнууд уг цар тахлын улмаас ялгаварлан гадуурхах, үзэн ядах үг хэллэг тараах, хэт туйлшрах, шаардлагагүй тохиолдолд хүч хэрэглэх зэрэг зохисгүй жишиг, тохиолдлууд гарч, хүний эрх, эрх чөлөө олон төрөл, байдлаар зөрчигдсэн, түүний дотор зарим Засгийн газар, төрийн тусгай албад эрх мэдлээр сүрдүүлэн далайлгах, үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөнд халдах явдал ихсэж байгаад санаа зовниж байгаагаа удаа дараа илэрхийлсэн байна². Коронавирусын өвчлөлийг таслан зогсоох зорилгоор авч хэрэгжүүлсэн онц байдлын арга хэмжээ нь нийгмийн эрүүл мэндийг сахин хамгаалахад ач холбогдолтой хэдий ч хүний эрхийн талаар хүлээсэн төрийн амлалт, үүрэг хариуцлагаа огоорох шалтгаан болохгүйг дээрх байгууллагууд онцолсон байна. Хүний эрхийн олон улсын эрх

1 *Коронавирусын цар тахалтай холбогдуулан НҮБ-ын Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх Дэд хорооноос Урьдчилан сэргийлэх үндэсний механизм болон оролцогч улс орнуудад хандан гаргасан зөвлөмжүүд (2020 оны 3 дугаар сарын 25-ны өдөр баталжээ)*

2 *Глоб Интернэшнл Төв ТББ, “Ковид-19 ба Хэвлэлийн эрх чөлөө”, <https://www.gic.mn/public/docs/publications/COVID%2019%20&%20Media%20Freedom.pdf> 2 дахь тал.*

зүйд тухайлбал Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын дагуу хүний эрхийг зарим талаар хязгаарлаж болох ч энэ нь үндэсний аюулгүй байдал, хүн амын эрүүл мэндийг хамгаалах шаардлагаас үүдэн гарсан, заавал хуулийн дагуу, зайлшгүй байх, тодорхой цаг хугацаа, хэм хэмжээнд нийцсэн байх ёстойг энд дурдах нь зүйтэй. Жишээ болгон хэлэхэд ЮНЕСКО-гийн дэргэдэх Олон улсын биоэтикийн хороо (IBC), Шинжлэх ухааны мэдлэг, технологийн ёс зүйн дэлхийн комисс (COMEST) хамтран онцгой байдлын үед улс төрийн болон захиргааны шийдвэр гаргахдаа шинжлэх ухааны үндэслэлтэй, ёс зүйн хэм хэмжээнд суурилан боловсруулах итгэл үнэмшил, ойлголцлыг бий болгохын тулд яаралтай арга хэмжээ авах талаар төр, Засгийн газруудад хандан уриалга гаргажээ.

Нөгөө талаас хүний эрхийг хамгаалахын тулд зөвхөн төрийн эрх баригчид төдийгүй нийгмийн бүх гишүүд, хувь хүмүүсийн үүрэг хариуцлага, ухамсар, оролцоо чухал болохыг онцлох, дахин эргэцүүлэх цаг үе болсныг судлаачид, эрдэмтэд онцолж байна. Өөрөөр хэлбэл Засгийн газрын хувьд хорио цээрийн дэглэм тогтоох, эм, эмнэлгийн хэрэгслийн хангалтыг базаах, эмчилгээ, сувилал, тандалт зэргээр хүний болон хөрөнгийн шаардлагатай нөөцийг дайчилж, шуурхай арга хэмжээ авч чадсан ч иргэдийн хүлээх хариуцлага болох зай барих, хөдөлгөөн хязгаарлах дэглэмийг сахин гэртээ байх, хамгаалах хэрэгслийг хэрэглэх, гараа угаах зэргээр халдвар, хамгааллын дэглэмийг чанад мөрдөхгүйгээр уг нүүрлэсэн аюулаас зайлж чадахгүй билээ. Энэ цар тахлын хамрах хүрээ, түүнээс үүдсэн нийгмийн үзэгдлүүд, үр дагавар зэргийг харгалзан хямралт нөхцөл байдлаас гарах, амьдралын хэвийн горимд орох үйл явц наад зах нь нэг жил үргэлжилнэ гэдгийг судлаачид онцолжээ. Тиймээс хүний эрх болон хувийн үүрэг хариуцлагын талаар ёс зүйн болон хууль зүйн хоёрдмол байдал үүсгэж буй зарим нөхцөлүүдийг тодруулж авч үзье.

1. Нийтийг хамарсан цар тахлын үед хүн бүр эрсдэлтэй тул зөвхөн тухайн хүн өөрийн эрүүл мэндийн эрхийг баталгаажуулж чадна. Хүний эрхийн Түгээмэл Тунхаглалын 14 дүгээр зүйлд "эрүүл мэндийн хамгийн боломжит өндөр түвшинд байх" нь хүний эрх бөгөөд өнөөгийн нөхцөлд эрүүл мэндийн тусламж үйлчилгээг аль болох, хамгийн сайн түвшинд авах боломжтой байхыг ойлгоно гэж тайлбарлажээ. Үүнтэй холбоотойгоор эрүүл мэндийг хамгаалах хувийн үүрэг хариуцлага гэх ойлголт байх бөгөөд энэ нь хувь хүний болон хамтын түвшинд хариуцлагаа ухамсарлан хүлээн зөвшөөрөх, бодитоор хэрэгжүүлэх, мэдлэг ойлголтоо нэмэгдүүлэхийг шаарддаг. Гэхдээ "аливаа хүн эрүүл мэндээ хамгаалах үүрэг хариуцлагаа хэрэгжүүлэх нь өөрийн эрхээ хязгаарлуулахыг зөвшөөрсөн гэж үзэх үү" гэх асуулыг дэвшүүлж байна.
2. Цар тахлын нөхцөлд хүмүүс эмзэг болдог тул уг байдлыг анхаарч үзэх хэрэгтэй ажээ. Тусгаарлах, хөл хорио тогтоох зэрэг хорио цээрийн арга хэмжээ нь хүмүүсийн зан үйл, авир, хандлагад ихээхэн нөлөөлдөг байна. Тухайлбал хөл хорионы дэглэмийн улмаас гэр бүлийн хүчирхийлэл, эдийн

засгийн хүндрэл бэрхшээл үүссэн талаар мэргэжлийн байгууллагууд, судлаачид тодорхой баримт, нотолгоо гарган тавьж буй энэ үед дээрх хүмүүст онцгой анхаарал хандуулах хэрэгтэй. Ялангуяа эмзэг нөхцөлд буй хүмүүсийг хамгаалах, сэтгэл зүйн, эдийн засгийн болон бие махбодын хүчирхийллээс сэргийлэх, ялгаварлан гадуурхахаас зайлсхийх, урьдчилан сэргийлэхийг дэмжих, нөхцөл байдлыг улам дордуулахгүй байх стратеги хэрэгтэй. Улмаар ажилгүйдэл, ядуурал, ялгаварлан гадуурхалт, шилжих хөдөлгөөнийг зогсоосон зэрэгтэй холбоотой зан харилцааны, сэтгэл зүйн болон эдийн засгийн, эмзэг байдлыг сайтар анхаарч, түүнд чиглэсэн бодлогын арга хэмжээг авч хэрэгжүүлэх нь чухал болоод байна.

3. Нийтийг хамарсан цар тахал, өвчний үед нас хүйс, амьдралын нөхцөл байдал, боловсролын түвшнээс үл хамааран хүн бүр тухайн нөхцөл байдлыг үнэлэх боломжтой байхын тулд олон эх сурвалж бүхий, баталгаатай, бодитой мэдээлэл шаардлагатай. Улс төрчид, эрдэмтэн судлаачид, эрх баригчид, хэвлэл мэдээллийн хэрэгслүүдийн мэдээлэл цаг үедээ нийцсэн, үнэн зөв, тодорхой, бүрэн, ил тод байх шаардлагатай нь улам бүр тодорхой болж байна. Өдөр тутмын амьдралд холбогдох бодитой, хэрэглээ бүхий ойлгомжтой мэдээлэл нь иргэд өөрсдийн болон нийгмийн эрүүл мэндийг хангахад чухал хувь нэмэр оруулдаг. Буруу ташаа буюу "хуурамч мэдээлэл" нь нөхцөл байдлыг дордуулж, иргэд, байгууллагуудад учрах эрсдлийг нэмэгдүүлж, амгалан тайван байдлыг алдагдуулдаг байна.
4. Гар утас, социал медиа, хиймэл оюун ухаан зэрэг дижитал технологи нь өвчний тархалтыг хянах, урьдчилан сэргийлэх арга хэмжээ, мэдээлэл зааварчилгаагаар хангах, хөдөлгөөнийг хянах зэргээр цар тахал өвчинтэй тэмцэхэд ихээхэн үүрэг гүйцэтгэдэг байна. Гэхдээ хэвлэл мэдээллийн хэрэгсэл, нийгмийн сүлжээний сэдэвт халдварын тухай мэдээлэл давамгайлдаг тул их хэмжээний мэдээлэл, сэтгэлийн түгшүүр, стресст их өртөж байна. Тиймээс хүний эрхийг ямагт хүндэтгэж, хувийн нууцлал, бие даасан, хараат бус байх зэрэг аюулгүй байдлыг нягт нямбай, тэнцвэртэй хангах ёстой. Эдгээр технологийг ашиглахтай холбоотой ёс зүй, нийгэм, улс төрийн шийдлийг тодорхой болгох нь чухал ач холбогдолтой юм.

Коронавирусын халдвар анх Хятад Улсаас зөөвөрлөгдөн Европ тивийн улс орнуудад тархаж эхлэхэд ази, хятад иргэдийг ялгаварлан гадуурхах, эрхэд нь халдах үзэгдэл цөөнгүй гарч байсан. Харин одоо Хятад Улсад хар, цагаан арьст гадаад иргэдийг мөн ялгаварлан гадуурхах тохиолдол олширсон байна. Энэ талаар Хүний эрхийн хяналт (Human Rights Watch) олон улсын байгууллагаас зохих мэдээлэл цуглуулж, судалгааны тайлан боловсруулж танилцуулсан байна³. Нэг тэрбум илүү хүн амтай, 55 гаруй тооны үндэстнүүд хамтдаа амьдран суудаг Хятад Улсын хувьд арьс өнгөөр ялгаварлан гадуурхах үзэл хамгийн бага гардаг,

³ Human Rights Watch, China: Covid-19 Discrimination Against Africans, Forced Quarantines, Evictions, Refused Services in Guangzhou. <https://www.hrw.org/news/2020/05/05/china-covid-19-discrimination-against-africans> 2020 оны 5 дугаар сарын 21-ний өдөр хандав.

гадаад иргэдэд ээлтэй орнуудын нэг байжээ. Гадныхныг арьс өнгө, хэл, шашин шүтлэгээр гадуурхах үзэгдэл бараг байдаггүй Хятад Улсад гарч буй үзэгдлийг ажиглагчид хоёр нөхцөлтэй холбон тайлбарлажээ. Үүнд нэг талаас ази хүмүүсийг ялгаварлан гадуурхаж буйг эсэргүүцсэн, дургүйлхсэн хандлагын эсэргүүцэн ийм хэлбэрээр илэрхийлж байж магадгүй. Нөгөө талаас коронавирусын халдвар Хятад Улсад намжиж, гадны улс орнуудад эрчимтэй тархсан тул өвчин зөөвөрлөгдөхөөс сэргийлж, өөрөөр хэлбэл, эрүүл мэнд, аюулгүй байдлын үүднээс үйлчилгээний байгууллагууд ийм журам мөрдөх болсон байх талтай гэж дүгнэжээ⁴. Энэ талаар олон улсын болон хүний эрхийн байгууллагууд ч мөн судалгаа, тайлан илтгэл боловсруулж байна. Тухайлбал Minority Rights Group International (“MRG”) байгууллага аливаа улс орон бүхэнд байгаа цөөнхийн бүлгийн гишүүдэд хамаарах хүний эрхийн зөрчлийн талаарх баримтууд цуглуулж, тайлан боловсруулж, НҮБ-ын холбогдох эрх бүхий байгууллага, гэрээний хороодод хүргүүлэхээр ажиллаж байна⁵. Мөн ялгаварлан гадуурхалт, хэт үндсэрхэг үзэл, туйлшрал, экстремизм зэрэгтэй тэмцэх, үүнийг дэмждэг нийгмийн болон соёлын үзэгдэл, бүлгүүдийн нөлөөллийг бууруулах, арилгахад анхаарах хэрэгтэйг олон улсын төрөлжсөн байгууллагуудаас анхааруулж байна⁶.

Ийнхүү иргэний харьяалал, амьдралын хэв маяг, ахуйн соёл, мэдээллийн боловсрол зэргийн ялгаатай байдлаас үүдэлтэй ялгаварлан гадуурхалт гарч, улмаар олон улсын харилцаа, эрх зүй, ёс зүйн болон хүний эрхийн өргөн хүрээний хэлэлцүүлэг, маргаан өрнөж байна. Үүний үр дүнд өмнө нь улс үндэстэн, ард түмнүүдийг нэгтгэн, нэгэн цул болгож байсан үнэт зүйл өөрчлөгдөж байгааг судлаачид авч үзэх болжээ. Тухайлбал улс төрийн бодлого, засаглалын хэлбэр, газар нутгийн байршил, эдийн засгийн хөгжил, соёлын ялгаа зэрэг олон нөхцөл байдлаас үл хамааран одоогоор улс орны удирдагч, эрх баригч намуудаас гаргаж буй шийдвэр, манлайлал нь иргэний боловсрол, ёс зүйн чухал сэдэв болоод байна. Хямралын үед хүмүүсийн сэтгэл зүй өөрчлөгдөж, айдас ноёлох үед тэдний эх оронч үзэл, нэгдэн нийлэх эрмэлзэл өсдөг ажээ. Тухайлбал Саутхемптоны их сургуулийн улс төр судлалын багш, профессор Уилл Женнингсийн онцолж буйгаар, эгзэгтэй нөхцөл байдал үүсэхэд эрх баригчид, удирдагчид улс үндэстнийхээ тулах цэг, нэгдэн нийлэх төв болох магадлалтай ажээ. Тиймээс аливаа гамшиг, урьдчилан таамаглаагүй нөхцөл байдал, халдварт өвчний үед улстөрч, эрх баригчдын авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, нэр хүнд өсөх үзэгдлийг судлаачид “Далбаан дор нэгдэхийн нөлөөлөл” гэж нэрлэж, үүнд холбогдох төрийн тэргүүн, зүтгэлтнүүдийн жишээ, баримтуудыг дурдсан байна⁷.

4 Х.Инга, “Тахал дэлхийг талцуулж байна” Үндэсний шуудан сонин. <http://www.npost.mn/a/167137> 2020 оны 5 дугаар сарын 2-ны өдөр хандав.

5 Minority Rights Group International (“MRG”), We want to hear from you and your communities – what specific challenges are you facing today related to Covid-19? <https://minorityrights.org/coronavirus/report-discrimination/> 2020 оны 5 дугаар сарын 21-ний өдөр хандав.

6 Олон улсын иргэний боловсролын тухай техникийн зөвлөгөөний баримт бичиг: Олон улсын иргэн боловсрол-үзсэн гарч буй хэтийн төлөв, ЮНЕСКО, 2013 он. <http://unesdoc.unesco.org/images/0022/002241/224115E.pdf>

7 Х.Инга, “Далбаан доор нэгдэхүй буюу удирдагч нарын уралдаан” Үндэсний шуудан сонин. <http://www.npost.mn/a/167105> 2020 оны 5 дугаар сарын 2-ны өдөр хандав.

Эдгээр баримтаас харахад нийгмийн харилцаа, үнэт зүйлс өнөө үед хурдацтай өөрчлөгдөн хувирч байна. Үүнийг дагалдан иргэдийн амьдралын хэв маяг мөн өөрчлөгдөж буй бөгөөд түүнд хэрхэн дасан зохицох, хөгжих, иргэний зүгээс төртэй харилцах⁸ эрх, эрх чөлөөгөө мэдэж шийдвэр гаргах үйл явцад оролцох, байр сууриа илэрхийлэх чадвараа хөгжүүлэхэд туслах, оролцоо бүхий нийгмийн хариуцлагатай гишүүн болон төлөвших үйл явцыг зөв оновчтой залж, чиглүүлэх асуудал чухлаар тавигдаж байна⁹. Ялангуяа асуудлыг хүчирхийллийн бус аргаар шийдвэрлэх, олон соёлт ертөнцийг ойлгон хүндэтгэдэг, эрхээ шаардахын хамт үүрэг хариуцлагаа ухамсарласан иргэнийг бэлтгэх шаардлага чухал болжээ.

II. Иргэний эрх үүрэг

Өнөөдрийн тулгамдаж буй цар тахлын нөхцөл байдал иргэдэд эрх, эрх чөлөөгөө мэдэх, шийдвэр гаргахад оролцох, нөлөөлөх, улмаар өөрт, нийгэмд тохиолдож буй асуудлуудаа шийдвэрлэх, үүрэг хариуцлага бүхий нийгмийн гишүүн болон төлөвшихийг зүй ёсоор шаардаж байна. Цаашид уур амьсгалын өөрчлөлт, дэлхийн дулаарал, хүн амын өсөлт болон одоогийнхтой адил дэлхий нийтийг хамарсан цар тахал өвчин зэрэг глобаль эрсдэлт байдал үүсэхийг үгүйсгэх аргагүй бөгөөд үүнийг даван туулах гол арга зам нь иргэдийн үүрэг хариуцлага, ёс зүйн асуудал байх нь зайлшгүй.

Монгол Улсын хувьд төрийн эрх бүхий байгууллагууд коронавирусын халдварыг тархаахгүй байх, хүн амын эрүүл мэндийг хамгаалах зорилгоор гадаад улсаас иргэдээ татан авах, тусгаарлалт, ажиглалтын дэглэм мөрдөх, нийгмийн харилцаанд зохицуулалт хийж буй арга хэмжээний талаар олон төрлийн байр суурь, үзэл бодол гарч, нийгэмд томоохон шүүмжлэл гарч байна. УИХ 2020 оны 4 дүгээр сарын 29-ний өдөр “Коронавируст халдвар /Ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай” хууль баталсан байна. Энэ нь Ковид-19 халдвараас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгмийн эрүүл мэндийг хамгаалах, хүний эрхэд тодорхой хязгаарлалт хийх, холбогдох шийдвэрийг шуурхай гаргах, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах зэрэгтэй холбогдсон харилцааг зохицуулахыг зорьсон нэг удаагийн үйлчлэл бүхий хууль ажээ. Хуульд Монгол Улсын Үндсэн хуулиар хамгаалсан иргэний үндсэн эрх, эрх чөлөөг хязгаарлах тохиолдолд холбогдох шийдвэр, арга хэмжээ нь хуульд заасан үндэслэл, журмын дагуу байх бөгөөд дараах шаардлагыг хангасан байна гэж заажээ¹⁰. Үүнд:

8 *Civils education for the twenty-first century* <http://portal.unesco.org/education/en> 2016-08-26.

9 *Иргэний сонгогчийн боловсрол судалгааны тайлан, УТБА. УБ, 2007 он.*

10 *Коронавируст халдвар /Ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн 11 дүгээр зүйл.* <https://www.legalinfo.mn/law/details/15312?lawid=15312>

- Үндэсний аюулгүй байдал, нийгмийн хэв журам, нийтийн ёс суртахуун, нийгмийн эрүүл мэнд, эсхүл хүний бусад үндсэн эрх, эрх чөлөөг хамгаалах зорилготой байх, энэхүү зорилгод хүрэхэд зайлшгүй, тохирсон байх;
- Хүний амьд явах эрх, итгэл үнэмшилтэй байх, шашин шүтэх, эс шүтэх эрх чөлөө, түүнчлэн хэнд боловч эрүү шүүлт тулгах, хүнлэг бус, хэрцгий хандахыг хориглосон Монгол Улсын Үндсэн хуулийн заалтыг хөндөөгүй байх;
- Хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсролоор болон бусад шинжээр нь ялгаварлан гадуурхахгүй, нэр төрийг нь доромжлохгүй байх зэрэг болно.

Улмаар цар тахлаас урьдчилан сэргийлэх, нийгмийн эрүүл мэндийг хамгаалах зорилгоор гарах шийдвэр арга хэмжээ нь иргэний үндсэн эрх, эрх чөлөөг аль болох хамгийн бага хязгаарласан, бодитой, тохирсон байх бөгөөд үүний хэрэгжилтэд Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комисс хуульд заасан чиг үүргийнхээ хүрээнд хяналт тавьж ажиллахаар журамлажээ¹¹.

Тус хуулийн 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсэгт цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх талаар Монгол Улсын иргэн нь үнэн зөв, бодит мэдээлэл авах, шаардлагатай эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ авах; эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн гэж үзвэл шүүхэд гомдол гаргах; хуульд заасан бусад эрхээ эдэлнэ хэмээн 4 эрхийг тодорхойлжээ. Мөн цар тахлын халдвараар өвчилсөн, өвчилсөн байж болзошгүй хүнийг ялгаварлан гадуурхах, гутаан доромжлохоос урьдчилан сэргийлэх, ийм үйл ажиллагааг хуульд заасан аргаар таслан зогсоохоор хуульчилжээ. Харин мөн зүйлийн 12.2 дахь хэсэгт иргэний хүлээх үүргийг нийт 10 үүрэг болгожээ. Эдгээрийг тоймлон авч үзвэл хязгаарлалтын дэглэм, заавар, журам, зөвлөмжийг сахин биелүүлэх; мэдээллийг үнэн зөв өгөх; үзлэг, шинжилгээнд заавал хамрагдах; тусгаарлах, ажиглах журмыг чанд сахих; холбогдох зайлшгүй зардлыг төлөх зэргээр өргөн хүрээний агуулгыг тусгасан байна. Мөн уг хуулиар иргэн болон аж ахуйн нэгж, байгууллагыг олон нийтийг төөрөгдүүлэх, худал мэдээлэл түгээхийг хориглохын зэрэгцээ хэрэв иргэн халдварт өвчнийг бусдад зориуд халдаасан бол Эрүүгийн хуульд заасан холбогдох хариуцлага хүлээхээр тусгасан байна¹².

Эндээс үзэхэд тус хуульд Ковид-19 халдвараас урьдчилан сэргийлэх, тэмцэхтэй холбоотойгоор иргэний эрх, үүргийг нарийвчлан тусгасан нь сайшаалтай байна. Гэхдээ хүний эрхэд тодорхой хязгаарлалт хийх эрх хэмжээг төр болон түүний эрх бүхий байгууллагуудад өргөнөөр олгож, тухайн нөхцөлд иргэний эдлэх

11 *Коронавируст халдвар /Ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн 11 дүгээр зүйл. <https://www.legalinfo.mn/law/details/15312?lawid=15312>*

12 *Коронавируст халдвар /Ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн танилцуулга. <https://www.avinexlaw.mn/post/>*

эрхийг тун хангалтгүй тусгасан гэж үзэж болохоор байна. Ялангуяа мэдээлэл авах, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ авах; шүүхэд гомдол гаргах зэрэг Үндсэн хуулиар баталгаажуулсан суурь эрхийг нэрлэн зааж, цар тахал болон түүнтэй холбогдох онц байдлын үеийн нөхцөл байдал, иргэдийн эрх, эрх чөлөө зөрчигдөж болзошгүй эрсдлийг нарийвчлан тооцож тусгаагүй байна гэж үзэж байна. Гэхдээ уг хууль батлагдаж, хүчин төгөлдөр болоод удаагүй байгаа бөгөөд одоогоор тус хуулийн хэрэглээтэй холбоотой гомдол санал гарсан тухай мэдээлэл байхгүй байна. Цаашид тус хуулийн хэрэглээ, практикийн талаар хууль эрх зүйн мэргэшсэн судлаачид санал дүгнэлтээ гарган, тодорхой үндэслэлүүд дэвшүүлэх болов уу.

Ковид-19 халдвараас сэргийлэх зорилгоор тогтоосон хорио цээр, хязгаарлалтын дэглэмийн улмаас дэлхий нийтэд сургууль хаагдах, үе тэнгийнхэнтэйгээ шууд харилцахаа болих, олон нийтийн арга хэмжээнд оролцох боломжгүй болох зэргээс шалтгаалан хүүхэд, өсвөр насныханд өвөрмөц тусгай хэрэгцээ гарч байна. Тухайлбал ЮНЕСКО-гийн тооцоолсноор 1.58 тэрбум суралцагч буюу нийт суралцагчийн 90-ээс дээш хувь нь Ковид-19 өвчний улмаас боловсролын байгууллагуудыг хааснаар олон сөрөг нөлөөлөлд өртжээ. Ялангуяа боловсролын үйл ажиллагаа тасалдсан нь хүүхэд, гэр бүлд хамгийн ихээр нөлөөлж буй стрессийн нэг болохыг судалгаагаар тогтоожээ¹³. Ойролцоогоор 2.33 тэрбум хүүхэд хөл хорио тогтоосон орнуудад амьдарч байгаа бөгөөд эдгээр хязгаарлалт нь сургуульдаа очих, найзуудтайгаа уулзах, амралт чөлөөт цагийн үйл ажиллагааг хязгаарласан, мөн хүмүүнлэгийн тусламж шаардлагатай хүүхдийн эрхийг хангахуйц, аюулгүй орчныг бүрдүүлж чадахгүй байна. Тиймээс хүүхэд, өсвөр насныхан Ковид-19 өвчин дэгдэхэд олон "давхар" дарамт, таагүй зүйлстэй нүүр тулж байна. Сургалтын тасалдал, хоол тэжээлийн дутагдал, халамж асаргаа дутагдах, цахим сургалтын дэд бүтцийн тэгш бус хүртээмж, хөдөлмөрийн хөлс буурах зэрэг олон эрсдэл гарч байна. Ийнхүү хязгаарлалтын арга хэмжээ нь хүүхдийн суралцахуй, зан төлөв, сэтгэл хөдлөл, нийгмийн хөгжилд үзүүлэх нөлөө нь улам гүнзгий байх болно. Гэхдээ хүүхэд, өсвөр насныхан, залуучуудыг зөвхөн нөлөөлөлд өртсөн бүлэг гэж үзэлгүй Ковид-19 өвчинтэй тэмцэх хүчин чармайлтад өндөр үр дүн гаргаж чадах түнш гэж үзэхийг дээр дурдсан судалгааг хийсэн мэргэжилтнүүд зөвлөжээ. Хүүхэд, залуучууд, насанд хүрэгчид корона вирус болон түүний хор хөнөөлийн түргэн өөрчлөгдөж байгаа нөхцөлийн талаар мэдлэг ойлголттой байж, хурдан өөрчлөгдөж байгаа, урт хугацааны үр дагавартай нөхцөл байдлыг ганц нэгээрээ болон хамтаар даван туулах, дасан зохицох чадварт суралцах шаардлагатай байна¹⁴.

13 UNICEF MHPSS Operational Guidelines, 2018. <https://www.unicef.org/coronavirus/covid-19> 2020 оны 4 дүгээр сарын 15-ны өдөр хандав.

14 Ази-Номхон далайн суурь ба насанд хүрэгчдийн боловсролын нийгэмлэгийн (ASPBAE) мэдэгдэл. <https://all4education.mn/?p=1036> 2020 оны 4 дүгээр сарын 28-ны өдөр хандав.

Үүнээс үүдэн иргэний эрх үүргийн уялдааны тухай, иргэний боловсролын талаарх уламжлалт хандлагын хүрээ заагаас даван гарч, “дэлхийн иргэн”-ийг төлөвлөх тухай дахин эргэцүүлэх хэрэгтэй байна. Өнөөгийн хөгжлийн хандлага, халдварын дараа бүрэлдэн буй болох шинэ дэг журамд нийцэн ажиллаж амьдрах, эрхээ шаардахын хамт үүрэг хариуцлагаа ухамсарлах, асуудлыг хүчирхийллийн бус аргаар шийдвэрлэх чадвартай “дэлхийн иргэн”-ийг хаана, хэн, хэрхэн бэлдэх вэ?, энэ хүрээнд Монгол Улсын боловсролын байгууллагууд ямар үүрэг хүлээх вэ? зэрэг олон асуудлыг хэлэлцэж, нийгмийн өөрчлөлттэй хөл нийлүүлэн алхах шаардлагатай боллоо. Монгол Улсад зан харилцаа, мөс чанар, ёс жудаг, хүмүүжил, хүндлэл, тэвчээр зэрэг хүний зан үйлийн сайн чанаруудыг эзэмшихэд чиглэсэн сургалт, боловсрол олгох үйл ажиллагаа хангалтгүй байгаагаас гэмт хэрэг, зөрчилд ихээр холбогдож байна хэмээн үзэж иргэдийн хүнлэг чанар, дотоод сэтгэлийн боловсрол, төлөвшлийг сайжруулах зорилгын үүднээс Хүмүүнлэг боловсролыг дэмжих тухай хуулийн төслийг нэр бүхий УИХ-ын гишүүд боловсруулж, хэлэлцүүлэхээр УИХ-ын даргад 2020 оны 5 дугаар сарын 5-ны өдөр өргөн барьжээ.

Монголчуудын оюун санааны хүрээнд соён гэгээрүүлэх асуудал үндсэндээ орхигдсон учраас энэ асуудлыг төрийн бодлого болгон бүх шатны сургалтын хөтөлбөрт хуульчлан тусгах шаардлагатай гэж хууль санаачлагчид онцолсон байна. Энэ хууль батлагдан хэрэгжсэнээр хүн хүнээ хүндэтгэх, эх дэлхий, байгаль орчноо хайрлан хамгаалах зан чанар төлөвшиж, бие бялдрын хөгжилтэй, хөдөлмөр эрхлэх чадвартай иргэдийн тоо нэмэгдэх, гэмт хэрэг, зөрчлийн улмаас үүсч буй хохирол багасах, иргэдийн нийгмийн хариуцлага сайжрах зэрэг нийгэм, эдийн засгийн олон зөрөг үр дагавар гарна хэмээн төсөл санаачлагчид үзжээ¹⁵. Хүмүүнлэг боловсролыг дэмжих тухай энэ хуулийн төсөл нь иргэний боловсролын үзэл баримтлалтай хэрхэн холбогдох, үнэт зүйлс, зорилго, арга зүйн хувьд нийцэх, сургууль, цэцэрлэг, төрийн захиргааны байгууллага зэрэг нь дээрх зорилгыг хэрэгжүүлэхэд хэрхэн оролцох зэрэг нь уг хуулийг хэлэлцэх явцад илүү тодорхой болж, иргэний эрх, үүргийн харилцан тэнцвэрийг тогтооход зохих дэмжлэг болно гэж найдаж байна.

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

Товч дүгнэлт

Нийгмийн салбарын шинэчлэлийг аливаа бүтэц, байгууллагад бус харин харин иргэдийн сэтгэлгээ, хандлагыг өөрчлөхөд чиглэсэн оюун санааны үнэт зүйлс рүү чиглүүлэх нь илүү үр дүнтэй байдаг. Иргэний боловсрол нь нийгэм, соёлын ялгаатай байдал, олон ургальч үзлийг хүлээн зөвшөөрөх, нийгмийн харилцан үйлчлэл, нээлттэй байдал, эрх үүргийн тэнцвэрт харилцааг хүлээн зөвшөөрөх зэрэг шинэ агуулга, үнэт зүйлсээр улам бүр баяжин хөгжиж байна. Тиймээс Тогтвортой хөгжлийн зорилгуудын хүрээнд чухалчлан үздэг “Дэлхийн иргэн” хэмээх ойлголтыг дахин сөхөн гаргаж, нэгдмэл тодорхойлолтод хүрэх, түүнд тавигдах боловсролын, ёс зүйн, эрх зүйн шаардлагуудыг тодорхойлох хэрэгтэй байна. “Дэлхийн иргэн” нь ямар нэгэн хууль эрх зүйн статус, харьяалал, гишүүнчлэлийн тухай ойлголт биш юм. Харин хүн бүр хүн төрөлхтөний нэгэн эд эс бөгөөд дэлхий нийтийн сайн сайхан байдал, тэгш, шударга, зөв нийгмийн төлөө хамтын хариуцлага хүлээж, хувь нэмрээ оруулах үзэл санаа, үйлдэл, үйл ажиллагаа хэмээн үздэг. Тогтвортой хөгжил, дэлхийн иргэний боловсрол нь соёлын олон төрөл байдлыг хүндэтгэн үзэх, одоо ба ирээдүй үеийнхэн байгаль орчинд ээлтэй, эдийн засгийн өгөөжтэй, шударга, зүй ёсны нийгмийн төлөө хариуцлагатай үйл хийж, мэдээлэлд үндэслэсэн шийдвэр гаргах талаар суралцагчдыг чадавхижуулахыг зорьдог.

Энэ цаг үед дэлхий нийтээр нэг талаас нийгмийн эрүүл мэндийг хамгаалах, нөгөө талаар, хүний эрхийг хөсөрдүүлэхгүй байх хүндхэн сорилттой тулгараад байна. Эрүүл байх эрх нь олон улсын хүний эрхийн хуулиар хамгаалагдсан бусад эрхтэй, мөн үүрэг хариуцлагатай нягт холбоотой. Эцэст нь дүгнэхэд газарзүйн хил, соёлын ялгаа, түүнээс үүдэлтэй ялгаварлан гадуурхалт, үл ойлголцлоос зайлсхийх, бусдын эрх, ялгаатай байдлыг хүндэтгэх, иргэний үүрэг хариуцлага зэрэгт төвлөрсөн иргэний боловсролыг дэмжин, нийгмийн гишүүдэд хүрч ажилласнаар нь дэлхий нийтэд тулгамдсан цар тахал өвчнийг даван туулах, тархалтаас урьдчилан сэргийлэхэд шийдвэрлэх үүрэг гүйцэтгэнэ.

НОМ ЗҮЙ

I. Монгол эх сурвалж:

Иргэний сонгогчийн боловсрол судалгааны тайлан, УТБА, УБ, 2007 он.

Олон улсын иргэний боловсролын тухай техникийн зөвлөгөөний баримт бичиг: Олон улсын иргэний боловсрол- үүсэн гарч буй хэтийн төлөв, ЮНЕСКО, 2013 он.

II. Гадаад эх сурвалж:

Civils education for the twenty-first century, 2006

UNICEF MHPSS Operational Guidelines, 2018

UIH.MN
СЭВАЛГААНЫ САН

III. Эрх зүйн эх сурвалж:

Монгол Улсын Үндсэн хууль, (1992).

Коронавируст халдвар /Ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хууль, (2020).

IV. Бусад эх сурвалж:

<http://portal.unesco.org/education/en>

<https://www.montsame.mn/mn/read/224417>

UIH.MN
СУДАЛГААНЫ САН



Б.НЯМЖАВ

“Газрын эзэн баян зүрх”
нөхөрлөлийн захирал

ХҮҮХДИЙН ЭРХИЙГ ХАНГАХАД АНХАН ШАТНЫ НЭГЖИД ТУЛГАМДАЖ БУЙ ЗАРИМ АСУУДАЛ

SOME CHALLENGES IN PROTECTING CHILDREN'S RIGHTS FOR PRIMARY UNITS

Хураангуй: Монгол Улс 215 орчим¹ олон улсын гэрээ, конвенцод нэгдэж орсон бөгөөд үүнээс хүүхдийн эрх, хүүхдийн дээд ашиг сонирхлыг хангаж хамгаалах чиглэлээр 15 гэрээ конвенц хэрэгжиж байна. Монгол Улсад хүүхдийн эрх, хамгааллын чиглэлээр үндсэн 4 хууль хэрэгжиж, хүүхэдтэй хамаарал бүхий заалттай бусад засаг захиргааны болон боловсрол эрүүл мэндийн чиглэлийн 40 гаруй хууль үйлчилж байна. Хүүхдийн эрх, хамгааллын зохицуулалтын зарчим, нийтлэг хэм хэмжээг нэг мөр ойлгох хэрэглэхэд эдгээр хуулийг хэрэгжүүлэхэд хүндрэлтэй асуудал гарч байна. Хүүхдийн эрхийн тухай хуульд хүүхдийн хөгжил, хамгаалал, оролцоо, эрүүл аюулгүй амьдрах асуудлыг тусгасан боловч хэрэгжээд 3 жил гаруй болж байна. Хуулийг хэрэгжүүлэх явцад төрийн үүрэг, хариуцлага, зохион байгуулалт, уялдаа холбоо төрийн албан хаагчдын ажиллах нөхцөлийг сайжруулах, ёс зүйг төлөвшүүлэх, төрийн үйлчилгээний хэв шинжийг бүрдүүлээд зогсохгүй анхан шатны нэгжид хүүхэд хүрч ажиллах бүтэц, зохион байгуулалт, ойлголт хандлага, төсөв хөрөнгө зайлшгүй шаардлагатай байна. Аймгийн төв болон сум, дүүрэгт бидний ажиллах явцад дээрх шаардлагууд тулгамдсан асуудал хэвээр байна.

¹ <http://www.vienna.embassy.mn/index.php?moduls=15>

Хүн амын 40 орчим хувийг эзэлж байгаа хүүхэд, залуучуудыг хөгжүүлэх, хүмүүжүүлэх, монгол хүн болгох, монгол боловсрол олгож сайн иргэн болгож төлөвшүүлэх нь ирээдүйн Монгол Улсын юугаар ч сольшгүй баялаг болох учраас хууль тогтоомжоо оновчтой болгож, хүүхдийн салбарын бодлого, чиглэл, үйл ажиллагааг улам чанаржуулж, хүртээмжтэй ажиллах нь бидний тулгамдсан зорилт болжээ. Тухайлбал Хэнтий аймаг, Баянзүрх дүүргийн иргэд, өсвөр насны хүүхдүүдийн төлөөлөл, холбогдох төрийн албан тушаалтнуудтай ганцаарчилсан 15, бүлгийн 21 ярилцлага хийж, нийт 160 гаруй хүнтэй уулзалт хийх, улмаар “Эрх нь зөрчигдсөн хүүхдүүдийн ар гэртэй ажиллах”, “Өсвөр насны хүүхдүүдэд мэдээлэл, зөвлөгөө өгөх”, “Дахин төлөвлөлтөд өртсөн айл өрхүүдэд орон байртай байх эрх, хууль эрх зүйн мэдлэг олгох”, “Дахин төлөвлөлтөд өртсөн өрхийн хүүхдүүдийг мэдээ, мэдээллээр хангах” гэх мэт төслүүдийг сүүлийн 6 жил гаруй хугацаанд хэрэгжүүлж, 500 гаруй өрхийн 800 гаруй хүнд зөвлөгөө мэдээлэл өгчээ.

Түлхүүр үг: Төрийн хамгаалал, хүүхдийн эрх хамгаалал, төрийн албан хаагчийн үүрэг, эцэг эхийн зөвлөл, хамтарсан баг, хүүхдийн дээд ашиг сонирхол, хүүхдийн эрх, хамгаалал, төрийн тогтолцоо, анхан шатны нэгж, хандлага, ядуурлын шугам.

Abstract: Mongolia has signed over 215 international treaties and conventions. There are six treaties aimed at ensuring the rights of children and nine conventions ensuring and protecting the rights of the child. There are four valid laws aimed at protecting children’s interests and related enactments included in forty laws. Problems still exist in implementing legislation. Particularly, notions and approaches are still unsettled in understanding and implementing the rights of the child within the public order. The law on the rights of the child which covers all issues including child protection, participation, development and health has been in effect for three years. Commitment, responsibility, organization and coordination are crucial in implementing the law. For instance, there is an urgent need to improve the working conditions of public servants, develop ethics, create a new type of public service as well as a need for a formal organizational structure, approach and budget at the level of the primary unit. The education and development of children and youth (who comprise over 40 percent of the nation’s population) toward creating the next generation of productive citizens is crucial for the future of Mongolia. Therefore, the streamlining of legislation as well as enhancement of policy and operation has become our paramount goal. Also, we have conducted fifteen face-to-face and twenty-one group interviews regarding the implementation and conceptualization of children rights with citizen representatives, adolescents, and public servants from Khentii province and Bayanzurkh district. In total, we met with more than 160 persons. We have implemented projects such as: “Working with families whose children’s rights have been violated”, “Offering information and recommendations to adolescents”, “Supplying legal information to re-planned households”, “Supplying information for children whose households have re-planned” and made recommendations to about 800 persons from 500 households.

Key words: State protection, protection of children’s rights, duties of civil servants, parent council, joint team, child’s best interest, child protection, government system, primary unit, attitude, poverty line.

I. Оршил

Монгол Улс 2016 онд Хүүхдийн эрхийн тухай, Хүүхэд хамгааллын тухай хуулиудыг баталснаар хүүхдийн дээд ашиг сонирхолд нийцсэн байх, хүүхдийн нас бие, сэтгэхүйн хөгжлийн онцлогийг үндэслэн, тэдний санал, хүсэлтийг харгалзан үзэх зарчим баримтлахыг төр, аж ахуйн нэгж, байгууллага аливаа үйл ажиллагаандаа мөрдлөг болгохыг баталгаажуулсан байна.

Тус хуульд төрийн чиг үүргийг тодорхойлж, хүүхдийн эрх, хамгаалал, хүүхдийг үл хайхрах, зүй бусаар харьцах, мөлжлөгийн аливаа хэлбэрээс хамгаалах, хүүхдийн боловсрол, хөгжил, оролцоог хангахтай холбоотой харилцааг зохицуулахаар тусгажээ.

Эдгээр хууль батлагдсанаар хүүхдийн эрхийг хамгаалах эрх зүйн зохицуулалт бүхий хамтарсан багтай болсон нь хууль тогтоомжийг өөрчилж нийгмийн хамгааллын бодлого, эрх зүйн орчинд ахиц гарсан юм.

Хүүхдийн эрхийн хамгаалалтыг бэхжүүлэхэд УИХ-ын 2016 оны 19 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030” хөтөлбөрт нийгмийн тогтвортой хөгжлийг хангахын тулд дараах зарчим² баримтлахаар заажээ. Үүнд:

- Нийгмийн хамгааллын үйлчилгээ нь баталгаатай, хүртээмжтэй, зорилтот бүлэгт чиглэсэн байх;
- Нийгмийн үйлчилгээнд зарцуулж буй улсын төсвийн хөрөнгө оруулалтын зардлыг хүн амын тоотой уялдуулж төлөвлөх;
- Нийгмийн хөгжил дэвшилд жендэрийн эрх тэгш оролцоог хангах, нийгмийн баялгийн үр шимээс адил тэгш хүртэх таатай орчинг бүрдүүлэх;
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хөдөлмөр эрхлэх, нийгмийн үйлчилгээнд эрх тэгш оролцох боломжийг бүрдүүлэх.

Хүн ам зүйн бодлогод хүн амаа өсгөх, нийгмийн хамгаалал, сурч боловсрох эрхийг хангах, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, эрүүл мэндийн үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх зэрэг олон арга хэмжээг зорилт болгон тавьж нилээд ажлууд хийгдэж байгаа ч тавьсан зорилтоо бүрэн хангаж, үр дүнд хүрсэн гэхэд чамлалттай.

Хүүхдэд чиглэсэн хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэхэд улс орнуудад олон бэрхшээл тулгардаг боловч хүүхдийн эрх, хамгааллын асуудлаарх хууль, эрх зүйн орчин сайжирч, боловсрол, эрүүл мэндийн үйлчилгээний чанар хүртээмж нэмэгдэж, тодорхой үр дүн гарч байгаа ч шийдвэрлэх шаардлагатай асуудал гарч байна.

² УИХ-ын 2016 оны 19 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030”. <https://www.legalinfo.mn/law/details/11725>

Хотжилт, хот орчмын бүс нутагт төлөвлөгдөөгүй хүн амын суурьшил өсөн нэмэгдсэн ч Улаанбаатар хотын хүн амын 63 орчим хувь нь гэр хороололд амьдарч байна. Хот төлөвлөлтийн бодлого нь цөөн хүн амаар төсөвлөлтөөр явж ирснээс шалтгаалан дэд бүтцийн хүртээмжгүй байдал, хүрэлцэхгүйн улмаас тухайн газар нутагт хөрс, ус, агаарын бохирдол ихээр үүсч, улмаар хүүхдүүд өвчлөлд өртөмтгий эмзэг байгаан зэрэгцээ нийгмийн үйлчилгээнд тэр бүр хамрагдаж чадахгүй байна.

Хөрсний бохирдлоос үүдэлтэй 60 гаруй төрлийн халдварт өвчин³ үүсдэг бөгөөд бохир хөрс нь өвчин үүсгэгч нян, халдвар дамжуулагч, хачиг, нохой бөөс, бясаа, шумуул, ялаа үржих таатай орчин болдог. Улаанбаатар хотын хүүхдүүд агаар, хөрсний бохирдол багатай хот, суурин газрын хүүхдүүдтэй харьцуулахад 7-8 дахин илүү өвчилж байна⁴.

Нийгмийн дэд бүтэц хангалтгүйгээс хүүхдэд үзүүлэх боловсрол, хөгжлийн үйлчилгээ хүрэлцээгүй байна. Улсын хэмжээнд 5-14 насны хүүхдийн 36.5 хувь, 15-17 насны хүүхдийн 30.1 хувь ядуурлын шугамаас доогуур амьдарч буй хүүхдийн сайжруулсан ундны усны эх үүсвэрийн хүртээмж ядуурлын шугамаас дээш түвшинд амьдарч буй хүүхэдтэй харьцуулахад 10-11 хувиар доогуур байна. Мөн 5-14 болон 15-17 настай хүүхдүүдэд хийсэн олон хэмжээст гачигдлын шинжилгээ нь эхийн боловсролын түвшин доогуур, олон ам бүлтэй эсвэл малчин өрхийн хүүхдүүд гачигдлаар илэрхийлсэн ядууралд илүү өртөж байгааг харуулж байна.

Түүнчлэн 0-23 сартай хүүхдийн 9.4 хувь нь бага насны хүүхдийн хөгжлийн хувьд, 76.9 хувь хувь нь орон сууцны болон ариун цэврийн байгууламжийн хувьд гачигдсан, 10 хүүхдийн нэг нь эцэг эхийн анхаарал дутагдсан, 10 хүүхэд тутмын наймаас илүү нь аюултай, эсвэл шаардлага хангаагүй орон байр, ариун цэврийн хангалтгүй нөхцөлд амьдарч байна⁵.

Дээрх судалгаанаас үзэхэд хүүхдийн эрх, хамгаалалтай холбоотой хууль тогтоомжийн хэрэгжилт бүрэн хангагдахгүй байна. Хүүхдэд ээлтэй, хүүхдийн эрхийг хангах аливаа санал санаачилга хэрэгжих үндэс суурь нь гэр бүл, олон нийтэд чиглэсэн бодлого, төрийн үйлчилгээ, тэгш, хүртээмжтэй, чанартай, ялгаварлалгүй боловсролын систем, орон нутгийн дэмжлэг тул энэ чиглэлд түлхүү анхаарах нь зүйтэй юм.

3 “Улаанбаатар хотын хөрсний дортойтол ба эрхүүл ахуй” сэдэвт хэлэлцүүлэг, Эрүүл мэндийн яамны мэдээлэл, 2019 он.

4 Засгийн газрын 2017 оны 270 дугаар тогтоолоор баталсан “Хүүхдийн хөгжил хамгааллын үндэсний хөтөлбөр”.

5 “Хүүхдийн олон хэмжээст, давхацсан гачигдлын шинжилгээний тайлан”, НҮБ-ын Хүүхдийн сан, Монгол Улсын Засгийн газар, 2016 он. / <https://ikon.mn/n/tc2/>

II. Хүүхдийн эрх, хамгааллын өнөөгийн байдал

Монгол Улсын нийт хүн ам 2019 оны эхний улирлын байдлаар 3,238,479 үүнээс 0-19 насны 1,230,454 хүүхэд байна⁶. Энэ нь нийт хүн амд харьцуулбал 37.9 хувийг эзэлж байна.

Хэнтий аймгийн нийт хүүхдийн тоо 2019 оны суурь үзүүлэлтээр 27,314 буюу тухайн аймгийн хүн амын 34.5 хувийг эзэлж байхад Баянзүрх дүүргийн хувьд нийт хүн амын 35.9 хувь (123,292 хүн) нь 0-18 насны хүүхэд тус тус эзэлж байна⁷.

Үүнээс харахад нийт хүн амын 35-40 орчим хувьд хүүхдүүдэд чиглэсэн үйлчилгээг төр хэрхэн үзүүлж, ингэхдээ хэрхэн төлөвлөж, ажлаа хувиарлаж, төсөвлөж байгаагаас дурдвал: Тухайлбал төр болон төрийн бус байгууллагууд хүүхдийн эрхийн хамгаалах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг боловч төсөв мөнгө, хийсэн ажил нь хүндээ, хүүхэддээ хүрэхгүй байгаагаас хүүхдийн эрхийг хангах ажил үр дүнгүй гэж үзэх үндэслэл болж байна.

Энэ нь төрийн албан хаагчид тухайн албан тушаалын тодорхойлолтод үндэслэн хүүхдийн эрх, хүүхэд хамгааллын асуудлын талаар иргэд, тэр дундаа ажил үүргийн дагуу зөвлөл, комисс, хорооны бүрэлдэхүүнд оролцон ажилладаг хэдий ч тэдний хүүхдийн эрхийг хангах, хамгаалахад өөрийн хийж байгаа ажил, албан тушаал хэрхэн ямар үүрэгтэй болох зэрэг олон асуудлаар тэдний мэдлэг ойлголт хангалтгүй байгаатай холбоотой юм.

Иймд хүүхдийн асуудлаар гаргасан эрх зүйн актад⁸ тусгагдсан хамаарал бүхий ажлын байранд томилогдоход нь тухайн ажилтныг хүүхдийн эрх, хүний эрхийн сургалтад тогтмол хамруулдаг болох хэрэгцээ шаардлага байна. Ялангуяа ажлын байр дахь үр дүнг үнэлэхгүй байгаагаас тухайн ажилтны ажил үүргийн хуваарийн гадуур хийгдсэн хүүхдийн эрх, хамгааллын ажлууд хавсарга байдлаар хийгдэж байгааг анхаарах шаардлагатай.

Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга тухайн орон нутгийн хүн амын 40 орчим хувийг эзлэх хүүхдийн асуудалд хүний эрхий дээдлэх төрийн үүргийг зангидах, нэгтгэх нь анхан шатанд төсөв захиран зарцуулахад бүрэн эрхийн хувьд нилээд хувь нэмэр оруулах учиртай боловч аль ч шатны Засаг даргын ажил үүргийн хуваарь, хэрэгжүүлэх үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрт хүүхдийн эрхийг хангах ажил үйлчилгээ бараг тусгагдаагүй байна.

6 <https://www.1212.mn>

7 <https://www.1212.mn>

8 Хүүхдийн төлөө зөвлөл, Гэмт хэргээс урьдчилан сэгийлэх ажлыг зохицуулах зөвлөл, Хүүхдийн эрхийн хууль зүйн хороо, Хамтарсан баг гэх мэт.

Хуулийн бүх заалтууд дээр төрийн албан хаагчдыг үүрэгжүүлсэн, хариуцлага оногдуулна гэсэн зохицуулалттай. Гэхдээ албан тушаалын тодорхойлолтод эрх, үүрэг, хариуцлагын талаар ямар нэгэн заалт ордоггүй байна. Жишээлбэл миний албан тушаалын тодорхойлолтод хүүхдийн гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх ийм ажлыг хийнэ, үр дүнг ингэж үнэлэнэ гэж тусгагдаагүй учраас энэ ажлыг хийсэн ч болно, хийхгүй байсан ч болохоор байгаа юм. Нэг ёсондоо үнэлгээнд ордоггүй учраас хөрсөн дээрээ ажил бодитой, үр дүнтэй болохгүй байна...

*Хэнтий аймгийн Цагдаагийн газрын ажилтантай
хийсэн ярилцлагаас...*

Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын 2018 оны төсвийг дараах байдлаар зарцуулжээ. Үүнд:

- Шинээр хүүхэд хамгааллын үйлчилгээг сайжруулах зорилгоор нийт 6.4 тэрбум төгрөг тусгаснаас 57 хувийг (3.7 тэрбум төгрөг) байгууллагын үйл ажиллагааны зардал, эд хогшил, тавилга худалдан авах;
- 15 хувийг (957.5 сая төгрөг) мэдээлэл сурталчилгаа, урлагийн наадам, тэмдэглэлт өдөр зохион байгуулах;
- 8 хувийг (528.1 сая төгрөг) сургалт семинар зохион байгуулах;
- 10 хувийг бусад үйл ажиллагааны зардал;
- 10 хувийг хүүхэд хамгааллын ажилд тус тус зарцуулсан байна.

Харин 2019 оны төсөвт уг зардлыг хүүхдийн тоо, гэмт хэргийн гаралт зэрэг статистик үзүүлэлт болон хүүхэд хамгааллын үйлчилгээний хэрэгцээний судалгааг харгалзсаны үндсэн дээр орон нутгийн хүүхдийн байгууллагын төсөвт хүүхэд хамгааллын чиглэлээр хэрэгжүүлэх арга хэмжээг санхүүжүүлэхээр тооцож нийт 2.4 тэрбум төгрөгийг төсөвлөсөн байна. Ингэснээр төсвийн хөрөнгийг зориулалтын дагуу илүү үр дүнтэй, зарцуулах боломж бий болно⁹ гэж тайланд дүгнэжээ.

Орон нутагт хүүхдийн эрхийг хамгаалан ажилладаг анхан шатны нэгжид хүүхдийн эрхийг хангах нь бүү хэл хүүхдийн эрхийн нэг хэсэг болох хүүхэд хамгааллын талаар ажлууд төлөвлөсөн нь ямар ч мөнгөгүйгээр явагдаж, албан үүргээ гүйцэтгэж байгаа төрийн албан хаагчид өөрсдийн цалингаасаа холбогдох зардлыг гарган ажиллаж байгаа нь Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын төсөв нь хүрэлцээгүй, зохицуулалтгүй байгааг харуулж байна.

Хүүхдийн эрхийн чиглэлээр бүхий л нөөц, чадавхи ашиглан ажиллаж байна. Бидэнд айл руу дуудлагаар явах төсөв мөнгө байхгүй. Илүү цагаар тогтмол ажилладаг. Илүү цагийн мөнгө гэж байдаггүй. Өөрсдөөсөө мөнгөө гаргаж байна...

Хэнтий аймгийн нэгэн ерөнхий боловсролын сургуулийн нийгмийн ажилтантай хийсэн ярилцлагаас...

Кэйс тохиолдол гарч, айлд очиход мөнгө хэрэгтэй болно. Айлд очихдоо яаахдаа хүүхдэд нэг ч гэсэн уут боов өгөх хэрэгтэй болно. Мөн өвлийн хүйтэнд хүүхэд гэтрээ гал ч байхгүй хүйтэн нүцгэн шахам байдаг. Хөлдөж үхэх аюултай байхад шуудай нүүрс аваад өгөх хэрэг гарна. Үүнийг зохицуулмаар байна. Харсаар байгаад хүүхдийг өлсгөөд үхүүлэлтэй биш, хөлдөж үхэг гээд хаялтай биш өөрөөсөө л мөнгөө гаргах юм. Дараа нь аймгаас авах гэхээр баримт нь бүрдэж өгөхгүй хэцүү. Тэгээд хэзээ хойно авах бүх материалаа бүрдүүлж өгөөд, аймаг руу явуулж цохуулаад мөнгөө авч байна...

Хэнтий аймгийн нэгэн сумын багийн нийгмийн ажилтантай хийсэн ярилцлагаас...

Гэр бүлийн орчинд хүүхдийн эсрэг зүй бус хандлага, эцэг эхийн үл хайхралт, хүчирхийлэл, бэлгийн хүчирхийлэл, насанд хүрээгүй жирэмслэлт, төрөлт, насанд хүрээгүй байхдаа гэр бүл болж амьдрах үзэгдэл, амьжиргааны баталгаажих түвшингээс доош орлоготой, архины хамааралтай гэр бүлд байгаа хүүхдийн эрхийн асуудал шийдэгдэхгүй байгаагаас хүүхдийн эрхийг хамгаалах хууль тогтоомж зөрчигдсөөр байна. Тухайн асуудлыг шийдэхдээ Зөрчлийн тухай хуулиар зохицуулж байгаа нь хүүхдийн эрхийн зөрчлийг илүү далд хэлбэрт оруулж байна.

Манай ээж сумын нийгмийн бодлогын түшмэлээр ажилладаг. Өдөр шөнөгүй ажилтай. Өглөө ажилдаа явна, заримдаа шөнө дуудлагаар яваад өгнө. Үнэндээ би үл хайхралтад өртөж байна. Ээжтэйгээ бараг тааралдахгүй байдаг. Манай ээж эцэг, эхийн хуралд огт сууж үзээгүй. Ер нь төрийн албан хаагчид хүүхдээ хамгийн ихээр үл хайхардаг. Миний эрх зөрчигдлөө гээд 108-д дуудлага өгвөл манай суманд ирж уулзах хүн нь миний ээж юм шүү дээ...

Хэнтий аймаг, нэгэн сумын төрийн албан хаагчийн хүүхэдтэй хийсэн ярилцлагаас...

Малчин өрхийн хүүхдүүдийн зарим нэг эцэг эх нь өөрсдөө өсвөр насны охид хөвгүүдийг нэг гэрт оруулчихаад яваад өгдөг. Үүнийг хүүхдийн эрхийн хуульд хэрхэн тусгах вэ? Гэр бүлийн тухай хуульд ер нь хэрхэн зохицуулсан байдаг юм вэ? Эцэг эх нь өөрсдөө сурагч хүүхдээ дэмжээд гэр бүл болгоод байх юм. Үүнээс гадна ах, эгч нарт нь дүү нарыг нь хариуцуулаад сумын төвд гэр бариад суулгачихаад яваад өгнө. Үүнээс болоод өрх толгойлсон хүүхдүүд бий болж байна...

Хэнтий аймгийн, нэгэн сумын ерөнхий боловсролын сургуулийн сургалтын менежертэй хийсэн ярилцлагаас....

Хүчирхийллийн улмаас 13-18 хүртэлх насандаа ээж болсон хүүхдүүд байна. Тэр хүүхдийн төрүүлсэн хүүхдийг эцэг эх нь авахгүй, хүлээн зөвшөөрөхгүй, өөрөө хүүхэд болохоор хүүхдээ өсгөх боломжгүй. Тэгэхээр насанд хүрээгүй хүүхдийн гаргасан хүлээн зөвшөөрөхгүй байгаа хүүхдийг яах вэ гэдэг асуудал хүнд байна...

*Хэнтий аймаг, төрийн албан
хаагчтай хийсэн ярилцлагаас...*

Зөрчлийн тухай хуулийн дагуу гэр бүлийн хүчирхийлэл гаргасан этгээдийг 200, 300 мянган төгрөгөөр торгоё гэтэл тэр гэрийн эдийн засагт нь нөлөөлдөг. Хүүхэддээ хоол авах мөнгийг нь авах болдог. Торгууль хүлээсэн эцэг, эх чи дуудлага өгснөөс болоод цагдаад мөнгөө хураалгасан хоосон хоно, мөнгө байхгүй гээд дахин хүчирхийлэл үйлдээд байдаг. Хамтарсан багаар явж байхад үнэхээр хүнд хэцүү амьдралтай айлууд олон байдаг. Зөрчлийн тухай хууль гарахаас өмнө Захиргааны хариуцлагын тухай хуульд илүү зөв заалт байсан санагддаг.

Зарим хүмүүсийг баривчлаад ямар ч үр дүн байдаггүй. Харин ч муу нөхдүүдийн танилын хүрээ нь ихэсдэг. Түүний оронд ухамсарлуулж ойлгуулаад явуулвал илүү үр дүнтэй зөвөөр хүлээж авах хүн ч байдаг. Амьдрал дээр баривчилгаанд явуулсан хүмүүсийн цөөхөн хувь нь л ойлгодог. Ийм учраас илүү оновчтойг сонгох хэрэгтэй.

Цагдаагийн зүгээс тодорхой арга хэмжээний хүрээнд ухуулан сэнхрүүлэх үйл ажиллагаа явагдана. Хорооны хамтарсан багаас ойлгуулах нөлөөлөх ажлыг нэлээд хийдэг. Энэ нь илүү үр дүнтэй. Хорооны Засаг дарга нар энэ ажилд илүү анхаарч ажиллах хэрэгтэй. Иймээс хамтарсан багийг л сайн ажиллуулах хэрэгтэй. Хүүхдийн эрхийн тухай, Хүүхэд хамгааллын тухай, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай зэрэг хуулиудыг сайн барьж ажиллах хэрэгтэй байх. Хорооноос тухайн хүүхдийн асуудал хүндэрч 108 дуудлагаар түр хамгаалах байранд очсон тохиолдолд л аргагүй хөдөлж байна...

*Баянзүрх дүүрэг, Цагдаагийн ахлах мэргэжилтэн
цагдаагийн хошуучтай хийсэн ярилцлагаас...*

Сум, хороо, баг, хэсэг дэх анхан шатны нэгжийн хүрээнд хүүхдийн эрх, гэр бүлийн асуудлыг зохицуулах, тэдэнд хүрч үйлчилгээ үзүүлдэг хүүхдийн эрх, хөгжил, хамгааллын асуудлаар ажиллаж байгаа хүний нөөц дутмаг, 1-2 орон тоотой байгаа нь уялдаа холбоо бүхий бүтэц хангалтгүй, хуулийн хэрэгжүүлэх нөөц бололцоо хүрэлцэхгүй байна. Тухайлбал хамтарсан баггүй хороо, нийгмийн ажилтангүй баг, цагдаагийн хэсгийн төлөөлөгчгүй газрууд байгаагаас хүүхдийн эрх зөрчигдөж улмаар гэмт хэрэг, зөрчлийн статистик үзүүлэлт нэмэгдэж байна. Тэнд тогтвортой ажиллах нөхцөл бололцоо байхгүйн зэрэгцээ тэднийг дэмжих дэмжлэг туслалцаа үгүйлэгдэж байна.

Хамтарсан баг нэртэй болохоос биш Багийн дарга, нийгмийн ажилтан хоёроос өөр хүн байхгүй, заримдаа ганцаараа ажилладаг. Жишээлбэл шөнө 12 цаг өнгөрч байхад цагдаа дээр хамтарсан багийг дуудаж байгаа юм. Яасан бэ гээд яваад очиход танай багийн хүн гэр бүлээрээ согтуу байна, бид эрүүлжүүлж болохгүй энэ хүн үхэх аюултай гээд хүнээ ав гэдэг. Тэр хүнийг эрүүлжүүлэх авахгүй Багийн дарга гэртээ аваачилтай биш, аваад явлаа гэхэд гэрт үхчихвэл хэн хариуцлагыг нь хүлээх вэ?

Эх нь согтуу, ой дөнгөж өнгөрч байгаа хүүхэд нь эхийнхээ хөхнөөс зууралдаад шалдан шахам уйлаад байж байгаа дүр зурагтай байна. Эхийг нь эрүүлжүүлэхэд үлдээгээд хүүхдийг нь аваад явах гэхээр байлгах газар байхгүй...

*Хэнтий аймгийн нэгэн сумын сумын багийн
Засаг даргатай хийсэн ярилцлагаас...*

Кэйс тохиолдол гарахад тэдэнд чиглэсэн үйлчилгээ үзүүлчихээд баримтаа бүрдүүлж өгөөд 80 мянган төгрөг аймгийн Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн хэлтсээс гаргуулан авч байна. Хүүхэд хамгаалал болон хүүхдийн эрх, нийгмийн бодлогын асуудлаар багтаа би ганцаараа ажилладаг. Бидний албан тушаалын тодорхойлолтод хүүхэд хамгаалал, хүүхдийн эрхийн чиглэлээр үнэлгээ өгөх заалтууд огт байхгүй. Үнэ төлбөргүй хийдэг гэсэн үг.

Аймагт Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн хэлтэс 22 хүнтэй. Боловсрол соёл, спорт, урлагийн газар мөн л 20 гарсан ажилтантай. Бүгд л бичиг шидээд л, ийм ч тайлан, тийм үйл ажиллагаа зохион байгуул гээд л, дараа нь юу хийснээ тайлангаа явуул гэнэ. Үнэндээ ганцаараа 40 гаруй хүнтэй харилцана, тэдний ажлыг сумандаа зохион байгуулна, тайланг нь бичнэ. Бас кэйс тохиолдолд гарлаа, дуудлага ирлээ гээд л явна. Энэ ажлыг хийх ямар ч нөхцөл бололцоо байхгүй. Дэмжлэг байхгүй. Тэгээд хэдэн төгрөгийн цалин авдаг билээ. Гэтэл манайх 6 мянган хүн амтай сум, хажуугийн сум 1,2 мянган хүн амтай сум. Бид яг адилхан цалин авдаг. Ажлын ачаалал нь үнэхээр их ялгаатай. Ийм байхад яаж ажил хийх хүсэл зориг байхав дээ...

*Хэнтий аймгийн нэгэн сумын төрийн
албан хаагчтай хийсэн ярилцлагаас...*

Амьжиргааны түвшин доогуур гэр бүл нь хүүхдэд зориулж олгож буй тэтгэмж, туслалцааны мөнгөн хөрөнгийг банк, санхүүгийн байгууллага зээл болон дэлгүүр лангууны төлбөрт барьцаалж байгаа нь хүүхдийн өдөр тутам хэрэглэх мөнгөн хэрэглээг хязгаарлаж буйгийн нэг илрэл юм. Тухайн асуудлыг зохицуулах талаар Хүүхдийн эрхийн улсын байцаагчид, хүүхдийн чиглэлээр ажилладаг газруудад эрх мэдэл, эрх зүйн зохицуулалт байхгүйн улмаас зөвхөн банкны мэдэл, шийдвэрийн дагуу хэрэгжүүлж байна. Иймд цаашид банк санхүүгийн холбогдох хууль тогтоомжид өөрчлөлт оруулах нь зүйтэй юм.

Манайх дахин төлөвлөлтөд ороод нүүсэн. Одоо 7 жил гэр оронгүй явж байна. Тухайн үед би 11 настай, дүү нар маань 4, 6 настай байсан. Энэ хугацаанд эцэг, эх хоёр маань нас барсан. Хоёр дүүтэйгээ гурвуулаа бүтэн өнчин. Бид гурав хүүхдийн тэжээгчээ алдсаны тэтгэмжээ авах гэхээр асран хамгаалагчаар тогтоолгосон нагац ах маань тэтгэмжийг маань зээл болгож авчихаад төлөхгүй байгаа. Бидэнд талхны, хоолны мөнгө өгөхгүй байгаа. Мөн хорооноосоо хүнсний талон авч чадахгүй байна. Хороон дээр очихоор гэрт нь очиж үнэлгээ хийж байж олгоно гээд, гэр орон байхгүй бол олгох боломжгүй гээд хамруулахгүй юм. Хүүхдийн мөнгөө авах гэхээр ээжийн карт руу шууд ордог, ээжийн картны хугацаа дуучихсан. Нас барсан учраас сунгаж, ашиглаж чадахгүй байдалтай байна. Бушуухан 18 нас хүрээд хоёр дүүгийнхээ хүүхдийн мөнгө, тэтгэмжийг авах юмсан...

*Баянзүрх дүүргийн дахин төлөвлөлтөд өртсөн нэгэн өрхийн
17 настай хүүхэдтэй хийсэн ярилцлагаас...*

Товч дүгнэлт, анхаарах асуудал

Ирээдүйн эзэд болох хүүхдийг зөв хүн болгож хүмүүжүүлэх, тэдгээрийн сурч боловсрох, хөгжих, эрүүл, аюулгүй амьдрах орчин нөхцөлийг хангаж, эрүүл оюун ухаан, сэтгэл санааг хэрхэн төлөвшүүлэх нь Монгол Улсын тусгаар тогтнол, үндэсний аюулгүй байдалд шууд хамааралтай. Иймд дараах асуудалд анхаарах хэрэгтэй байна. Үүнд:

1. Төрөөс явуулж байгаа үйл ажиллагааг сайжруулах, зохицуулалт хийх чиглэлээр анхаарах асуудал:

- Төрийн албан хаагчдад зориулан хүний эрх, хүүхдийн эрхийн сургалтын нэгдсэн модулийг нэг стандартаар боловсруулж, цахим хэлбэрээр сургалт зохион байгуулж мэдлэгжүүлэх ажлыг тогтмолжуулах;
- Хүүхдийн төлөө зөвлөл, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл, Хүүхдийн эрхийн хууль зүйн хороо, Хамтарсан баг, Цагдаагийн байгууллагын хүүхдийн байцаагч, Хүүхийн элч зэрэг ажил үүргийн дагуу хүүхдийн эрхийг хангах сонгуульт үүрэг гүйцэтгэдэг, тэр дундаа гол зохицуулагч, нарийн бичгийн даргын үүрэг хүлээх ажилтны албан тушаалын тодорхойлолт, үр дүнгийн гэрээнд хувь эзлүүлж үнэлж дүгнэдэг болгох;
- Хүүхдийн төлөө зөвлөл, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл, Хүүхдийн эрхийн хууль зүйн хороо, Хамтарсан багууд ихэвчлэн Засаг дарга удирдахаар зохицуулсан байна. Тиймээс аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргын тухайн жилд хэрэгжүүлэх үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрт хүүхдийн эрхийн асуудлаар бүлэг ажил оруулах, түүнд шаардлагатай төсвийг хуульд заасан одоогийн

зохицуулалтын дагуу Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар батлуулдаг жишиг тогтоох;

2. Хүүхдийн эрхийг хангахад чиглэсэн хууль, бүтэц зохион байгуулалтад анхаарах асуудал:

- Хүүхдийн эрхийн тухай хуулийг шинэчлэн найруулж, бусад хууль тогтоомжид нийцүүлэх;
- Аймаг, дүүргийн Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн хэлтсийн орон тоог багасгаж, тайлан, дүн мэдээ хуулийн хүрээнд нэгтгэх, цомхон бүтэцтэй болгох;
- Сум, баг, хорооны түвшинд одоогийн нэр төдий, ажиллах хүчгүй хамтарсан багийг гэр бүл, хүүхэдэд чиглэсэн нийгэм, сэтгэл зүйн зөвлөгөө өгдөг, тодорхой ажил үүрэг гүйцэтгэдэг мэргэшсэн албан хаагчдаас бүрдсэн хамтарсан баг болгож зохион байгуулах; Энэ нь Хүүхдийн эрхийн тухай, Хүүхэд хамгааллын тухай, Гэр бүлийн тухай, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн хэрэгжилтийг хангахад дөхөм болно. Тухайлбал Хэнтий аймгийн нэгэн суманд 2020 оны 1 дүгээр сард гэр бүлийн хүчирхийлэлтэй холбоотой 9 дуудлага цагдаагийн байгууллагад бүртгэгдэж арга хэмжээ тооцогдсоноос 3 гэр бүл нь салсан, бусад гэр бүл нь дахин дуудлага өгсөн ч гомдолгүй гэж хүсэлтээ буцаасан¹⁰ жишээ байна.
- Хүүхэдэд үйлчилгээ үзүүлдэг, хүнд нөхцөлд, илүү цагаар зайлшгүй ажиллах шаардлагатай төрийн захиргааны анхан шатны нэгжид ажиллаж байгаа албан тушаалтны цалинг нэг хүнд ногдох үйлчилгээний стандартай холбон тогтоодог болох; Энэ нь анхан шатны нэгжид чадварлаг, хүндээ хүрч үйлчлэх сэтгэлтэй хүмүүс ажиллах нөхцөл бүрдэж, гэр бүл салалт, хүүхдийн эрхийн зөрчлүүд буурах боломж бүрдэнэ гэж үзэж байна.

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

НОМ ЗҮЙ:

I. Монгол эх сурвалж:

УИХ-ын 2016 оны 19 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030” хөтөлбөр.

“Улаанбаатар хотын хөрсний дортойтол ба эрхүүл ахуй” сэдэвт хэлэлцүүлэг, Эрүүл мэндийн яам, 2019 он.

“Хүүхдийн олон хэмжээст, давхацсан гачигдлын шинжилгээний тайлан”, НҮБ-ын Хүүхдийн сан, Монгол Улсын Засгийн газар, 2016 он.

<https://ikon.mn/n/tc2/>

“2019 оны төсвийн гүйцэтгэлийн тайлан”, Сангийн яам, 48 дугаар хуудас.

“Монголын хүүхдүүд 2016/2017 статистик эмхэтгэл”, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар, 2019 он.

“2014-2020 онд хийж гүйцэтгэсэн ажлын тайлан”, Газрын эзэн баян зүрх нөхөрлөл, 2020 он.

II. Эрх зүйн эх сурвалж:

Хүүхдийн эрхийн тухай хууль, (2016).

Хүүхэд хамгааллын тухай хууль, (2016).

Засгийн газрын 2017 оны 270 дугаар тогтоолоор баталсан “Хүүхдийн хөгжил хамгааллын Үндэсний хөтөлбөр”.

III. Бусад эх сурвалж:

<https://www.legalinfo.mn>

<https://www.1212.mn>

<http://www.vienna.embassy.mn/index.php?moduls=15>





UNITED NATIONS
HUMAN RIGHTS
OFFICE OF THE HIGH COMMISSIONER


НЭГДСЭН ҮНДЭСТНИЙ БАЙГУУЛЛАГЫН ХҮНИЙ ЭРХИЙН ДЭЭД КОМИССАРЫН ГАЗАР

Ковид-19 Удирдамж Covid-19 Guidance

Ковид-19 нь иргэд, зон олон, төр засаг, нийгэмд бүхэлд нь сорилт, шалгалт болж байна. Энэ цаг үед вирустэй тэмцэж, Ковид-19-ийн тархалтыг зогсооход чиглэсэн арга хэмжээнүүдээс санамсаргүй байдлаар үүдэн гарах аливаа сөрөг үр нөлөөг бууруулахад хамтын ажиллагаа, эв нэгдэлтэй байх нь юу юунаас илүү чухал болоод байна. Хүний эрхийг, тухайлан эдийн засаг, нийгмийн, иргэний болон улс төрийн эрхийг бүхий л хүрээнд хүндэтгэн үзэх нь нийтийн эрүүл мэндийн төлөө авч буй хариу арга хэмжээг амжилттай хэрэгжүүлэх үндэс суурь нь болох юм.

Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хүртээмж

- Эрүүл мэндийн стратеги, бодлого нь зөвхөн цар тахлын эмчилгээний хүрээнд хариу арга хэмжээ авахаас гадна эрүүл мэндийн чиглэлээр авч буй арга хэмжээнээс үүдэн гарах аливаа хүний эрхийн болон жендэрийн асуудалд сөрөг нөлөө бүхий үр дагаврыг ч мөн адил харгалзан үзэж, шийдвэрлэх нь зүйтэй юм.
- Эмчилгээ, үйлчилгээ нь аливаа ялгаварлан гадуурхалтгүй хүн бүрт хүртээмжтэй байх ёстой. Тодруулбал эмчилгээний төлбөр төлөх боломжгүй эсвэл аливаа шившиглэл, гадуурхалтын улмаас эмчилгээ, үйлчилгээнд хамрагдаж чадахгүй байгаагаас болж эрүүл мэндийн үйлчилгээнээс хэнийг ч орхигдуулахгүй байх явдлыг хангах ёстой юм.
- Цар тахалтай холбоотой хүний нэр нууцалсан мэдээллийг наад зах нь нас, хүйс, хөгжлийн бэрхшээлээр ангилан авч, нэгтгэн, нийтэд ил болгох, эрүүл мэндийн шинжтэй хариу арга хэмжээнийхээ талаар мэдээлэх, анхаарлын гадна орхигдох өндөр эрсдэлтэй хүмүүсийг олж тогтоох нь зүйтэй.



Онцгой байдлын арга хэмжээ

- Ковид-19-ийн эсрэг хариу арга хэмжээ авахын тулд Засгийн газрууд хэцүү шийдвэрүүдийг гаргах ёстой болно. Тодорхой аюул заналын эсрэг онцгой байдлын хариу арга хэмжээнүүдийг авахыг олон улсын хуулиар зөвшөөрдөг. Гэхдээ авах арга хэмжээ нь үнэлж тогтоосон эрсдлийнхээ хэр хэмжээнд нийцсэн, зайлшгүй шаардлагатай бөгөөд аливаа ялгаварлан гадуурхалтгүй байх ёстой. Өөрөөр хэлбэл нийтийн эрүүл мэндийг хамгаалахын тулд тодорхой чиглэл, үргэлжлэх хугацаатай, аль болох түвэг багатай байдлаар арга хэмжээнүүдийг авах хэрэгтэй.
- Онц байдал зарласан үед Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын дагуу гишүүн улс орнууд НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн даргаар дамжуулан албан ёсны мэдээлэл өгөх үүргээ биелүүлэх ёстой. Бүс нутгийн хүний эрхийн гэрээ конвенц ч мөн ижил үүрэг хүлээлгэнэ.
- Ковид-19-тэй холбоотойгоор онцгой байдлын үеийн эрх хэмжээгээ гагцхүү нийтийн эрүүл мэндийг хамгаалах зорилгоор хэрэгжүүлэхээс бус хүний эрхийн хамгаалагчид эсвэл сэтгүүлчдийн ажил, үйл хэргийг няцаах, хүчингүй болгох эсвэл тэднийг чимээгүй болгоход ашиглах ёсгүй юм. Зарим эрхүүдийг ямар ч үед хязгаарлаж болохгүй бөгөөд үүнд албадан гаргахгүй байх зарчим, хамтын цөллөгийг хориглох, эрүүл шүүлт болон хүнлэг бус харьцах явдлыг хориглох, албадан хорихыг хориглох зэрэг бусад хүний эрхийн асуудал орно.
- Засгийн газрын зүгээс онцгой байдлын арга хэмжээ гэж юу болох, хаана, хэр удаан хугацаанд эдгээр арга хэмжээнүүдийг авах талаар вируст өртсөн олон нийтэд мэдээлэх хэрэгтэй.
- Хямрал болж өнгөрсний дараа төр засгууд хэвийн амьдралдаа буцаж орж, өдөр тутмын амьдралыг зохицуулах үүднээс онцгой байдлын эрх хэмжээгээ хэрэглэхгүй байх нь чухал бөгөөд авч буй хариу арга хэмжээ нь энэхүү хямралын өөр өөр нөхцөл байдал дахь хэрэгцээнд нийцсэн байх ёстой гэдгийг хүлээн зөвшөөрөх ёстой.

Хэнийг ч ардаа орхихгүй байх

- Аль ч нийгэмд янз бүрийн шалтгааны улмаас гадуурхагдсан, олон нийтийн мэдээлэл, үйлчилгээ авахад хүндрэлтэй тулгардаг хүмүүс байдаг бөгөөд бугшсан ялгаварлан гадуурхалт, улс төрийн хуваагдалт байгаа болохыг тэдний заримаас харж болно. Ковид-19-тэй холбоотой олон нийтэд мэдээлэл тарааж, хариу арга хэмжээ авахдаа орхигдож болзошгүй эрсдэлд буй хүмүүст онцгой анхаарал хандуулах хэрэгтэй бөгөөд үүнд үндэстний цөөнх, шашны цөөнх, уугуул иргэд, цагаач болон

дүрвэгсэд, настай хүмүүс, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс болон ЛГБТИ зэрэг хүмүүс орно.

- Хүний эрхийн үндэсний байгууллагууд болон иргэний нийгэм нь орхигдож болзошгүй байх байсан хүмүүсийг олж тогтоож, эдгээр хүмүүст хүргэх мэдээллийн урсгалыг дэмжиж, авч буй арга хэмжээ нь олон нийтэд ямар үр нөлөө үзүүлж байгаа талаарх мэдээлэл, санал хүсэлтээ холбогдох эрх бүхий хүмүүст хүргэх замаар туслалцаа дэмжлэг үзүүлж болно.

Орон байр

- Хүмүүсийг гэртээ байхыг зөвлөж байгаа энэ үед төр засгийн зүгээс зохистой орон байргүй хүмүүст туслах яаралтай арга хэмжээ авах нь нэн чухал юм. Гэрээс гарахгүй байх, нийгмээс тусгаарлах гэх мэт Ковид-19-тэй холбоотой авч буй арга хэмжээ нь зарим нэг хүмүүст, ялангуяа хэт шахалдсан нөхцөлд амьдардаг болон ундны ус, ариун цэврийн байгууламжгүй хүмүүст маш хүнд тусч байгааг харгалзан үзэх хэрэгтэй. Муухан оромжид амьдарч байгаа болон орон гэргүй хүмүүсийн асуудлыг шийдвэрлэх сайн туршлага бол вирусын нөлөөнд өртсөн болон тусгаарлагдах шаардлагатай хүмүүсийг үйлчилгээ бүхий түр орон байраар (ашиглаагүй эсвэл эзэнгүй орон сууцны хэсэгт, богино хугацаагаар түрээслэх боломжтой түрээсийн байр) яаралтай хангах явдал юм.
- Орон байргүй болох хүмүүсийн тоо нэмэгдэхээс урьдчилан сэргийлэхэд эрх бүхий байгууллагаас онцгой анхаарах ёстой юм. Жишээ нь хүмүүс орлогогүй болоход байрны зээл болон түрээсийн төлбөрөө төлөх боломжгүй болж, улмаар байраа чөлөөлөхөөс аргагүйд хүрдэг. Байрнаас албадан гаргах болон байрны зээлийн төлбөр авахыг хойшлуулах зэрэг сайн туршлагыг өргөнөөр хэрэглэх нь зүйтэй юм.
- Хөл, хөдөлгөөнийг хязгаарлах арга хэмжээг хэрэгжүүлж байх үед хүнийг орон байргүйн төлөө эсвэл муухан оромжид амьдардагийнх нь төлөө хэнийг ч шийтгэж үл болно.

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс

- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс Ковид-19 өөр өвчлөх магадлал өндөр байдаг бөгөөд улс орнууд тэдэнд зориулж тусгайлсан зорилтот хариу арга хэмжээ авах хэрэгтэй. Гамшгийн хариу арга хэмжээ, эрүүл мэнд, нийгмийн хамгааллийн үйл ажиллагаа нь хүн бүрт хүртээмжтэй байх ёстой бөгөөд хөгжлийн бэрхшээлтэй хүнийг ялгаварлан гадуурхаж болохгүй.

ОИИ.МН
СУДАЛГААНЫ САН

- Зай барих, өөрийгөө тусгаарлах болон бусад онц байдлын үеийн арга хэмжээг авч хэрэгжүүлэхдээ хөгжлийн бэрхшээлтэй иргэний хэрэгцээ шаардлагыг харгалзан үзэх хэрэгтэй. Учир нь тэдэнд зориулсан тусламжийн сүлжээ зайлшгүй шаардлагатай бөгөөд тэдний зарим нь тусгаарлалтаас үүдэн сэтгэл санааны хямралд орох өндөр магадлалтай байдаг.
- Төрийн зүгээс хямралын туршид хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст үзүүлдэг дэмжлэг, үйлчилгээг тасалдуулахгүйн тулд нэмэлт арга хэмжээ авах ёстой. Одоо байгаа хөл хорио, хязгаарлалт гэр бүлийн болон нийгмийн үйлчилгээ, тусламжийн сүлжээнд саад үүсгэвэл эдгээрийг орлох өөр бусад үйлчилгээг үзүүлэх хэрэгтэй.
- Хязгаарлагдмал нөөцтэй эд хэрэглэгдэхүүн (тухайлбал хүчилтөрөгчийн аппарат) хуваарилахдаа өмнөх гэмтэл, туслалцаа авах зайлшгүй шаардлага, амьдралын чанарын үнэлгээ, эсхүл тухайн хөгжлийн бэрхшээлтэй хүний эсрэг анагаах ухааны өрөөсгөл хандлагад үндэслэхгүй байх.
- Төр боллоцоо гарах бүрт хөгжлийн бэрхшээлтэй хүнийг эмнэлэг, асрах байр, сэтгэцийн эмнэлэг болон бусад газраас гаргах, тийм байгууллагад буй хүнийг зохих хамгаалалаар ханган ажиллах хэрэгтэй.
- Нэмэлт санхүүгийн дэмжлэг болон нийгмийн халамж үйлчилгээний хүртээмжтэй байдал нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс болон тэдний ар гэрийнхэнд их чухал юм. Учир нь тэдний ихэнх нь түр хугацаагаар зогсоогоод буй үйлчилгээнээс хамааралтай байдаг бөгөөд наад захын хэрэгцээгээ хангах боломж боллоцоо хомс байдаг.

Өндөр настай хүмүүс

- Ахмад настанууд нь бусад аливаа бүлгийн хүмүүстэй адил эрхтэй бөгөөд цар тахлын үеэр мөн адил хамгаалагдах хэрэгтэй. Тусгаарлалтаас үүдэлтэй ганцаардал, үл хайхрагдах явдал болон эрүүл мэндийн тусламж болон бусад үйлчилгээ авах хүртээмжид гардаг насаар ялгаварласан гадуурахлт зэрэг ахмад настанд тулгарч болох онцлог эрсдэлд онцгойлон анхаарах хэрэгтэй.
- Эмнэлгийн шийдвэрийг хувь хүний эмнэлзүйн үнэлгээ, эрүүл мэндийн шаардлага, ёс зүй болон шинжлэх ухааны нотолгоонд суурилж гаргах ёстой бөгөөд нас эсвэл хөгжлийн бэрхшээлд суурилах ёсгүй.

Хорих газар болон саатуулах байруудад буй хүмүүс

- Эрх чөлөөгөө хязгаарлуулсан хүмүүс, тухайлан шорон, цагдан хорих байр, цагаачлалын хорих байр, байгууллага болон бусад цагдан хорих

байруудад байгаа хүмүүс нь вирус тархсан тохиолдолд халдвар авах хамгийн эрсдэл өндөр бүлэгт орно. Тэнд халдвар тархах өндөр эрсдэлтэй бөгөөд нийгмээс тусгаарлах арга хэмжээг хэрэгжүүлэхэд хүндрэлтэй байх болно. Хямралын нөхцөлийг даван туулах төлөвлөлт хийж, хариу арга хэмжээ авахдаа эдгээр хүмүүсийн нөхцөл байдлыг тусгайлан шийдвэрлэх нь зүйтэй юм.

- Төрийн зүгээс эрх чөлөөгөө хязгаарлуулсан хүмүүсийг мэдээлэл авах, урьдчилан сэргийлэх болон эрүүл мэндийн бусад үйлчилгээг эрх тэгш авах боломжоор хангахад зориулж тусгай арга хэмжээ авах хэрэгтэй.
- Төр хорих, саатуулах байруудад гарч болзошгүй аливаа хор хохирлын эрсдлийг бууруулах үүднээс хөнгөн, жижиг зөрчил гаргасан, хүчирхийллийн бус гэмт хэрэг үйлдсэн, суллагдах хугацаа нь дөхсөн, цагаачийн түр саатуулах байранд болон цагаачлалын зөрчилтэй байдлаасаа саатуулагдаж буй хүмүүс, шилжих хөдөлгөөний статуснаасаа үүдэн баривчлагдсан, эрүүл мэндийн суурь шалтгаантай, цагдан хорих болон баривчлах байранд байгаа хүмүүсийг суллах эсвэл хорихоос өөр арга хэмжээг яаралтай эрэлхийлэх хэрэгтэй. Хууль зүйн үндэслэлгүй баривчлагдсан мөн мансууруулах, согтууруулах донтныг албадан эмчилэх байгууллагад эмчлүүлж буй хүмүүсийг суллах хэрэгтэй.
- Хүүхдэд оногдуулсан хорих арга хэмжээг хойшлуулах хэрэгтэй бөгөөд төр суллахад аюул учруулахгүй бүх хүүхдийг суллах хэрэгтэй.
- Аливаа асрамж, сувилалын газарт буй ялангуяа хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс болон ахмад настнуудын нөхцөл туйлын хүнд болно. Нэг талаасаа онцгой эрүүл мэндийг арга хэмжээний хүрээнд гэр бүлийнхэнтэйгээ уулзаж, харьцахыг нь хязгаарлаж болох ч энэ нь хөгжлийн бэрхшээлтэй болон настай хүмүүс анхаарлын гадна орхигдох, дарамт, хүчирхийлэлд өртөх эрсдлийг бий болгож болзошгүй юм. Нутгийн хамт олонд суурилсан дэмжлэг болон хүчирхийллээс урьдчилан сэргийлэх хүртээмжтэй арга хэрэгсэл бий болгосон байх хэрэгтэй.

Мэдээлэл болон оролцоо

- Ковид-19 цар тахалтай холбоотой аливаа мэдээлэл, хариу арга хэмжээ нь хүн бүрт хүрэх ёстой. Үүний тулд мэдээллийг амар хялбар ойлгогдох хэлбэрээр бичих, тусгай хэрэгцээт бүхий хүмүүс, тухайлан харааны болон сонсголын бэрхшээлтэй хүмүүст тохирсон хэлбэрээр мэдээллийг хүргэх, мөн унших чадвар хязгаарлагдмал, уншиж чаддаггүй эсвэл интернэтэд холбогдох боломжгүй хүмүүст мэдээллийг хүртээмжтэй байдлаар хүргэх нь зүйтэй юм.

ОИХ.МН
СУДАЛГААНЫ САН

- Вирус халдсан хүмүүст мэдээлэл хүргэхэд интернэт ашиглах боломжтой байх нь нэн чухал юм. Төр засаг зүгээс интернэтийн хэрэглээг доголдуулах, хаах явдлыг зогсоож, интернэт хэрэглээг нээлттэй байлгах хэрэгтэй. Мөн интернэтийн үйлчилгээ авах боломжийг аль болох өргөнөөр бий болгож, жендэрийн зөрүүтэй байдал зэрэг дижитал хуваагдалтыг арилгахад чиглэсэн арга хэмжээ авах нь зүйтэй юм.
- Хүмүүс өөрсдийнх нь амьдралд нөлөөлөх аливаа шийдвэр гаргахад оролцох эрхтэй. Нээлттэй, ил тод байж, нөлөөлөлд өртсөн хүмүүсийг шийдвэр гаргах явцад оролцуулах нь өөрсдийнх нь болоод нийтийн эрүүл мэндийг хамгаалахад чиглэсэн арга хэмжээнд хүмүүсийн оролцоог хангахад чухал бөгөөд тэдгээр арга хэмжээнүүд нь эргээд тухайн иргэний онцлог нөхцөл шаардлагын тусгал болж байдаг.
- Эмнэлгийн мэргэжилтнүүд болон эрдэмтэд өөр хоорондоо болон олон нийттэй чөлөөтэй ярьж, үнэн зөв, чухал мэдээллийг хуваалцах боломжтой байх ёстой. Сэтгүүлчид болон хэвлэл мэдээллийн салбар цар тахлын мэдээллийг, түүний дотор ямар нэгэн айдас, хязгаарлалтгүйгээр Засгийн газраас явуулж буй чухал арга хэмжээний талаарх мэдээ мэдээллийг хүргэх боломжтой байх ёстой юм. Айдас түгшүүр болон шударга бус явдлыг дэвэргэх аливаа худал, хуурмаг, төөрөгдүүлэх мэдээлэлтэй тэмцэхийн тулд үндэсний болон олон улсын түвшинд ихээхэн хүчин чармайлт гаргах ёстой.
- Олон улсын, бүсийн болон үндэсний Ковид-19-ийн талбарт эмэгтэйчүүдийн төлөөлөл, манлайллын үүрэг ролийг оролцуулах зэргээр тархалтын үеийн бэлэн байдал болон хариу арга хэмжээний үед эмэгтэйчүүдийн үзэл бодол, дуу хоолой болон тэдний мэдлэг, мэдээллийг авч тусгах нь чухал юм.

Шившиглэх, гадаад хүмүүсийг үзэн ядах үзэл болон арьсны өнгөөр ялгаварлах үзэл

- Ковид-19 цар тахал нь тодорхой нэг үндэстэн, ястны хүмүүсийн эсрэг ялгаварлан гадуурхалт, шившиглэлт, арьс өнгөөр ялгаварлах үзэл болон гадаад хүмүүсийг үзэн ядах үзлийг улам бүр өдөөж байна. Бид бүгд энэ хандлагын эсрэг хамтдаа тэмцэх хэрэгтэй байна. Тухайлбал энэ өвчнийг ямар нэгэн газарзүйн байршлаар нэрлэхээс илүүтэйгээр Ковид-19 гэж нэрлэх нь зүйтэй юм.
- Улс төрийн манлайлагчид, бусад нөлөө бүхий хүмүүс энэхүү хямралын үед улам бүр гаарч буй шившиглэлт, арьс өнгөөр ялгаварлан гадуурхах үзлийн эсрэг хүчтэй дуу хоолойгоо хүргэх хэрэгтэй бөгөөд ийм төрлийн ялгаварлан гадуурхалтыг дэвэргэх явдлаас ямар ч үнээр хамаагүй

зайлсхийх ёстой юм. Айдас түгшүүрийг улам бүр дэвэргэх аливаа уран хоосон үг, худал мэдээлэлтэй тэмцэх арга хэмжээг төрийн зүгээс яаралтай авах хэрэгтэй бөгөөд Ковид-19-тэй холбоотой авч буй хариу арга хэмжээ нь тодорхой нэг бүлгийн хүмүүсийг хүчирхийлэл, дарамт, ялгаварлан гадуурхалтад улам өртөх явдлыг бий болгохгүй талаас нь байх ёстой.

- Буруу ташаа мэдээлэл болон айдас түгшүүрээр гаарч байдаг ялгаварлан гадуурхалт болон гадаад хүмүүсийг үзэн ядах үзлийн эсрэг тэмцэх хамгийн үр дүнтэй арга бол үнэ зөв, тодорхой, үндэслэл нотолгоонд суурилсан мэдээлэл түгээж, мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх аян зохион байгуулах явдал юм. Ялгаварлан гадуурхалт болон гадаад хүмүүсийг үзэн ядах үзлээс үүдэлтэй аливаа хэрэг, тохиолдолд мониторинг хийхэд нэмэлт хүчин чармайлт гаргах шаардлагатай бөгөөд гарсан аливаа хэрэг, тохиолдолд шуурхай арга хэмжээ авч, олон нийтэд сайтар мэдээллэх нь зүйтэй.
- Ялгаварлан гадуурхалт болон бугшсан тэгш бус байдал нь нийгмийн зарим бүлэг, үндэстний, арьс өнгө болон угсаатны цөөнхийн эрүүл мэндэд сөргөөр нөлөөлдөг байна. Цар тахалтай тэмцэж, Ковид-19-өөс ангижрахын тулд ангилсан мэдээллийг цуглуулж эдгээр асуудлыг шийдвэрлэх хэрэгтэй.

Цагаачид болон дүрвэгсэд

- Цагаач, дотоододоо шилжин суурьшигч, дүрвэгсдийн хувьд нэг бол хуаран, гацаанд байх эсвэл хэт бөөгнөрсөн, ариун цэврийн нөхцөл муу, хэт их тархсан эсвэл эрүүл мэндийн үйлчилгээ хүртээмжгүй хотод амьдардаг тул тодорхой эрсдлүүдтэй тулгардаг. Цагаачдыг түр саатуулах байр эсвэл цагаач, дүрвэгсдийн эрх чөлөөг хасах зориулалт бүхий өөр газар тусгаарлагдсан хүмүүс онцгой эрсдэл байна.
- Цагаачид болон дүрвэгсэд хувьд хэл, соёлын саад бэрхшээл, төлбөр мөнгө, мэдээллийн хүртээмжгүй байдал, ялгаварлан гадуурхалт болон гадаад хүмүүсийг үзэн ядах үзлээс болж эрүүл мэндийн эмчилгээ үйлчилгээ авахад ихэвчлэн хүндрэл бэрхшээлтэй тулгардаг байна. Хууль бус нөхцөл байдалд буй цагаачид эрүүл мэндийн үйлчилгээнд хамрагдах эсвэл өөрийн эрүүл мэндийн байдлын талаарх мэдээлэл өгөх боломжгүй эсвэл өгөх хүсэлгүй байдаг байна. Учир нь тэд цагаачлалын статусаасаа болж баривчлагдаж, нутаг буцаагдах эсвэл ял шийтгэл авах вий гэсэн айдастай байдаг ажээ.
- Төр засгийн зүгээс үндэсний хэмжээнд Ковид-19-өөс урьдчилан сэргийлэх болон хариу арга хэмжээнд цагаачид болон дүрвэгсдийг

хамруулах үүднээс тодорхой арга хэмжээг авах нь зүйтэй юм. Үүнд статусаас нь үл хамааран бүх цагаачид болон дүрвэгсдийг мэдээлэл авах, сорил өгөх болон эрүүл мэндийн үйлчилгээнд тэгш хүртээмжтэй байдлаар хамрагдах боломжоор хангах, тэднийг эрүүл мэндийн болон бусад зайлшгүй шаардлагатай үйлчилгээ авах боломжийг нь гадаадын иргэн, харьяат, цагаачдад хамаарх хууль сахиулах үйл ажиллагаанаас нь ялгаж салгах хамгаалалтаар хангах хэрэгтэй.

- Хүлээн авагч улс орнууд цагаачид болон өөрсдийн иргэдэд аль алинд нь үзүүлэх үйлчилгээг эрчимжүүлж, тэднийг үндэсний ажиглалт тандалт, урьдчилан сэргийлэх болон хариу арга хэмжээнд хамруулахад олон улсын дэмжлэг туслалцаа нэн шаардлагатай юм. Дээрх арга хэмжээг хэрэгжүүлж чадахгүй аваас бүх хүмүүсийн эрүүл мэндийг эрсдэлд оруулж, дайсагнал, шившиглэлийг улам нэмэгдүүлэх эрсдлийг бий болгож болзошгүй. Цагаачдын эсрэг дайсагнал болон гадаад хүмүүсийг үзэн ядах үзэлтэй тэмцэх тусгайлсан арга хэмжээнүүдийг авах нь зүйтэй юм.
- Мөн хилийн хяналтыг чангатгах, аялал жуулчлалыг хязгаарлах эсвэл чөлөөтэй зорчих эрхийг хязгаарлах явдал нь дайн болон хавчлага мөрдлөгөөс зугтаж буй эсвэл аюулгүй байдал, хамгаалалт хүсч буй нэгэнд саад болох ёсгүй юм. Төр цагаачдыг түр саатуулах байрнаас суллах, тэднийг албадан гаргах асуудлыг түр хойшлуулах нь цагаачид, цагаачлалын албаны ажилтнууд болон нийгмийг бүхэлд нь хамгаална.

Нийгмийн болон эдийн засгийн үр нөлөө

- Сургуулиудыг хаасан тохиолдолд ч цахимаар суралцах боломжоор хангах зэргээр суралцагчдын сурч боловсрох эрхийг хамгаалах нь зүйтэй юм. Олон охид сургуульд явахад ихээхэн саад бэрхшээлтэй тулгардаг тул энэ тохиолдолд охидууд илүү өртөх магадлалтай бөгөөд тэдний ар гэрийн ажлын ачаалал нэмэгдэх хандлагатай болохыг үгүйсгэхгүй. Түүнчлэн сургуулиас олгодог тэжээллэг хоол хүнс болон бусад үйлчилгээг охид, хөвгүүд авч чадахгүйд хүрэх байх.
- Нийгэм хамгааллын хөтөлбөр хүүхдүүдэд онцгой анхаарал хандуулах шаардлагатай юм. Учир нь тэд бие махбод, оюун санаа, сэтгэл зүйн хөгжлийн эхэн үедээ их эмзэг байдаг. Хүүхдийн эрхийг хамгаалах сайн туршлагаас дурдвал хүүхэдтэй гэр бүлд бэлэн мөнгө шилжүүлэх нь хүүхдийн эрхийг хамгаалахад үр нөлөөтэй арга хэмжээ юм.
- Энэхүү хямралаас үүдэн гарч буй нийгэм-эдийн засгийн сөрөг үр нөлөөг бууруулахаар Засгийн газар, төрийн болон хувийн хэвшлийн салбар, олон улсын болон үндэсний байгууллагуудаас авч буй хэрэгжүүлж буй сайн туршлагаа өөр хоорондоо солилцож, мэдээллэх нь чухал юм.

- Хямралын үед ажиллаж буй тэр дундаа эмэгтэйчүүд зонхилдог эрүүл мэндийн ажилтнууд, тэдний туслах ажилтнуудын хөдөлмөрийн эрүүл ахуй, аюулгүй байдлын асуудлыг тогтмол үнэлж, шийдвэрлэж байх нь зүйтэй. Эрүүл мэндийн ажилтнууд болон бусад өндөр эрсдэлтэй орчинд ажиллаж буй хүмүүсийг чанартай хувийн хамгааллын хувцас хэрэглэлээр хангах хэрэгтэй. Ажлаа алдах эсвэл цалин мөнгөгүй болох вий гэсэн айдсаасаа болж өөрсдийн эрүүл мэндээ ямар ч шаардлагагүйгээр эрсдэлд оруулах нөхцөлд хэнийг ч албадан ажиллуулж болохгүй.
- Хямралыг даван туулах чадвар бага хүмүүст чиглэсэн татварын урамшуулал болон нийгэм хамгааллын багц нь цар тахлын асар хор хөнөөлтэй үр дагаварыг бууруулах ач холбогдолтой. Эдийн засгийг сэргээх яаралтай арга хэмжээ нь, тухайлбал өвчтэй үед цалинтай чөлөө олгох, ажилгүйдлийн тэтгэмжийг сунгах болон, хоол хүнс түгээх, хүүхдийн халамж болон наад захын хэрэгцээг нь хангах тэтгэмж олгох нь хямралаас үүдэн гарах ноцтой үр дагавраас урьдчилан сэргийлэхэд тустай юм.

Хүнс

- Ковид-19 хямралын уршиг хүнсний аюулгүй байдлыг улам дордуулж байна. Учир нь зорчих эрхийн хязгаарлалт, хамгаалах хэрэгслийн хомс байдалтай холбоотойгоор дийлэнх нь цагаачид ажилчид байдаг хөдөө аж ахуйн салбарт сөргөөр нөлөөлж байна. Хүнсний үйлдвэрлэлийг хангахын тулд хөдөө аж ахуйн ажиллагчдыг зорчих, аюулгүй нөхцөлд ажиллуулах арга хэмжээг яаралтай авах хэрэгтэй. Ингэхдээ жижиг хэмжээний аж ахуй эрхлэгчдэд, тэр дундаа эмэгтэйчүүдэд чиглэсэн санхүүгийн дэмжлэг, зээл авах боломж, худалдаа эрхлэх боломж болон үр зэрэг хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний тусламж үзүүлэх хэрэгтэй.
- Хүн амын нэн ядуу болон янз бүрийн шалтгааны улмаас гадуурхагдсан хэсгийн хүнсний аюулгүй байдлыг яаралтай шийдвэрлэх алхмыг авч хэрэгжүүлэх хэрэгтэй байна. Хүнс тэжээлийн хэрэгцээг хангахад шууд дэмжлэг үзүүлэхэд чиглэсэн хоол хүнс түгээх, хүнс тэжээлийн тусламж үзүүлэх зэрэг арга хэмжээг авах хэрэгтэй юм.

Хувийн нууц

- Эрүүл мэндэд хяналт тавих гэдэгт хувь хүмүүсийн зан авир болон үйл хөдлөлийг тогтоож, хянадаг янз бүрийн арга хэрэгсэл орно. Ийм төрлийн ажиглалт, хяналтыг зөвхөн нийтийн эрүүл мэндийн тодорхой зорилгын хүрээнд ашиглаж, тухайн нөхцөл байдалд шаардагдсаны дагуу үргэлжлэх хугацаа болон хамрах хүрээ нь хэмжээ, хязгаартай

УИАН
СУДАЛГААНЫ САН

байх ёстой. Эдгээр арга хэмжээг төр эсвэл компани хувь хүний нууц мэдээллийг нийтийн эрүүл мэндийн хямралтай холбоотой бус өөр зорилгоор ашиглахгүй байх тал дээр хатуу хяналт тавьж баталгаа гаргах хэрэгтэй.

Хүүхэд

- Ковид-19-өөр өвчилсөн хүүхдэд цөөн шинж тэмдэг илэрч, эндэгдлийн тоо бага байгаа боловч, вирусээс урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ нь хүүхэд өдөр тутамдаа эрсдэлд орох нөхцлийг бүрдүүлж байна. Улс орнууд ковидын хариу арга хэмжээ болон эмчлэх төлөвлөгөө хэрэгжүүлэхдээ хүүхэд хамгаалал болон хүүхдийн эрхэд анхаарлаа улам нэмэгдүүлэх хэрэгтэй. Хариу арга хэмжээ хэрэгжүүлэхэд хүүхдийн дээд ашиг сонирхлыг эн тэргүүнд харгалзах ёстой.
- Дэлхийн 188 орон улс даяараа сургуулиа хааснаас үүдэлтэй 1.5 тэрбум хүүхэд сурч боловсрох эрхээ эдлэж чадахгүйд хүрээд байна. Ихэнх тохиолдолд охид сурч боловсрохынхоо хажуугаар гэрийн ажил, асран халамжлах үүрэгтэй байдаг, мөн зайнаас сурах боломжийн хувьд тэгш бус боломжтой, сургуулиа бүр мөсөн орхих эрсдэлтэй байдаг зэргээс үзэхэд охид хамгийн их хохирч үлдэх төлөвтэй байна. Энэ нь тэдний боловсрол, эрүүл мэнд болон эдийн засгийн боломжид урт хугацааны нөлөө үзүүлж байна.
- Гэртээ байх дэглэм болон хөл хорио нь хүүхдийн бие бялдарын болон сэтгэхүйн эрүүл мэндийг гэмтээж байна. Гэртээ тусгаарлагдах нь хүүхэдтэй зүй бусаар харьцаа, бэлгийн хүчирхийлэл зэрэг хүчирхийллийн хэлбэрүүдэд өртөх эрсдлийг нэмэгдүүлж байна. Эрсдэлт бүлгийн хүүхдэд зориулсан тусламж үйлчилгээ болон хамгаалах байрнуудын үйл ажиллагааг үргэлжлүүлэх нэн шаардлагатай.
- Сая сая хүүхдүүд гэр бүлийн гишүүд нь өвдсөн, эсвэл ажиллах боломжгүй болсонтой холбоотойгоор ядууралтай нүүр тулж байна. Тэр дундаа эмзэг бүлгийн хүүхдүүд болох орон гэргүй хүүхэд, цагаач, дүрвэгчдийн хүүхэд, хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч хүүхэд, мөргөлдөөнтэй бүс нутагт амьдарч буй хүүхэд, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд өндөр эрсдэлтэй нөхцөлд байна.


Залуус

- Ковид-19 цар тахал тархахаас өмнө дэлхийн таван залуу тутмын нэг нь ажилгүй, боловсролын буюу сургалтын байгууллагад хамрагдаагүй байсан бөгөөд залуусын ажилгүйдлийн түвшин бусад насны бүлгээс гурав дахин их байв. 2007 оны дэлхийн санхүүгийн хямрал залууст илүү нөлөөлсөн бөгөөд тэр дундаа далд эдийн засагт ажиллах магадлалтай, бага цалин хөлс авдаг, баталгаа, хамгаалалт харьцангуй доогуур ажлын байранд ажилд орох төлөвтэй охид, бүсгүйчүүд илүү өртсөн. Улс орнууд цар тахлын эсрэг авах хариу арга хэмжээнийхээ хүрээнд залуусын тусгай хэрэгцээг харгалзсан, эрхийг нь хүндэтгэсэн, зохистой ажлын байр болон нийгмийн хамгааллын зэрэг арга хэмжээг тусгах нь зүйтэй.

Жендэр

- Ковид-19 цар тахлын эсрэг хариу арга хэмжээг авч хэрэгжүүлэхдээ охид, эмэгтэйчүүд болон ЛГБТИ хүмүүсийн онцгой нөхцөл байдал, шаардлагыг харгалзан үзэж тэднийг шууд болон шууд бусаар жендэрээр ялгаварлан гадуурхахгүй байх ёстой.
- Охид, эмэгтэйчүүдийн хувьд гэр орноо авч явах үүрэг роль нь нэмэгдэх хандлагатай бөгөөд энэ нь тэднийг стресст илүү оруулж, улмаар халдвар авах эрсдлийг нэмэгдүүлж болзошгүй юм. Дэлхий даяар, эрүүл мэндийн ажиллагчдын 70 хувь нь эмэгтэйчүүд байна. Үүнд эх баригч, сувилагч, эмийн санч, нийгмийн эрүүл мэндийн ажилтан орж байгаа нь тэднийг вирус авах эрсдлийг нэмэгдүүлж байна. Хямралын үр нөлөөнд охид, эмэгтэйчүүдэд илүү өртөж буй явдлыг шийдвэрлэхийн тулд тэдэнд чиглэсэн тусгайлсан арга хэмжээ авах хэрэгтэй.
- Олон улс орнуудад эмэгтэйчүүдийн дийлэнх нь албан бус ажлын талбарт (гэрийн үйлчлэгч, хүүхэд асрагч, газар тариалан болон гэр бүлийн бизнест туслах ажил хийдэг) ажилладаг бөгөөд тэд хамгийн түрүүнд ажлаа алдах эсвэл нийгмийн болон эрүүл мэндийн даатгалгүй, цалинтай чөлөө авах боломжгүй тул хямралаас гарах үр нөлөөнд хамгийн ихээр өртөх эрсдэлтэй байдаг. Түүнчлэн олон эмэгтэйчүүд хүртээмжтэй, боломжийн үнэтэй хүүхдийн халамж, үйлчилгээнээс хамааралтай байдаг бол, дээрх үйлчилгээний хүртээмж багассанаар тэдний ажиллаж, орлого олох боломж бололцоо хязгаарлагдаж байна.
- Настай эмэгтэйчүүдийн хувьд ядуурлын түвшинд амьдрах, маш бага эсвэл ямар ч тэтгэвэрийн орлогогүй амьдрах нөхцөл байдалд ороод байгаа бөгөөд энэ нь вирусын сөрөг үр нөлөөг улам нэмэгдүүлж, тэдний бараа бүтээгдэхүүн, хоол хүнс, цэвэр ус, мэдээлэл болон эрүүл мэндийн үйлчилгээ авах боломжийг хязгаарлах эрсдэлтэй байна.

- Нийтийн эрүүл мэндийн төлөө авч буй хатуу арга хэмжээнүүд нь, тухайлбал хол хорио нь жендэрт суурилсан хүчирхийлэл, ялангуяа дотно-хамтрагчийн зүгээс үйлдэх хүчирхийлэл болон гэр бүлийн хүчирхийлэлд өртөх эрсдлийг улам нэмэгдүүлж байна. Жендэрт суурилсан хүчирхийллийн хохирогчдод зориулсан туслах үйлчилгээ болон түр хамгаалах байрын үйлчилгээг эн тэргүүнд хэвээр байлгах шаардлагатай бөгөөд хохирогчдыг холбогдох газарт нь үр дүнтэйгээр холбож өгөх, тэдний аюулгүй байдлын хүрэлцээтэй, хүртээмжтэй байдлыг хангах нь чухал юм. Иргэд рүү Ковид-19-тэй холбоотой зурвас илгээхдээ 24 цагийн дуудлагын утас болон цахим үйлчилгээний талаарх мэдээллийг мөн тусгах нь зүйтэй юм.
- Бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэндийн үйлчилгээг хариу арга хэмжээний амин чухал, салшгүй нэг хэсэг гэж үзэх ёстой бөгөөд үүнд жирэмслэлтээс хамгаалах арга хэрэгсэл хэрэглэх боломж, эх болон нярайн эмчилгээ үйлчилгээ, БЗХӨ-ний эмчилгээ, аюулгүй үр хөндөлтийн эмчилгээ болон холбогдох газарт нь үр дүнтэйгээр холбож өгөх үйлчилгээнүүд орно. Нэн ялангуяа охид, эмэгтэйчүүдийн амьдрал болон хүний эрхэд нь нөлөөлөх зайлшгүй шаардлагатай бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэндийн үйлчилгээнд зарцуулах нөөц, хөрөнгийг өөр чиглэлд хувиарлахгүй байх хүчин чармайлтыг гаргах ёстой.
- ЛГБТИ хүмүүс цар тахлын үед өндөр эрсдэлтэй нүүр тулж буй тул үүний үр дагаварыг шийдвэрлэх тэдэнд чиглэсэн онцлог арга хэмжээг авч хэрэгжүүлэх хэрэгтэй байна. ЛГБТИ хүмүүс гол төлөв албан бус салбарт ажиллах төлөвтэй байдаг ба тэдний дунд ажилгүйдлийн түвшин болон ядуурлын түвшин өндөр байдаг тухай мэдээлэл байдаг. Энэ хямралын үеэр ЛГБТИ хүмүүстэй холбоотой үйл ажиллагаа явуулдаг эрүүл мэндийн төвүүд тухайлбал ХДХВ-ийн шинжилгээ авч, эмчилгээ хийх үйлчилгээг тасралтгүй үргэлжлүүлэх хэрэгтэй байна.
- Улс төрчид болон бусад нөлөө бүхий хүмүүс цар тахлын үед ЛГБТИ хүмүүс рүү чиглэсэн шившиглэсэн, үзэн ядалтын шинжтэй ярианы эсрэг нийгэмд дуу хоолойгоо хүргэх хэрэгтэй.
- Гэртээ байх хязгаарлалтын улмаас ЛГБТИ залуус өөрсдийг нь дэмждэггүй гэр бүлийн гишүүд эсвэл хамт амьдардаг хүмүүсийн дайсагнасан орчинд байгаагаас тэд хүчирхийлэл, түгшүүр, сэтгэл гутралд улам бүр өртөх эрсдэлтэй боллоо. Улс орнууд энэ цаг үед тусламжийн үйлчилгээ, хамгаалах байрны үйл ажиллагааг нээлттэй байлгах хэрэгтэй.



Ус, ариутгал, ариун цэвэр

- Ковид-19-ийн эсрэг тэмцэх хамгийн эхний алхам бол гараа савантай цэвэр усаар угаах юм. Гэвч дэлхий дээр 2.2 тэрбум хүн цэвэр ус болон эрүүл ахуйгаар хангагдаж чадахгүй байна. Цэвэр усаар хангагдах боломж тэгш бус, хангалтгүй байгаа хүмүүс, тэр дундаа охид, эмэгтэйчүүд зэрэг эмзэг бүлгийнхний цэвэр ус, ариутгал, ариун цэврийн хэрэгцээг шийдвэрлэх нь Ковид-19-ийн эсрэг дэлхий даяараа амжилттай тэмцэхэд ихээхэн ач холбогдолтой юм.
- Усны төлбөрөө төлж чадахгүй хүмүүсийн усны хэрэглээг таслахыг хориглох, ядуурлын түвшинд амьдарч буй болон эдийн засгийн хүндрэлийн нөлөөнд өртөж буй хүмүүст хямралын туршид усыг үнэгүй олгох (тухайлбал, хангалттай эрүүл ахуйн үйлчилгээ авч чадахгүй байгаа газарт зөөврийн ариутгагч байршуулах замаар) зэрэг яаралтай арга хэмжээ нь дээрх хүмүүст дэм болох юм.

Нутгийн уугуул иргэд

- Төрөөс нутгийн уугуул хүмүүсийн уламжлалт эмнэлэг зэрэг эрүүл мэндийн онцлог үзэл ойлголтыг харгалзан үзэж, Ковид-19-өөс урьдчилан сэргийлэх арга хэмжээ боловсруулахдаа уугуул иргэдэд урьдчилан мэдэгдэж, өөрсдөө зөвшөөрснөөр хамрагдах боломжоор хангах нь зүйтэй.
- Төрөөс уугуул хүмүүсийн нутаг дэвсгэрт гаднаас хүн нэвтрэхэд хяналт тавих арга хэмжээг уугуул хүмүүстэй, тэдгээрийн төлөөлөгчийн байгууллагаар дамжуулан хэлэлцэж, хамтран ажиллах байдлаар хэрэгжүүлэх.
- Сайн дурын тусгаарлалтад байгаа, эсхүл ойрын хавьталд хамаарах уугуул хүмүүсийн хувьд Төр болон бусад талууд тухайн уугуул хүмүүсийг онцгойлон эмзэг бүлэг гэж тооцох хэрэгтэй. Эдгээр хүмүүсийн байрлаж буй газар гадны хүн нэвтрэхээс хамгаалах хамгаалалтыг нарийн чанд зохион байгуулж аливаа хавьталтаас урьчилан сэргийлэх хэрэгтэй.

Цөөнх

- Төрөөс ихэвчлэн наад захын бараа, үйлчилгээ хязгаарлагдмал алслагдсан газар, бүс нутагт амьдардаг үндэстний цөөнхөд Ковид-19 цар тахлаас үүдэн гарах үр нөлөөг тооцон нэмэлт арга хэмжээ авч хэрэгжүүлэх хэрэгтэй. Цөөнхийн бүлэг ихэвчлэн олуулаа амьдардаг бөгөөд энэ нь хоорондын зай барих, өөрийгөө тусгаалах асуудлыг

УНДАН
СЭДАЛ ААНЫ САН

илүү хүндрэлтэй болгодог. Мөн дижитал төхөөрөмжийн хүртээмж хязгаарлагдал байдаг болон эцэг эхийн боловсролын дутмаг байдал нь гэр-сургуулийн асуудлыг төвөгтэй болгодог.

- Цөөнхийн бүлэгт хамаарах хүмүүс албан ёсны бичиг баримт дутуу, эсхүл бусад нөөц боломж тааруу, эсхүл ялгаварлан гадуурхалтаас шалтгаалан эрүүл мэндийн халамж, үйлчилгээ авч чадахгүй байх магадлалтай байна. Төрөөс үндэстний цөөнхийг, тэдгээрийн дотор эрүүл мэндийн даатгал, эсхүл биеийн байцаалтгүй иргэдийг эрүүл мэндийн тусламж үйлчилгээ авах боломжоор хангах шаардлагатай.

Бизнес ба хүний эрх

- Бүх бизнесийн байгууллага НҮБ-ын Бизнес ба хүний эрхийн удирдах зарчимд заасны дагуу эдийн засгийн хүндрэл, нийтийг хамарсан эрүүл мэндийн хямралын үед, мөн Төрөөс үүргээ биелүүлж байгаа эсэх, хэрхэн гүйцэтгэж байгаагаас үл хамааран хүний эрхийг хүндэтгэн сахих өөрийн үүрэгтэй.
- Төрөөс бизнесийн байгууллагуудад Ковид-19 цар тахлын эдийн засгийн үр нөлөөг бууруулахаар эдийн засгийн тусламж, урамшууллын багц, эсхүл өөр зорилгод хөнгөлөлтийг үзүүлэхдээ тухайн байгууллагууд НҮБ-ын Бизнес ба хүний эрхийн удирдах зарчмыг дагаж мөрдөнө гэж заах ёстой. Хямралын үед төрөөс компаниудыг дэмжих арга хэмжээний цөм нь ажилчлагдыг хамгаалах, ялангуяа хамгийн эрсдэлтэй нөхцөлд байгаа хүмүүсийг хамгаалах асуудал байх хэрэгтэй.

Олон улсын болон нэг талын хориг арга хэмжээ

- Олон улсын хамтын нийгэмлэг Ковид-19 цар тахалтай амжилттай тэмцэх боломжид саад болж байгаа болон зайлшгүй эмнэлгийн туслалцаа шаардлагатай хүмүүсийг тусламж авахад саад учруулж байгаа бүх хориг арга хэмжээг зогсоох, эсхүл дор хаяж түдгэлзүүлэх талаар нөлөөлөх хэрэгтэй.
- Хориг арга хэмжээ авсан засгийн газрууд Ковид-19 цар тахлын хариуд аливаа засгийн газрын хэрэгжүүлж байгаа арга хэмжээнд саад болохуйц хориг арга хэмжээнүүдийг яаралтай дахин нягтлах, цуцлах шаардлагатай. Үүнд эм, эмнэлгийн төхөөрөмж, эсхүл бусад шаардлагатай бүтээгдэхүүн худалдах, тээвэрлэх боломжийг хассан буй арга хэмжээ, эм, эмнэлгийн төхөөрөмж, бусад шаардлагатай бүтээгдэхүүн худалдан авах санхүүжилтэд саад учруулж буй арга хэмжээ, эсхүл хүмүүнлэгийн тусламжийн хүргэхэд саад учруулж буй арга хэмжээнүүд орно.

Хүн худалдаалах гэмт хэрэг

- Олон улсын хөдөлмөрийн байгууллага 1.25 тэрбум буюу дэлхийн нийт ажлын байрны 38 хувьтай тэнцэх тооны ажиллагчид цар тахлаас шалтгаалан ажлын байраа алдана гэж тооцоолжээ. Ингэснээр олон сая хүн аюултай буюу мөлжлөгийн шинжтэй хөдөлмөр эрхлэх эрсдлийг нэмэгдүүлж байна. Түүнчлэн, цар тахлаас шалтгаалан хамгаалах байр, тусламж үйлчилгээний хүрээ багасаж, цагдаагийн сэргийлэх ажилд нөлөөлснөөр хүн худалдаалах гэмт хэрэгтэй холбоотой авч хэрэгжүүлж буй арга хэмжээ буурч болзошгүй байна.
- Төрөөс хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийг хамгаалах, туслалцаа үзүүлэх зэрэг үндэсний механизмын үйл ажиллагаанд үргэлжлүүлэн дэмжлэг үзүүлэх шаардлагатай.

Олон улсын хамтын ажиллагаа ба эв санааны нэгдэл

- Ковид-19 улс орнуудын доторх болон хоорондох тэгш бус байдлыг ил болгосон төдийгүй хурцатгалаа. Улс орнууд болон бүхий л эрх зүйн этгээд эв санааны нэгдэл, хамтын үүрэг хариуцлагынхаа хүрээнд олон талт, олон улсын хамтын ажиллагаагаа бэхжүүлэх зайлшгүй шаардлагатай байна.
- Тусламж шаардлагатай байгаа улс орнууд болон нийгмийн бүлгүүдэд санхүүгийн болон техникийн дэмжлэг үзүүлснээр хүний амь нас, аж амьдралыг аварна. Олон улсын хамтын нийгэмлэг богино болон урт хугацаат хамтын арга хэмжээндээ хөгжих эрх зэрэг бүхий л хүний эрхийг баримтлах учиртай. Олон улсын эв нэгдэл, хамтын ажиллагааг түшиглэн хөгжих эрх нь үндэсний болон дэлхийн худалдаа, хөрөнгө оруулалт, санхүүгийн тусламжтайгаар илүү сайн, тогтвортой хөгжих боломж бололцоо олгосон орчинг бий болгоход тусална.

ОИХ.МН
СУДАЛГААНЫ САН

ЭРҮҮДЭН ШҮҮХ БОЛОН БУСАД ХЭЛБЭРЭЭР
ХЭРЦГИЙ, ХҮНЛЭГ БУСААР БУЮУ НЭР ТӨРИЙГ
ДОРМЖЛОН ХАРЬЦАЖ ШИЙТГЭХЭЭС
УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ДЭД ХОРОО

SUBCOMMITTEE ON PREVENTION OF
TORTURE AND OTHER CRUEL, INHUMAN OR
DEGRADING TREATMENT OR PUNISHMENT

**Коронавирусын цар тахалтай холбоотой Эрүү шүүлтээс
урьдчилан сэргийлэх Дэд хорооноос Урьдчилан сэргийлэх үндэсний
механизм болон оролцогч улс орнуудад гаргасан зөвлөмжүүд**

(2020 оны 3 дугаар сарын 25-ны өдөр батлав)

**Advice of the Subcommittee on Prevention of Torture to
States Parties and National Preventive Mechanisms
relating to the Coronavirus Pandemic**

(adopted on 25th March 2020)

I. Оршил

1. Сүүлийн хэдэн долоо хоногт Коронавирус (Ковид-19) нь хүн бүрийн өдөр тутмын амьдралд маш том нөлөө үзүүлж байна. Үүнд төрөөс нийгмийн эрүүл мэндийн онцгой байдлын арга хэмжээг авч хувь хүний зорчих хөдөлгөөн болон эрх чөлөөнд хязгаарлалт тогтоох байдлаар цар тахалтай тэмцэж байна.
2. Эрх чөлөөгөө хязгаарлуулсан хүмүүс эрсдэлтэй, эмзэг байдалд орж байна. Энэ нь тэд нарын хязгаарлалтад байгаа байдал болон урьдчилан сэргийлэх, өөрсдөө сэрэмжлэх арга хэмжээ авах боломж хязгаарлагдсан байдлаас үүдэж байна. Тэр тусмаа хорих анги болон бусад саатуулах байранд нэг өрөөнд байх хүний тоо их байдгаас гадна бохир байдал нь эрсдлийг улам хурцатгаж байна.
3. Зарим улс орнуудад эрх чөлөөг хязгаарладаг газруудад цар тахалтай тэмцэхээр авч хэрэгжүүлсэн арга хэмжээ нь тухайн хорих ангид болон хорих ангийн гадна замбараагүй байдал үүсгээд байгаа бөгөөд хүний амь эрэгдсэн тохиолдлууд гарсан байна. Тиймээс аливаа төр засгаас цар тахалтай тэмцэхээр авч хэрэгжүүлж буй арга хэмжээ нь эрхээ хязгаарлуулсан этгээд, түүний гэр бүл, хорих байгууламжийн ажилтнууд болон эрүүл мэндийн ажилтнууд зэрэг бүх хүний эрхийг анхааралдаа авч үзэх нь нэн чухал юм.

4. Хоригдлууд болон хорих байгууллагын албан хаагчдад чиглэсэн гарч болзошгүй эрсдэлийн талаарх арга хэмжээнд энэ хүү зөвлөгөөнд туссан чиг хандлагыг тусгах тэр дундаа “хохирол учруулахгүй байх” болон “үзүүлж буй анхаарлын тэнцвэртэй байдлын” зарчмыг баримтлах шаардлагатай. Эрх чөлөөгөө хязгаарлуулсан хүмүүс болон тэдгээрийн гэр бүлийн гишүүдэд, хэвлэл мэдээллийнхэнд тухай бүр авч буй арга хэмжээ, түүний үндэслэлийн талаар ил тод мэдээлэл өгөх нь чухал билээ.
5. Үндэсний хэмжээний амин чухал, онцгой нөхцөл байдал үүссэн нөхцөлд ч эрүүдэн шүүх, хэрцгий, хүнлэг бусаар харьцах, шийтгэхийг хориглоно¹. Эрүүдэн шүүхээс урьдчилан сэргийлэх дэд хороо өмнө гаргасан заавартаа албан ёсоор хөл хорио тогтоосон газрууд Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцын Нэмэлт протоколын мандатын хүрээний асуудал мөн гэдгийг баталсан болно². Үүнээс улбаалаад ижил, төстэй зориулалт бүхий, хэн нэгэн өөрийн хүсэлтээр тухайн газрыг орхин явах, тухайн газраас гарах боломжгүй байгаа бүхий л газрууд нь Нэмэлт протоколын хүрээнд Эрүүдэн шүүхээс урьдчилан сэргийлэх Дэд хороо болон Урьдчилан сэргийлэх үндэсний механизмын харьяаллын асуудал болно.
6. Үүссэн нөхцөл байдлын талаар ямар хариу арга хэмжээ авах талаар Дэд хорооноос олон УСҮМ-ууд зөвлөгөө авахыг хүсч байсан билээ. Мэдээж өөр өөрсдийн улс оронд цар тахалтай холбогдуулж хэрхэн, ямар хариу арга хэмжээ авахыг бие даасан, хараат бус байгууллагын хувьд өөрсдөө тодорхойлох бүрэн боломжтой. Ямарваа нэгэн зөвлөгөөг Дэд хорооноос авахыг хүсэх нь бүгдэд нь нээлттэй хэвээр байна. Олон улсын болон бүс нутгийн байгууллагуудаас оролцогч улсууд болон УСҮМ-уудад хандан гаргасан үнэ цэнэтэй, чухал мэдэгдлүүдийг мөн анхааралдаа авч байгаа^{3,4}. Энэхүү зөвлөмжийн зорилго нь үүрэг хүлээсэн урьдчилан сэргийлэх үзлэг хийдэг болон эрх чөлөөг нь хязгаарласан газруудад хяналт тавин ажиллаж буй байгууллагуудад Нэмэлт протоколын хүрээнд ерөнхий заавар өгөх зорилготой юм.

1 Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцын 2(2) дугаар зүйл болон Ирэгний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын 4, 7 дугаар зүйлүүд.

2 Их Британи Умард Ирландын Нэгдсэн Вант Улсын Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний механизмд коронавирусын улмаас албадан хөл хорио тогтоох талаар Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх Дэд хороонын 40 дэх чуулганаар баталсан зөвлөгөө (2020 оны 2 дугаар сарын 10-14-ний өдрүүд), дараах холбоосоор танилцах боломжтой. https://www.ohchr.org/Documents/HRBodies/OPCAT/NPM/2020.03.03-Advice_UK_NPM.pdf

3 ДЭМБ-аас баталсан “Хорих байгууллагуудад Ковид-19 хянах, урьдчилан сэргийлэх, бэлэн байдал хангах заавар, 2020 оны 3 дугаар сарын 15-ны өдөр”.

4 CPT/Inf (2020)13 (2020 оны 3 дугаар сарын 19-ний өдөр). www.coe.int/en/web/cpt/-/covid-19-council-of-europe-anti-torture-committee-issues-statement-of-principles-relating-to-the-treatment-of-persons-deprived-of-their-liberty

7. Нийгмийн эрүүл мэндийг сахих үүднээс авч хэрэгжүүлж буй арга хэмжээнүүд нь урьдчилан сэргийлэх үзлэг шалгалт хийхэд тодорхой хэмжээгээр нөлөөлөх хэдий ч энэ нь урьдчилан сэргийлэх үзлэг шалгалтыг цуцлах үндэслэл биш гэдгийг Дэд хорооноос онцлохыг хүсэж байна. Харин ч эсрэгээрээ, авч буй нийгмийн эрүүл мэндийн арга хэмжээнүүд нь хоригдлууд зүй бус харьцаанд өртөх эрсдлийг улам нэмэгдүүлж болзошгүй юм. Тиймээс УСҮМ нь тогтоосон хязгаарлалтуудыг баримтлан урьдчилан сэргийлэх үзлэг шалгалтаа үргэлжлүүлэн хийхийг Дэд хороо зөвлөж байна. Өнөөгийн үүссэн нөхцөл байдалд УСҮМ нь хорих тогтолцоо болон үүрэг хүлээсэн албан хаагчдаас ирж болох тодорхой хэмжээний шахалтын улмаас хоригдлуудад ирэх өндөр магадлалтай бөгөөд хоригдлуудад учирч болзошгүй хүнлэг бус, нэр төрийг нь доромжлон харьцах боломж нөхцөлийг багасгах үр нөлөөтэй, зохистой арга хэмжээ авах баталгааг хангах хэрэгтэй байна.

II. Хорих байгууламжууд, гадаадын иргэнийг түр саатуулах байр, дүрвэгсдийн хаалттай хуаран, сэтгэцийн эмнэлэг болон бусад эмнэлгийн байгууламжууд зэрэг эрх чөлөөг нь хязгаарлах бүхий л газар төр засгаас авч хэрэгжүүлэх арга хэмжээ


8. Төрийн өөрийн хяналтад хоригдож байгаа хүний эрүүл мэндийг хариуцах бөгөөд хорих ажиллагааны болон эрүүл мэндийн ажилтнаар дамжуулан анхаарах үүрэгтэй эргэлзээгүй юм. “Ямар ч хоригдол бусад эрх чөлөөтэй хүмүүсийн эрүүл мэндийн үйлчилгээ авах стандарттай адил түвшинд эрүүл мэндийн үйлчилгээ авах эрхтэй ба хоригдлуудын эрх зүйн байдлаас үл хамааран эрүүл мэндийн үйлчилгээг үнэ төлбөргүйгээр авах боломжоор хангах” гэж Нельсон Манделагийн дүрэмд⁵ тодорхой заасан байдаг.

9. Хоригдож буй хүмүүс халдвар авах өндөр эрсдэлд байгааг анхааралдаа аван улс орнуудад Дэд хорооноос дараах уриалгыг гаргаж байна:

- 1) Хоригдож байгаа хүмүүсийн дунд яаралтай эрсдэлийн үнэлгээ хийж, бүхий л эрсдэлтэй бүлгийг харгалзан хоригдож буй хүмүүсээс нэн эрсдэлтэй бүлгийг тодорхойлох;
- 2) Токиогийн дүрэмд заасан хорихоос бусад төрлийн шийтгэлүүдийг анхааран судалж, аюулгүй байдал талаас шаардлага хангаж буй хоригдлуудыг хугацаанаас нь өмнө суллах, түр болон тодорхой нөхцөлөөр суллах зэргээр хорих байгууламжид байрлаж буй хүний тоог багасгах;

5 НҮБ-ын Хоригдолтой харьцах наад захын жишиг дүрэм (Нельсон Манделагийн дүрэм), UN Doc A/RES/70/175 (17 December 2015), 24(1) дүгээр дүрэм.

- 3) Албан ёсны багтаамжаас ачаалал нь хэтэрсэн болон албан ёсны багтаамж нь нэг хүнд оногдох зайг ам метрээр хэмжиж тооцдог нийт ард иргэдэд өгч буй зөвлөмжийн дагуу хүн хооронд баримтлах зайтай холбоотой зааврыг мөрдөх боломжгүй байгаа хорих газруудад онцгой анхаарал хандуулж ажиллах;
- 4) Цагдан хорих шийдвэрүүдийг дахин харах, олон нийтийн эрүүл мэндийн асуудал хөндөгдөх үед цагдан хорих нь зайлшгүй авах арга хэмжээ мөн эсэх талаар мөн дахин авч үзэх, зөвхөн хүнд хэргүүдээс бусад хэрэгт холбогдож буй этгээдүүдэд таслан сэргийлэх бусад хэмжээ авах;
- 5) Гадаад иргэдийг түр саатуулах байр болон хаалттай дүрвэгсдийн хуаранд байрлаж буй хүмүүсийн тоог цөөн байлгах зорилгоор тэдгээрийн нөхцөл байдлыг судлах;
- 6) Хорихоос суллахдаа мөн эмнэлгийн үзлэгт хамруулж халдварт өвчин авсан эсэх эсвэл авах өндөр эрсдэлтэй хүмүүст шаардлагатай арга хэмжээ авах;
- 7) Одоо байгаа дэглэмд тогтоож буй аливаа хязгаарлалтыг аль болох багасгах болон эрүүл мэндийн онцгой шаардлагын хэр хэмжээнд болон хуульд нийцсэн байхад анхаарах;
- 8) Үйлчилж буй гомдлын механизмыг үр нөлөөтэй, үргэлжлэн ажиллуулахад анхаарах;
- 9) Цар тахалтай тэмцэхээр авч хэрэгжүүлж буй арга хэмжээнүүдийг баримтлан хоригдлуудын гадаа агаарлах, дасгал хийх цагийн хэмжээг боломжоороо хадгалах;
- 10) Нийт ард иргэдтэй нэгэн адил нөхцлөөр хувийн ариун цэвэр сахих хүрэлцээтэй хэрэглэгдэхүүнээр хоригдлуудыг (үнэ төлбөргүй) хангах;
- 11) Эрүүл мэндийн шалтгаанаар эргэлт авах эрхийг нь хязгаарлаж байгаа бол гэр бүлийн гишүүд болон хорихоос гаднах ертөнцтэй холбоотой байх бусад арга хэрэглэхийг нь дэмжих, үүнд утсаар ярих, интернэтээр видео уулзалт зохион байгуулах зэрэг бусад цахим хэрэгслийг ашиглах. Цахим хэлбэрээр холбоо барих нөхцөл бололцоогоор тогтмол хангах, дэмжих, мөн үнэ төлбөргүй байх;
- 12) Хоригдолд гэр бүлээс нь бусад хэрэгцээг нь хангах илгээмж авах эрхийг нь хязгаарлахгүй байх, илгээмжийн эрүүл ахуйн болон аюулгүй байдлын шаардлагыг хангуулж ажиллах;



- 13) Эрсдэлтэй бүлэгт хамрагдах хоригдлуудыг эрсдэлийн зэрэгтэй нь нийцүүлж хүний эрхийг нь хангаж хорих;
- 14) Эрүүл мэндийн шалтгааны улмаас ганцаарчлан байрлуулах арга хэмжээг сахилгын арга хэмжээгээр солихгүй байх, тиймээс зөвхөн бие даасан, хараат бус эмнэлгийн ажилтны хийсэн дүгнэлтийн дагуу тодорхой заасан хугацаагаар, хэр хэмжээ тааруулан, бусад дүрэмд нийцүүлж ганцааранг нь байрлуулах шийдвэр гаргах;
- 15) Шаардлагатай тохиолдолд хорихоос гадуур эмнэлгийн үйлчилгээ үзүүлэх;
- 16) Хууль бус харьцаанаас урьдчилан сэргийлэх үндсэн хамгаалалт хүртээмжтэй, байнга бэлэн байхад анхаарах (хараат бус эрүүл мэндийн зөвлөгөө авах эрх, хууль зүйн туслалцаа авах эрх, гуравдагч этгээдэд хоригдсон талаар мэдэгдсэн байх гэх мэт);
- 17) Аливаа авч хэрэгжүүлж буй шийдвэрийн талаар үнэн, бодит, цаг үеийн мэдээллийг мөн авч хэрэгжүүлж буй үндэслэлийг хоригдол болон хорих байгууллагын ажилтнуудад хүргэж байх;
- 18) Хорих байгууллагын ажилтнууд болон эрүүл мэндийн ажилтнууд эрүүл мэндийг хамгаалах, үүргээ гүйцэтгэж буй албан хаагчдыг шаардлагатай хамгааллын хэрэгслээр хангахад анхаарах;
- 19) Эдгээр арга хэмжээний нөлөөлөлд байгаа хоригдол болон хорих байгууллагын албан хаагчдад шаардлагатай сэтгэл зүйн дэмжлэг үзүүлэх боломжоор хангах;
- 20) Эдгээр болон бусад арга хэмжээг сэтгэцийн эрүүл мэндийн байгууллагад албадан эмчлүүлж буй хүмүүст мөн авч хэрэгжүүлэх.

III. Төрийн зүгээс албан ёсоор хөл хорио тогтоосон газруудад авч хэрэгжүүлэх арга хэмжээ

10. Эрүүдэн шүүхээс урьдчилан сэргийлэх Дэд хороо өмнөх зөвлөгөөгөөр хөл хорионд орсон хүмүүсийн байдлын талаар тайлбар хийсэн ба энэ удаа дараах зөвлөмжүүдийг нэмэхийг санал болгож байна:
 1. Түр хугацаагаар хөл хорионд оруулсан хүний эрх чөлөөг шууд бүхэн хязгаарлаж болохгүй, харин хуулийн зүйл, заалт болон шинжлэх ухааны нотолгоонд үндэслэж тодорхой хязгаарлалт оруулж хөл хорио тогтоох нь зохимжтой;
 2. Ямар нэгэн байдлаар хөл хорионд орсон хүнийг “хоригдол” мэт харж, харьцаж үл болно;

3. Хөл хорионд орсон хүмүүсийг байршуулсан газар нь хэмжээ, зайны хувьд хангалттай байх шаардлагатай ба тухайн байгууламж дотроо өөрийн хэрэгцээ шаардлага хангахад нийцэхүйц хэмжээний хөдөлгөөнийг хязгаарлахгүй байх;
4. Зохимжтой арга хэрэгслээр гэр бүл, найз нөхөдтэйгөө холбоо барихыг дэмжих, шаардлагатай тохиолдолд дэмжлэг үзүүлэх;
5. Бодит байдал дээр хөл хорио тогтоох нь тодорхой хэмжээгээр хорьж байгаагийн нэг хэлбэр бөгөөд хөл хорионд орсон хэн бүхэн хууль бус харьцахаас ангид байх, хөл хорионд орсон шалтгааны талаар мэдээлэл авах эрх, хараат бус эмнэлгийн зөвлөмж авах эрх, хууль зүйн туслалцаа авах эрх, тухайн хүнтэй хамаарал бүхий гуравдагч этгээдүүд түүнийг хөл хорионд орсон талаар мэдэгдсэн байх зэрэг эрхүүдийг хязгаарлаж болохгүй;
6. Хөл хорионд байгаа, эсвэл хөл хорионд байсан хэн бүхнийг ялгаварлан гадуурхагдахаас, эмзэг байдалд орохоос нь урьдчилан сэргийлэх бүхий л арга хэмжээг авсан байх;
7. Шаардлагатай хүнд хөл хорионд байх хугацаанд болон хөл хорионоос гарснаас хойш сэтгэл зүйн дэмжлэг үзүүлэх боломжтой байх.

IV. УСҮМ-аас авах арга хэмжээ

11. Цар тахлын үед УСҮМ нь тогтоосон хязгаарлалтыг зөрчихгүйгээр өөрийн бүрэн эрхээ үргэлжлүүлэн хэрэгжүүлэх хэрэгтэй. Хорих ангиуд болон хөл хорио тогтоосон газрууд УСҮМ-ыг нэвтрэн орох, үзлэх хийх эрхийг хязгаарлаж болохгүй бөгөөд Эрүү шүүлтийн эсрэг конвенцын нэмэлт протоколын 14(2) дугаар зүйлийг баримтална.
12. Нэмэлт протоколын 1 дүгээр зүйлд заасанчлан “тогтмол эргэж очих тогтолцоо бие болгох” зорилго болон удиртгал хэсэгт заасан “эрх чөлөөгөө хасуулсан хүмүүсийг эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж, шийтгэхийн эсрэг хамгаалалтыг бэхжүүлэх” зорилт нь олон улсын эрх зүйгээр заавал биелүүлэх үүрэг юм. Тиймээс одоогийн нөхцөл байдалд УСҮМ-ын хувьд биеллэн харилцаанд орох хэлбэрийг багасгасан, үр дүнтэй бүрэн эрхээ хэрэгжүүлэх шинэ аргуудыг боловсруулах шаардлагатай байна.
13. Эдгээр арга хэмжээ нь:
 - 1) Холбогдох төрийн байгууллагуудтай дээрх II болон III дахь хэсэгт дурдсан эрсдэл бууруулах арга хэмжээний талаар харилцан ярилцах;

- 2) Дангаар болон хамтран хорих байгууллагын талаарх мэдээллийг цуглуулах, дүн шинжилгээ хийх;
- 3) Хорих байгууллагад байгаа хүнтэй цахимаар холбоо барих;
- 4) Хорих байгууллагуудад УСҮМ-ын шуурхай утас ажиллуулах, цахим шуудан болон захидал шуудангийн харьцааг сайжруулах;
- 5) Шинээр болон түр хугацаагаар байгуулж буй хорих байгууллагуудын талаар мэдээлэлтэй байх;
- 6) Хорих байгууллагуудад УСҮМ-ын үйл ажиллагааны талаарх мэдээллийн урсгалыг нэмэгдүүлж, шаардлагатай үед найдвартай, шуурхай, нууцлал алдагдахгүй холбоо барих шугам тогтоох;
- 7) Гуравдагч этгээдүүдтэй холбоо барьж хорих байгууллага доторх нөхцөл байдлын талаар нэмэлт мэдээлэл авах (хоригдож буй хүмүүсийн гэр бүл, хуульч, өмгөөлөгч);
- 8) Эрх чөлөөг нь хязгаарласан хүмүүстэй ажиллаж, дэмжлэг үзүүлдэг төрийн бус байгууллагуудтай хамтын ажиллагааг бэхжүүлэх, сайжруулах.

V. Дүгнэлт

14. Одоогийн байдлаар цар тахал хэр удаан үргэлжлэх, түүний үзүүлэх нөлөө бүхэлдээ ямар байх талаар тодорхой таамаг дэвшүүлэхэд бэрх байна. Харин энэхүү цар тахал аль хэдийн нийгмийн бүхий л хэсэгт маш том нөлөө үзүүлчихээд байгаа болон энэ байдал хэсэг хугацаанд үргэлжлэх нь тодорхой байна. Тиймээс Дэд хороо болон УСҮМ нь “хохирол учруулахгүй байх” зарчмыг алхам тутамдаа баримтлан ажиллах шаардлагатай юм. Иймд УСҮМ нь олон нийт, хорих байгууллагын ажилтнууд, хоригдлууд болон өөрсдийн эрүүл мэндийн үүднээс цар тахлаас үүссэн нөхцөл байдалд тааруулж өөрийн бүрэн эрхээ хэрэгжүүлэх шаардлагатай байна. Зүй бус харьцаанд өртөхөөс хоригдлуудыг урьдчилан сэргийлэх үр нөлөө нь үндсэн гол шалгуур байх шаардлагатай юм. Урьдчилан сэргийлэх ажлын хэмжүүр үзүүлэлтийг тухайн улсын авч хэрэгжүүлэхэд хүрсэн онцгой арга хэмжээнний байдлаар өргөжөөд байна. Нэмэлт протоколын хүрээнд үүрэг хүлээсэн Дэд хороо болон УСҮМ-ын хувьд өөрсдийн бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд шинэ тутам тулгарч буй сорилтод хариу арга хэмжээ авахдаа бүтээлч байдлаар хандан ажиллах шаардлагатай байна.

ЭМНЕСТИ ИНТЕРНЭШНЛ БАЙГУУЛЛАГЫН ОЛОН НИЙТЭД ХАНДСАН МЭДЭГДЭЛ (Хэсэгчлэн оруулав)

AMNESTY INTERNATIONAL PUBLIC STATEMENT (Abstract)

2020 оны 3 дугаар сарын 20-ны өдөр
12 March 2020

Индексийн дугаар POL 30/1967/2020
Index Number: POL 30/1967/2020

Улс орнуудын Ковид-19 вирусын халдварт өвчний эсрэг авч буй арга хэмжээ болон хүний эрхийг хангах үүрэг, хариуцлага: Эхний ажиглалт

Responses to covid-19 and states' human rights obligations: Preliminary observations

Ковид-19 вирусын халдварт өвчинд өртсөн улс орнуудын Засгийн газар, бусад оролцогчид уг халдварт өвчний эсрэг авч хэрэгжүүлж буй бодлого үйл ажиллагаандаа хүний эрхийн олон улсын хэм хэмжээг баримтлах ёстой. Энэхүү баримт бичигт Ковид-19 вирусын халдварт өвчний үед улс орнуудын бүх шатанд хэрэгжүүлж буй үйл ажиллагаанд тулгамдаж буй хүний эрхийн асуудал, сорилт, мөн хүний эрхийн талаарх Засгийн газруудын үүрэг, хэрэгжүүлэх аливаа арга хэмжээндээ баримтлах хүний эрхийн гол олон улсын хэм хэмжээ, зарчмуудыг хураангуйлан авч үзэв.

Өмнөтгөл

Дэлхийн эрүүл мэндийн байгууллага уг өвчнийг *цар тахал* хэмээн тодорхойлов¹. Ингэснээр уг цар тахлын эсрэг арга хэмжээ авч буй улс орнууд, тэдний хүчин чармайлтыг дэмжиж буй Засгийн газар хоорондын болон төрийн бус бусад оролцогчид, мөн өвчлөл гарсан улс орнуудын иргэд, Ковид-19 вирусын халдварт өвчинтэй нүүр тулж, тэмцэж буй эрүүл мэндийн байгууллагын эмч, эмнэлгийн ажилтнуудад ихээхэн хүнд цаг үе тулгарч байна.

Нийгмийн эрүүл мэнд, эрсдэлт нөхцөлд байгаа хүмүүс, эмзэг бүлгийнхнийг хамгаалахын тулд халдвараас урьдчилан сэргийлэх, бэлэн байдлаа хангах, халдварыг тогтоон барих, эмчлэх зэрэг бүхий л хүчин чармайлтын төвд хүний эрхийн асуудлыг тавих ёстой. Гэтэл халдвар авсан болон халдварын эрсдэлтэй хүмүүс, олон нийтэд учирч болзошгүй үр дагавруудыг бүрэн нягтлахгүйгээр халдварт өвчнийг тогтоон барих олон арга хэмжээг санал болгож, улс орнууд

¹ Дэлхийн эрүүл мэндийн байгууллага Ковид-19 вирусын халдварт өвчнийг *цар тахал* хэмээн зарлалаа. 2020 оны 3 дугаар сарын 11-ний өдөр. www.who.int/emergencies/diseases/novel-coronavirus-2019/events-as-theyhappen

хэрэгжүүлэх боллоо. Улс орнуудын Засгийн газар хүний эрхийн харилцан хамаарал, салшгүй байх зарчимд үндэслэн иргэний, соёлын, эдийн засгийн, улс төрийн болон нийгмийн эрхүүдийг хэрэгжүүлэх үүрэгтэй билээ. Хямралт байдлын ямар ч үе шатанд хүний эрх бүрэн хангагдах ёстой бөгөөд үүнд халдвар авсан, эрсдэлт бүлгийн хүмүүс бусдын адил эрхээ эдлэнэ. Түүнчлэн нийгмийн эрүүл мэндийн онцгой байдлаас шалтгаалан оршин байгаа газраа орхин нүүх болсон хүмүүс мөн адил хүний эрхийн хууль тогтоомжийн дагуу эрхээ бүрэн, үр нөлөөтэй эдлэх боломжоор хангагдана.

Өндөр настан, архаг өвчтэй хүмүүс (амьсгалын замын, зүрх судасны, сэтгэл зүйн, хавдар зэрэг өвчнөөр оношлогдсон, эмчийн хяналтад эмчилгээ хийгдэж байсан зэрэг) Ковид-19 вирусын халдварт өвчин авсан тохиолдолд хүндээр өвчлөх, амь насаа алдах өндөр эрсдэлтэй билээ. Мөн ядуу эмзэг бүлгийн хүн ам, усны хомсдолтой, зохих ариун цэврийн байгууламжгүй хүмүүс уг вирусын халдварт өвчнөөс өөрсдийгөө зохих түвшинд хамгаалахад саад бэрхшээл тулгарч байгаа нь дамжиггүй. Засгийн газрууд Ковид-19 вирусын халдварт өвчний эсрэг авах арга хэмжээгээ төлөвлөхдөө энэхүү халдварт өвчин тодорхой бүлэг хүмүүст тусах нөлөөллийг сайтар бодолцож, тэдний хэрэгцээ шаардлагыг төлөвлөгөө, стратегидаа тооцож үзвэл зохино.

Эрүүл мэндтэй холбоотой эрх нь олон улсын хүний эрхийн хэд хэдэн гэрээгээр баталгаажиж хамгаалагдсан бөгөөд дэлхийн ихэнх улс орнууд наанадаж нэг гэрээг соёрхон баталсан байдаг тул иргэдийнхээ эрүүл мэндийн асуудалд хүндэтгэлтэй хандах, хамгаалах, хэрэгжүүлэх үүрэгтэй. Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын пактын 12 дугаар зүйлд зааснаар “хүн бүрийн бие бялдрын болон сэтгэцийн эрүүл мэнд дээд түвшинд хүрсэн байх эрхийг” хангах, мөн “халдварт өвчин, тухайн орон нутгийн өвчин, мэргэжлийн болон бусад өвчнөөс урьдчилан сэргийлэх, эмчлэх, хяналтад байлгахад” шаардлагатай арга хэмжээ авах явдал юм. Тус пактын хэрэгжилтийг хянах үүрэг бүхий НҮБ-ын Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн хорооноос гаргасан Ерөнхий зөвлөмж №14-ийн 3 дахь хэсэг² уг эрхтэй холбоотой Засгийн газруудын үүргүүдийг тайлбарласан байна. Тус хорооноос “халдварт өвчин, тухайн орон нутгийн өвчнөөс урьдчилан сэргийлэх, эмчлэх, хянах арга хэмжээ” нь “нэн тэргүүнд хэрэгжүүлэх үүрэг хариуцлага” бөгөөд эрүүл мэндээ хамгаалуулах “шаардлагатай, наад захын түвшинд” эрхийг хангах хамгийн гол үүрэг болно. Аль ч улс орон, ямар ч нөхцөлд эдгээр “хөндөж үл болох” үндсэн эрхийг хангаагүй явдлаа зөвтгөх ёсгүй гэжээ³.

2 Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн хорооны Ерөнхий зөвлөмж №14, Эрүүл мэндийн боломжит дээд стандартыг хүртэх эрх, Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын пактын 12 дугаар зүйл, НҮБ-ын бичиг баримт. Е/С. 12/2000/4 (2000) (Үүнээс хойш: Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн Хорооны Ерөнхий Зөвлөмж №14 гэх).

3 Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн Хорооны Ерөнхий Зөвлөмж №14, 43, 44, 47 дүгээр догол мөрүүд. 47 дүгээр догол мөрд “үндсэн үүрэг”, 43 дугаар догол мөрөнд “хөндөж үл болох үндсэн эрхүүд”-ийг тайлбарласан. 43, 44 дүгээр догол мөрөнд улс орнуудын хэрэгжүүлбэл зохих “нэн тэргүүний үүргийн” жагсаалт байх ба адил тэгш хэрэгжүүлэх ёстой гэж заажээ.

Хорио цээрийн дэглэм

Халдварт өвчний тархалтыг хяналтад оруулах зорилгоор түгээмэл хэрэглэдэг хорио цээрийн дэглэм (халдварт өвчний шинж тэмдэг илэрсэн эсвэл илэрч болзошгүй хүмүүсийг тусгаарлах)-ийг Ковид-19 вирусын халдварт өвчний эсрэг улс орнууд нийтлэг хэрэгжүүлж байна. Хорио цээрийн дэглэм нь хувь хүний чөлөөтэй зорчих эрхийг хөндөхийн сацуу ядуу, эмзэг бүлгийн хүн амд хоол хүнс болон хэрэгцээт бусад зүйл, эрүүл мэндийн үйлчилгээ авах хангалттай нөөцгүй байдгаас хорио цээрийн дэглэм тэдэнд тэгш бус байдлаар тусч, хүний эрхийн зөрчил үүсч болзошгүй байдаг билээ. Тэд цалингүй чөлөөний хугацааг давах хангалттай нөөцгүй байж болно. Хүний эрхийн олон улсын эрх зүйн дагуу цөөн тооны нөхцөл байдалд л хорио цээрийн дэглэмийг зөвшөөрдөг.

НҮБ-ын Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактад зааснаар хэрвээ хууль тогтоомжид тусгагдсан бол олон нийтийн эрүүл мэнд зэрэг тодорхой хууль ёсны зорилгыг хамгаалахын тулд “Пактаар хүлээн зөвшөөрсөн бусад эрхтэй нийцэж байгаа” нөхцөлд чөлөөтэй зорчих эрхийг хязгаарлаж болно⁴. Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын заалтаас ухрах болон хязгаарлалт тогтоох талаарх Сиракусын зарчим болон шинжээчийн пактын талаарх тайлбарын дагуу хэзээ, хэрхэн хүний эрхийг хязгаарлах талаар дараах зөвлөмжийг өгсөн байна. Үүнд:

- (i) пактаар хүлээн зөвшөөрсөн эрхийг хязгаарлахдаа ямар нэг байдлаар ялгаварлахгүй байх;
- (ii) аливаа хязгаарлалт нь нийгмийн, олон нийтийн тулгамдсан хэрэгцээний хариу арга хэмжээ болж, хууль ёсны зорилгоо биелүүлэх ба энэхүү зорилготойгоо эн тэнцүү байх⁵;
- (iii) улс орнууд хязгаарлалт хийж буй зорилгодоо хүрэхэд шаардлагатайгаас илүүгээр хязгаарлах арга хэрэгсэл ашиглах ёсгүй,
- (iv) пактын дагуу баталгаажсан эрхийг хязгаарласан шалтгаанаа тухайн улс өөрөө тайлбарлана⁶;

4 *Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт, 12.3 дахь хэсэг.*

5 *Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын пактын Ерөнхий зөвлөмж №14, 29 дүгээр догол мөр, аливаа хязгаарлалт нь “тухайн тулгамдсан асуудалтай тэнцэхүйц...”, “...тодорхой хугацаатай, мөн эргэн хянах үзэх шаардлагатай” байна.*

6 *“Сиракусын зарчим”-ын 8-12 дугаар заалт, “Оролцогч улсууд онцгой байдлын үед хэрэглэх хүний эрхийн стандартыг олон улсын эрх зүйн хүрээнд боловсруулах талаар анхаарч үзэх ёстой” гэж Сиракусын зарчимд тусгагдсаныг Хүний эрхийн хороо цохон тэмдэглэв. Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын пактын Ерөнхий зөвлөмж №29, Онц байдлын үе. (4 дүгээр зүйл), НҮБ-ын баримт бичиг. CCRPR/C/21/Rev.1/Add.11 (2001), para.10.*

ОИ.МН
СУДАЛГААНЫ САН

(v) тухайн хязгаарлалтыг зүй бусаар ашиглахын эсрэг арга хэмжээ авах, мөн тулгарч болзошгүй бэрхшээлийг харгалзаж үзсэн байна. Олон нийтийн эрүүл мэндийг хамгаалах үүднээс хүний эрхийг хязгаарлах тохиолдолд “авах арга хэмжээ нь зөвхөн өвчнөөс урьдчилан сэргийлэх, эсвэл өвчтэй, гэмтэж бэртсэн хүмүүст тусламж үзүүлэхэд чиглэгдэх ёстой” гэдгийг Сиракусын зарчим дахин давтан сануулж байна⁷.

Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн хорооны №14 дүгээр Ерөнхий зөвлөмжид олон нийтийн эрүүл мэндийн төлөөх аливаа хязгаарлалт нь “олон улсын хүний эрхийн хэм хэмжээ болон хуульд нийцсэн, пактаар хамгаалагдсан эрхийн мөн чанар болон хууль ёсны зорилго, ардчилсан нийгмийн сайн сайхныг хангах зайлшгүй шаардлагатай нийцсэн байх ёстой” гэжээ⁸. Эдгээр хязгаарлалт нь тодорхой хугацаатай, дахин хянан үзэх ёстой, мөн хэд хэдэн хувилбар байгаа тохиолдолд хамгийн бага хязгаарлалттайг нь хэрэглэвэл зохино⁹.

Хорио цээрийн дэглэм болон тусгаарлах арга хэмжээг аюулгүй, хүндэтгэлтэй байдлаар хэрэгжүүлэх ба эрхээ бүрэн эдлэхэд учирч болох эрсдэлийг анхаарч үзэх ёстой. Олон нийтийн итгэлцэл, хамтын ажиллагааг нэмэгдүүлэхийн тулд нөлөөлөлд өртсөн хүмүүсийн нэр төрд хүндэтгэлтэй хандаж, тэдэнд өөрсдийнхөө амьдралд хяналт тавих бололцоог боломжийн хэрээр олгох, хөл хөдөлгөөнийг нь хязгаарлах арга хэмжээг боломжтой бол сайн дурын байдлаар хэрэгжүүлбэл зохино. Хэрвээ хорио цээрийн дэглэм хэрэгжүүлэх шаардлагатай бол Засгийн газруудын зүгээс үүнийг олон улсын хүний эрхийн холбогдох хэм хэмжээний дагуу уг дэглэмд хамрагдсан хүн бүрт хүнлэг байдлаар хандах нөхцөлийг бүрдүүлж, үр дүнтэй хяналт шалгалтын системийг бий болгох үүрэгтэй.

Хорио цээрийн дэглэмд байгаа хүмүүсийн эрхийг хүндэтгэж, хамгаалахдаа эн тэргүүнд зохистой орон байр, хоол хүнс, ус, ариун цэврийн байгууламж зэрэг хүний үндсэн хэрэгцээгээр хангагдах эрхийг хангана. Ковид-19 вирусын халдварт өвчний эсрэг авч буй хорио цээрийн дэглэм болон иргэдийн хөдөлгөөнийг хязгаарлаж буй аливаа арга хэмжээний үеийн бүх шийдвэрт эдгээр зарчмыг баримтлах ёстой.

Аяллын хориг ба хязгаарлалт

Аялал жуулчлалд хязгаарлалт хийх ба хориг тавих зэрэг төрөөс хэрэгжүүлдэг бусад хариу арга хэмжээ нь аливаа улсыг орхин явах, мөн өөрийн эх орондоо эргэн ирэх эрхээ дур зоргоор зөрчүүлэхгүй байх зэрэг чөлөөтэй зорчих

7 “Сиракусын зарчим”-ын 28 дугаар зүйл.

8 Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын пактын Ерөнхий зөвлөмж №14, 28 дугаар хэсэг.

9 Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын пактын Ерөнхий зөвлөмж №14, 29 дүгээр хэсэг.

эрхээ эдлэхэд тодорхой хэмжээгээр нөлөөлдөг¹⁰. Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын зүгээс тодорхой нөхцөл байдал үүссэнээс бусад тохиолдолд аяллын болон худалдааны хориг тавихгүй байхыг зөвлөдөг хэдий ч хамгийн сүүлд гарсан удирдамжид дурдсанаар “хязгаарлалт нь шаардлагатай тусламж, техникийн туслалцаанд саад болж, бизнесийг тасалдуулж, өвчлөл гарсан улс орнуудын нийгэм, эдийн засагт сөрөг нөлөө үзүүлэх магадлалтай”, цаашлаад “олон нийтийн эрүүл мэндийн онцгой байдал үүссэн үед бараа бүтээгдэхүүн болон хүмүүсийн хөдөлгөөнийг хязгаарлах нь ихэнхдээ үр дүнгүй ба хөндлөнгийн бусад тусламжаас нөөцийг холдуулж болзошгүй юм” гэжээ¹¹.

Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактад заасны дагуу хууль тогтоомжид зааж, олон нийтийн эрүүл мэндийг хамгаалах шаардлага болон хязгаарлагдмал нөхцөл байдалд, тодорхой үндэслэлтэйгээр зорчих хөдөлгөөнийг хязгаарлаж болно¹². Аяллын хориг болон хязгаарлалтыг хэрэгжүүлэх тохиолдолд үүнийг Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактад заагдсан үүрэг, Сиракусын зарчимд тодорхойлсон ялгаварлан гадуурхалтгүй, хууль ёсны, нэн шаардлагатай бөгөөд тулгамдсан асуудалтай тэнцэхүйц, өөрөөр хэлбэл хамгийн бага хязгаарлалтын хэлбэр байхаар хэрэгжүүлэх ёстой байна.

Мэдээллийн хүртээмж, ил тод байдал ба цензур

Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын 19 дүгээр зүйлээр нь “бүх төрлийн мэдээлэл болон үзэл санааг эрж хайх, хүлээн авах, түгээх” эрхийг хамгаалдаг бөгөөд энэхүү эрхийг зөвхөн тодорхой нөхцөлд, түүний дотор олон нийтийн эрүүл мэндийн ашиг сонирхлын үүднээс хязгаарлаж болно. Улс орнууд ийм хязгаарлалтыг хэрэгжүүлэхэд Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт болон Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын пактад заагдсан хамгаалалтуудыг давхар хэрэгжүүлэх ёстой. Эрүүл мэндтэй холбоотой мэдээллийг олж авах боломж нь эрүүл мэндээ хамгаалуулах эрхийн бас нэгэн чухал хэсэг юм. “Халдвараас урьдчилан сэргийлэх болон хянах арга хэлбэрийг оролцуулан олон нийтийн эрүүл мэндэд тулгамдаж буй асуудалтай холбоотой мэдлэг, боловсролыг хүртээмж”-тэй олгох нь эрүүл мэндээ хамгаалуулах эрхийн цөм болсон “нэн тэргүүнд авч хэрэгжүүлбэл зохих” үүрэгт тооцогдоно¹³.

10 Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын 12 дугаар зүйл.

11 Ковид-19 вирус халдварт өвчинтэй холбогдуулан олон улсын тээвэрт Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын өгөх шинэчилсэн зөвлөмж, 2020 оны 2 дугаар сарын 29-ний өдөр. www.who.int/ith/2019nCoV_advice_for_international_traffic-rev/en/

12 Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын 12 дугаар зүйлийн 12.3 дахь хэсэг.

13 Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын пактын Ерөнхий зөвлөмж №14, 44 дүгээр зүйл.

Мэдээллийн хүртээмжтэй байдал нь эрүүл мэндийн тусламж үйлчилгээний үндсэн хэмжүүр бөгөөд “эрүүл мэндийн асуудалтай холбоотой мэдээллийг хайх, олж авах, хэлэх, илэрхийлэх эрхэд” мөн хамаарна¹⁴. Өвчилсөн хүн бүрт олон нийтийн эрүүл мэндэд тулгарч буй аюулын мөн чанар, хэр хэмжээ, эрсдлийг бууруулахын тулд авах боломжит арга хэмжээ, цаашид гарч болзошгүй үр дагаврын талаар сэрэмжлүүлэг өгөх, мөн авч хэрэгжүүлж буй хариу арга хэмжээний талаар хялбар, хүртээмжтэй, цаг үеийн, ач холбогдол бүхий мэдээллээр хангах үүрэгтэй. Мэдээлэл нь өвчилсөн хүмүүсийн ялгаатай хэрэгцээ шаардлагыг хангасан хэлээр, мэдээллийн хэрэгсэл болон хялбархан ойлгогдох, хүртээмжтэй бусад хэлбэртэй байх ба энэ нь хүмүүсийг бүрэн хамруулах, мөн тэдэнд хариу арга хэмжээний үед мэдээлэлтэйгээр шийдвэр гаргах боломжийг олгоно.

Ковид-19 вирусын халдварт өвчний тархалтыг тогтоон барих, эмнэлгийн тусламж үйлчилгээ шаардлагатай байгаа хүмүүст туслах болон нөөцийг үр дүнтэй зарцуулахад итгэлцэл нэн чухал юм. Гэхдээ олон нийтийн тэрхүү итгэлийг олж авахын тулд цаг тухайд нь холбоо барьж, эрүүл мэндийн тулгамдсан асуудлын мөн чанарыг ойлгох боломжит бүхий л мэдээллийг өгөх шаардлагатай. Боломжтой бол үүнийг олон нийтийн оролцоо болон орон нутгийн засаг захиргаатай түншлэх замаар хэрэгжүүлбэл зохино. Хэрвээ ингэж чадахгүй бол хүмүүсийн арга барагдах, уурлаж бухимдах байдал нэмэгдэж, олон нийтийн эрүүл мэндийн талаар авч буй арга хэмжээг сулруулж, бусдыг эрсдэлт оруулж, хүний эрхийг зөрчиж болзошгүй юм. Түүнчлэн хүмүүсийг халдвар авахаас өөрсдийгөө хамгаалахад шаардлагатай арга хэмжээ авах, оролцогч бүх талууд бодит байдлын талаар ойлголттой болох, мөн Ковид-19 вирусын халдварт өвчинтэй тэмцэх үр дүнтэй арга хэмжээ авах, хамтран ажиллахад бэрхшээлтэй байдал бий болгох эрсдэлтэй.

Зарим бүлгийнхэнд тусах тэгш бус нөлөөлөл

Хэн ч Ковид-19 вирусын халдварт өвчин авах боломжтой, гэхдээ тодорхой бүлгийн хүмүүс хүндээр өвчлөх, амь насаа алдах ихээхэн эрсдэлтэй байна. Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын мэдээллээс үзэхэд өндөр настнууд болон хууч өвчтэй (багтраа, чихрийн шижин, зүрх судасны өвчин зэрэг) хүмүүст уг вирусын халдвар хүндрэл үзүүлэхээр харагдаж байна¹⁵. Ковид-19 вирусын халдварт өвчин жендэрийн нөлөөллийн талаарх мэдээлэл одоогийн байдлаар хомс байгаа хэдий ч өмнө нь тохиолдож байсан нийгмийн эрүүл мэндийн онцгой байдлын үед охид, эмэгтэйчүүдэд онцгой, тэгш бус байдлаар нөлөөлж байжээ¹⁶. Энэ нь ихэвчлэн эрүүл мэнд, нийгмийн болон албан бус салбарын

14 Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын пактын Ерөнхий зөвлөмж №14, 12 (б) дүгээр зүйл.

15 Дэлхийн Эрүүл мэндийн байгууллага, Коронавирусын халдвар (Ковид-19) олон нийтэд өгөх зөвлөмж: Цуу яриаг няцаах нь (2020). www.who.int/emergencies/diseases/novel-coronavirus2019/advice-for-public/myth-busters

16 НҮБ-ын Хүн амын сан, Шинэ Эбола вирусын халдвар Ардчилсан Конго Улсын охид, эмэгтэйчүүдэд хүндээр тусч байна, 2018 оны 9 дүгээр сарын 10-ны өдөр. www.unfpa.org/news/newebola-outbreak-hits-women-and-girls-hardest-democratic-republic-congo

аль алинд халамж үйлчилгээ үзүүлэх үүрэг гүйцэтгэж байсан эмэгтэйчүүдтэй холбоотой¹⁷ ба өвчний халдвар авах өндөр эрсдэлтэй нөхцөлд, түүнчлэн эрүүл мэндийн туслалцаа хүсэх болон шийдвэр гаргах үйл явцын эргэн тойронд жендерийн тэгш бус байдалтай нүүр тулгарч байжээ¹⁸. Түүнчлэн бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэндийн мэдээлэл, үйлчилгээний хүртээмж, тодруулбал сарын тэмдгийн үеийн эрүүл ахуйн бүтээгдэхүүн, жирэмсэн болон хөхүүл эхчүүдийг шаардлагатай хэрэгслээр хангах зэргээр охид, эмэгтэйчүүдийн онцгой хэрэгцээг анхаарах нь чухал байна.

Үүнээс гадна зарим хүмүүс Ковид-19 вирусын халдварт өвчнөөс өөрсдийгөө хангалттай хэмжээнд хамгаалахад илүү саад бэрхшээлтэй тулгарч болзошгүй байна. Тухайлбал ядуу, эмзэг бүлгийн хүн амд амны хаалт, ариутгалын бодис зэрэг урьдчилан сэргийлэх хэрэгсэл олж авахад хүндрэлтэй, мөн орон гэргүй хүмүүс өөрсдийгөө тусгаарлахад томоохон бэрхшээлтэй учирна. Үүний нэгэн адилаар ус болон аюулгүй ариун цэврийн байгууламжгүй хүмүүс Ковид-19 вирусын халдварт өвчин авах илүү эрсдэлтэй ба байнга зөвлөж буй урьдчилан сэргийлэх арга хэмжээг (гараа тогтмол угаах зэрэг) авч чадахгүй байх болно. Урьдчилан сэргийлэх хангалттай арга хэмжээ авах боломжгүй, хорих анги¹⁹ болон эрүүл мэндэд хөнөөл учруулах эрсдэлтэй орчинд бусадтай хамт ажиллах, амьдрахаас өөр сонголтгүй нөхцөлд байгаа хүмүүс тухайлан халдварт өртөх эрсдэлтэй юм.

Орлого багатай болоод баталгаагүй, албан бус салбарт хөдөлмөр эрхлэгчид халдварт өвчний эдийн засагт үзүүлж буй сөрөг нөлөөллөөс болж орлого нь багасах, ажилгүй болох зэргээр илүү ихээр өртөж болзошгүй²⁰. Ковид-19 вирусын халдварт өвчний эсрэг хариу арга хэмжээг төлөвлөхдөө улс орнууд уг вирусын тодорхой бүлэг хүмүүст үзүүлэх нөлөөлөлд анхаарч, төлөвлөгөө, стратегидаа тэдний хэрэгцээ шаардлагыг бүрэн тусгах нь чухал юм.


Ковид-19 вирусын халдварт өвчний тохиолдол нэмэгдэх нь нийгмийн эрүүл мэндийн тогтолцоонд ихээхэн дарамт учруулан, хууч өвчтэй хүмүүс, өндөр настнууд болон жирэмсэн эмэгтэйчүүд зэрэг эрүүл мэндийн тогтмол тусламж

17 Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын судалгаагаар эрүүл мэнд болон нийгмийн салбарын ажилтнуудын 70 хувийг эмэгтэйчүүд бүрдүүлдэг байна. Дэлхийн эрүүл мэндийн байгууллага, Эрүүл мэндийн салбарын ажиллах хүчний жендерийн тэгш байдал: 104 орны дүн шинжилгээ, Эрүүл мэндийн салбарын ажиллах хүчний тайлан мэдээлэл 1. https://www.who.int/hrh/resources/gender_equity-health_workforce_analysis/en/;

18 Клэйр Вэнхам, Жулиа Смит болон бусад, Ковид-19: Халдварын жендерийн нөлөөлөл, Лансет, 2020 оны 3 дугаар сарын 6-ны өдөр. The Lancet. [www.thelancet.com/journals/lancet/article/PIIS0140-6736\(20\)30526-2/fulltextWenham](http://www.thelancet.com/journals/lancet/article/PIIS0140-6736(20)30526-2/fulltextWenham)

19 Жишээ болгож: Английн Эмнести Интернэшнл, Иран Улс: Коронавирусын айдас дунд Назанин Загхари-Ратклифийг ямар ч болзошгүйгээр суллах болов, Хэвлэлийн мэдээ, 2020 оны 3 дугаар сарын 3-ны өдөр. www.amnesty.org.uk/press-releases/iran-amid-coronavirus-fears-nazanin-zaghari-ratcliffe-should-be-released

20 Өмнөд Хятадын Өглөөний Мэдээ, Бид хэрхэх вэ? 2020 оны 2 дугаар сарын 26-ны өдөр. www.scmp.com/news/hong-kong/hong-kong-economy/article/3052526/what-about-us-needy-hong-kong-who-fall-short-mark



үйлчилгээ шаардлагатай хүмүүст сөргөөр нөлөөлж болзошгүй байна²¹. Улс орнууд нэн тэргүүнд хүмүүс хэрэгцээтэй бараа, үйлчилгээгээр хангагдаж байгаа эсэхийг мэдэхийн тулд судалгаа шинжилгээ хийх хэрэгтэй. Ерөнхийдөө Ковид-19 вирусын халдварт өвчний эсрэг хариу арга хэмжээ авах, үүнд бэлтгэхдээ уг арга хэмжээ нь эрүүл мэндийн тогтолцоо болон эрүүл мэндийн бусад шалтгаанаар эмнэлгийн тусламж үйлчилгээ нэн шаардлагатай хүмүүст үзүүлэх аливаа сөрөг нөлөөллийг бууруулахад анхаарах нь зүйтэй.

Нийгмийн аюулгүй байдал ба ажиллагчдын эрх

Нийгмийн эрүүл мэндийг хамгаалах зорилгоор аяллын хориг, хорио цээрийн дэглэм болон хүмүүс олноор цуглахыг хязгаарлах зэрэг хэд хэдэн арга хэмжээ авч байгаа нь хүмүүсийн хөдөлмөрлөх эрхэд, ялангуяа албан бус салбарын хөдөлмөр эрхэлдэг хүмүүст тэгш бус, сөрөг нөлөөлөл үзүүлж болзошгүй билээ. Үүнд цагаач ажилчид²², түр зуурын, цагийн ажил хийдэг хүмүүс (gig economy)²³ зэрэг хамаарна. Энэ салбарт ажилладаг хүмүүс ихэнхдээ хангалттай хэмжээний болон эсвэл ямар ч нийгмийн хамгааллын тэтгэмж авдаггүй ба хорио цээрийн дэглэмийн үед цалингүй болдог эсвэл цалинтай чөлөө олддоггүй. Ковид-19 вирусын халдварт өвчнөөс шалтгаалан хөдөлмөр эрхэлж чадахгүй байгаа тохиолдолд мөн бүх хүн цалинтай чөлөө, өвчтөн асрах болон хүүхэдтэй болсны чөлөө эдлэх зэргээр нийгмийн хамгаалалд бүрэн хамрагдах боломжийг улс орнууд баталгаажуулах ёстой²⁴. Үүнд жишээ нь өөрсдөө өвчтэй, хорионд орсон, эсвэл сургууль хаагдсанаас болж хүүхдээ харж байгаа хүмүүс хамаарна. Үүнээс гадна (хөдөлмөр эрхлэх боломжгүй үедээ) нийгмийн хамгааллын дэмжлэг авах эрхийг хүндэтгэн, эдгээр арга хэмжээг авах нь төрөөс хэрэгжүүлж буй нийгмийн эрүүл мэндийг хамгаалах арга хэмжээг үр дүнтэй дагаж мөрдөхөд хүмүүст дэмжлэг үзүүлэх ач холбогдолтой. Тухайлбал хэрвээ нийгмийн хамгааллын хангалттай дэмжлэг авах боломжтой бол хүмүүс өөрсдөдөө сөрөг үр дагавар учруулахгүйгээр хорио цээрийн дэглэмийг дагаж мөрдөх болно.

21 Үндэсний олон нийтийн радио, Хэрвээ Хятадад хүндээр өвдсөн бол танд юу тохиолдох вэ?—Гэхдээ тэр нь Коронавирус биш, 2020 оны 2 дугаар сарын 25-ны өдөр. www.npr.org/sections/goatsandso-da/2020/02/25/805712259/what-happens-if-youre-critically-ill-in-china-but-not-with-coronavirus

22 Аль Жазийра, Коронавирусын халдвар: Цагаач ажилчид хэрхэх вэ? 2020 оны 3 дугаар сарын 5-ны өдөр. www.aljazeera.com/news/2020/03/coronavirus-outbreak-migrantworkers-do-200305102831177.html

23 “Гардиан”-ыг жишээ болгон үзнэ үү. “Хэрвээ би коронавирусын халдвар авбал би сүйрнэ, албан бус салбарт хөдөлмөр эрхлэгчид өвчний зардлыг дийлэхгүй”. 2020 оны 3 дугаар сарын 7-ны өдөр. www.theguardian.com/world/2020/mar/07/gig-economy-workers-on-breadline-too-poor-to-stay-at-home-if-they-catch-coronavirus; БиБиСи: “Өвчин тусвал би ажиллах хэрэгтэй болно”, 2020 оны 3 дугаар сарын 9-ний өдөр. www.bbc.co.uk/news/business-51800050

24 Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн хорооны Ерөнхий зөвлөмж №19, Нийгмийн хамгаалал авах эрх (9 дүгээр зүйл)-ийг үзнэ үү, НҮБ-ын баримт бичиг, E/C.12/GC/19 (2008).

Олон улсын хамтын ажиллагаа ба тусламж

Олон улсын хамтын ажиллагаа, туслалцаагүйгээр хүний эрхийг хамгаалах үүргийг бүрэн хэрэгжүүлэхэд бэрхшээлтэй. Хүний эрхийг хангах үүрэг хариуцлагад хүний эрүүл мэндтэй холбоотой эрхэд хүндэтгэлтэй хандах явдал болон олон улсын хамтын ажиллагаа, туслалцаатай холбоотой үүрэг хамаардгийг дэлхийн улс орнуудын дийлэнх олонх нь хүлээн зөвшөөрсөн байдаг²⁵. Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын пактын №14 дүгээр Ерөнхий зөвлөмжид “тухайн улсын хил хязгаарыг даван, түргэн тархаж буй халдварт өвчний үед олон улсын хамтын нийгэмлэг энэхүү асуудлыг хамтран шийдвэрлэх үүрэгтэй” гэж тодорхой заасан байдаг. Эдийн засгийн өндөр хөгжилтэй улс орнууд энэ асуудлаар ядуу, хөгжиж буй улсуудад туслалцаа үзүүлэх онцгой үүрэг хариуцлага хүлээдэг²⁶. Улс орнууд өөрийн харьяаллын хүрээн дэх Ковид-19 вирусын халдварт өвчний тархалтын хэмжээ, боломжит эмчилгээ, өвчний үр дагавар зэрэг холбогдох мэдээллийг бусад улс орнууд, олон улсын байгууллагуудад өгөх ёстой. Ковид-19 вирусын халдварт өвчний хурдацтай тархаж байгаа нь үүний эсрэг хангалттай хариу арга хэмжээ авах нөөцгүй байгаа зарим улс орнуудад нөлөөлж болзошгүй гэсэн айдсыг нэмэгдүүлж байна. Ийм үед олон улсын хамтын ажиллагаа, эв нэгдэл нэн чухал юм. Хариу арга хэмжээ авах боломжтой бүх улс орон аль болох хурдан ажиллах ёстой бөгөөд ингэхдээ хүний эрхийг хүндэтгэсэн, урт хугацааны нэн тэргүүний хэрэгцээ болон нийгмээс эмзэг бүлгийнхний онцлог, хэрэгцээг харгалзах шаардлагатай.

Олон улсын хамтын ажиллагааны нэгэн чухал тал бол Ковид-19 вирусын халдварт өвчний тархалт, эрсдэл, хэрхэн урьдчилан сэргийлэх, эмчлэх аргуудын талаарх мэдээллээ гол оролцогчдод ил тод, үр дүнтэй хэлбэрээр хуваалцах явдал юм. Нөлөөлөлд өртсөн хүмүүс болон бүх оролцогч талын оролцоог хангасан дэлхийн хэмжээний уялдаа холбоотой хариу арга хэмжээ нь мөн ижил ач холбогдолтой юм. Эрүүл мэндтэй холбоотой эрхийн хүрээнд “эрхийг хэрэгжүүлэхэд чиглэсэн, хамаарал бүхий бүх талуудын оролцоо, хүчин чармайлт, түүний дотор иргэний нийгмийн бүх төлөөллийн оролцоо хамаарна” гэжээ²⁷.

Иймд Ковид-19 вирусын халдварт өвчний эсрэг авч буй арга хэмжээг хүний эрхийн олон улсын эрх зүй, хэм хэмжээнд нийцүүлж, эрсдэлт болон туслалцаа шаардлагатай бүлгийнхний онцгой хэрэгцээг анхаарах, хүний эрхийн болзошгүй зөрчлийн эрсдэлийг бууруулан шийдвэрлэж, баталгаажуулахыг бүх улс орон, бусад оролцогчдод хандан Эмнести Интернэшнл байгууллагаас уриалж байна.

25 Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн хорооны Ерөнхий зөвлөмж №14, 38, 45 дугаар зүйл.

26 Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн хорооны Ерөнхий зөвлөмж №14, 40 дүгээр зүйл.

27 Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын пактын Ерөнхий зөвлөмж №14, 64 дүгээр зүйл.



М.ЧИНБАТ

Монгол Улсын Ерөнхий прокурорын орлогч,
Төрийн хууль цаазын шадар зөвлөх

“ХҮНИЙ ЭРХ, ЭРХ ЧӨЛӨӨГ ХАМГААЛАХ НЬ
ПРОКУРОРЫН ХУУЛИАР ХҮЛЭЭСЭН ҮҮРЭГ МӨН”

“PROTECTING HUMAN RIGHTS AND FREEDOMS
IS A PROSECUTOR’S LEGAL DUTY”

Монгол Улсын Ерөнхий прокурорын орлогч, Төрийн хууль цаазын шадар зөвлөх Максимын Чинбатыг “Хүний эрх” сэтгүүлийн 2020 оны эхний дугаарын зочноор урьж ярилцлаа. Тэрбээр Прокурорын байгууллагад 1995 оноос хойш ажиллаж байгаа нэгэн тул Монгол Улсад прокурорын байгууллага байгуулагдсаны түүхт 90 жилийн ойн босгон дээр хийсэн бүтээсэн зүйл, хөндөж ярих сэдэв мундахгүй их байв.

Прокурорын байгууллагын мэдээлэл хаалттай байна гэж хэвлэлийнхэн шүүмжилдэг. Энэ нь үйл ажиллагааны онцлогтой холбоотой байх. Сүүлийн үед зарим хүмүүс ямар нэгэн хэрэг зөрчлийг цахим сүлжээгээр мэдээлж, олон нийтийн санаа бодлыг татаж, улмаар хуулийн байгууллагуудын шийдвэрт нөлөөлөх оролдлого их хийх боллоо. Та бүхний ажилд энэ байдал хэр саад учруулж байна вэ?

Прокурорын байгууллага Үндсэн хуульд заасан чиг үүргийнхээ хүрээнд эрүүгийн хэрэг, зөрчил хянан шийдвэрлэх ажиллагаанд хяналт тавьж

ажилладаг, өдөр тутмын үйл ажиллагаа маань хүний эрх, эрх чөлөөг хөндсөн, шууд хамааралтай явагддаг онцлогтой. Олны санаа бодлоос хамаарч, шийдвэр гаргана гэвэл хууль зөрчигдөх магадлал өндөр болно. Прокурор хууль, шударга ёсыг л баримтлах ёстой. Аливаа асуудлыг хөндлөнгийн байр сууринаас шүүмжлэх, үзэл бодлоо илэрхийлэх нь прокурорын хувьд төрийн албаны ёс зүйн талаасаа хязгаарлагдмал байдаг. Прокурор нь хуулийн хүрээнд ажлаа явуулах ёстой бөгөөд тухайн хэргийн оролцогч биш субъектүүд эрх, ашиг сонирхол нь хөндөгдсөн мэтээр асуудал тавьж хандах явдал цөөнгүй байна. Шаардлагатай гэж үзвэл, хэрэг материалыг хянаж үзэж байна. Гэтэл өөрт таалагдсан шийдвэр гаргуулахаар муйхарлаж зүтгэдэг, дур зоргоороо ханддаг, харин холбогдох хэргүүдийг хянаж үзэхээр ном ёсоороо шийдвэрлэгдсэн, сэргээж шалгуулах шаардлагагүй, нэгэнт шалгаад мухарлачихсан, хэрэг хянан шийдвэрлэх хугацаа дууссанаас дахин шалгуулах боломжгүй тохиолдол ихэнхдээ байдаг. Хөөн хэлэлцэх хугацааг Эрүүгийн хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд өөрөөр хуульчилснаас үүдэж, нийгэмд асуудал гарч, ойлголтын зөрүү үүсээд байсныг хууль тогтоох дээд байгууллагаас арилгаж, дахин хуульчлан тогтоосон.

Хууль, шүүхийн байгууллагууд хүний эрх, эрх чөлөөг зөрчлөө гэж их ярих боллоо. Хүнийг эрүүдэн шүүж, хилс хэрэг хүлээлгэх явдлын эсрэг Прокурорын байгууллагын зүгээс ямар ажил арга хэмжээ авч байна вэ?

Улсын Ерөнхий прокурор Б.Жаргалсайхан өнгөрсөн онд шинээр томилогдоод, бодлогын хувьд авч хэрэгжүүлсэн арга хэмжээний нэг нь Эрүүдэн шүүхээс урьдчилан сэргийлэх ажил хариуцсан бүтцийг бий болгосон. Улсын Ерөнхий прокурорын тушаалаар Эрүүдэн шүүхээс урьдчилан сэргийлэх Зөвлөлийг 2019 оны 6 дугаар сард байгуулсан. Энэхүү Зөвлөл нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 13 дахь заалтад заасан, хүний эрх, эрх чөлөөг хамгаалах, зөрчлийн болон эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх, ял эдлүүлэх ажиллагааны явцад эрүү шүүлт тулгаж, хүний эрх зөрчихөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг Прокурорын байгууллагын хэмжээнд нэгтгэн зохион байгуулж, нэгж прокурорын газруудын үйл ажиллагааг мэргэжлийн удирдлагаар ханган, хүний эрхийг хамгаалах бусад байгууллагуудтай хамтран ажиллаж байна.

Хүнийг удаан хугацаагаар хорьсон, хорих байрны нөхцөл шаардлага хангахгүй байгаа талаар шүүмжлэл гарсаар байна. Энэ тухайд?

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад тодорхой үндэслэл, журмын дагуу хүнийг баривчлах, цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авах нь шүүх, прокурор, мөрдөх байгууллагын эрх хэмжээний асуудал байдаг. Гагцхүү энэ ажиллагаа маань хуульд нийцсэн байх учиртай.

Монгол Улсын Ерөнхий прокуророос 2019 оны 6 дугаар сард эрүү шүүлт тулгахаас урьдчилан сэргийлэх тухай албан даалгавар гаргаж, хэрэг бүртгэх,

мөрдөн байцаах, ял эдлүүлэх ажиллагааны явцад хүний эрхийг зөрчих, эрүү шүүлт тулгаж, хүнлэг бус хэрцгий хандах зэрэг хэрэг зөрчил гаргахгүй байхад прокурорын хяналтыг чиглүүлж ажиллахыг нийт прокуроруудад үүрэг болгосон. Албан даалгаврыг хэрэгжүүлэх зорилгоор харьяа нэгж Прокурорын газраас баривчлах, цагдан хорих байр, хорих ангиудын ахуй нөхцөл, үйл ажиллагаанд хяналт шалгалтын ажлыг тогтмол хийж, илэрсэн зөрчлийг арилгуулах арга хэмжээг авч ажиллаж байна.

Хүнийг эрүүгийн хэрэгт яллагдагчаар татаж, цагдан хорьсон тохиолдолд хэргийн хөнгөн, хүндээс шалтгаалж хорих нийт хугацааг хуулиар тогтоосон байдаг, хуульд зааснаас илүү хугацаагаар хорих нь өөрөө эрүүгийн хэргийн шинжтэй үйлдэл болдог. Прокурор шүүхэд цагдан хорих санал гаргах субъектийнхээ хувьд, тухайн хүний хоригдсон хугацааг нарийн тооцож, үндэслэл бүхий саналыг тавьдаг, хуульд зааснаас илүү хугацаагаар хүнийг цагдан хорьсон тохиолдол гараагүй, гарах ч ёсгүй, шүүгч ч шийдвэр гаргахдаа хуулийн дээрх заалт, холбогдох нотлох баримтыг судлан шинжилдэг юм.

Хууль шүүхийн практикт тэгш эрхийн зарчимд харшлахуйц үзэгдэл ажиглагдах боллоо. Жишээ нь ямар нэгэн эрүүгийн хэргийн талаар олон нийтийн сүлжээгээр лайвдаад, өлсгөлөн зарлаад төрийн өндөр албан тушаалтнуудыг дуудаж ирүүлээд, ам өчиг авахуулж байна. “Өндөр авсан хэрэг” гэдэг нэр томьёо ч гарч ирлээ. Тэгэхээр энэ бас нэг гажуудал биз?

Хууль, шүүхийн байгууллагад итгэх итгэл нийгэм, олон нийтийн дунд буурчихсан үе байсан. Энэ талаар олон улсын байгууллагын 2018 онд гаргасан судалгаа ч бий. Таны хэлсэн дээрх үйлдэл нь шүүх, прокурорын хараат бус байдалд нөлөөлж болзошгүйг тэр хүмүүс нь ойлгохгүй, ойлгохыг хүсэхгүй байна. Шүүх эрх мэдлийн байгууллагуудын ажилтан нь хуулиар хүлээсэн үүрэгт ажлаа хэн нэгний таалалд нийцүүлж хийх асуудал байж болохгүй. Иргэн, албан тушаалтан хэн боловч нийгэмд тогтоосон хууль журмыг зөрчихгүй байх ёстой. Зарчмаараа явахгүй гажуудсанаас болж төрийн байгууллагын, ялангуяа шүүх, хууль хяналтын нэр хүнд уначихсан, нийгмээрээ хэрэг хэлэлцдэг, шүүдэг цаг үеийг хэн ч хүсэхгүй.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа нь хэргийг шуурхай, бүрэн илрүүлэх, хэрэг үйлдсэн хүнийг олж, шударгаар ял шийтгэх, хүний эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах зорилтод тулгуурладаг. Шуурхай байх ёстой. Шуурхай байна гэдэг нь хагас дутуу дүгнэлт гаргана гэсэн ойлголт огт биш. Гэтэл өнөөдөр төрийн өндөр албан тушаалтан, тусгай алба хаагч холбогдсон хэргийг шалгах үед өмгөөлөх, өмгөөлүүлэх эрх гэж яриад, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд санаатайгаар саад учруулах нь олонтаа гарч байна. Прокурорын байгууллагаас яллах дүгнэлтээ гардаж авдаггүй, дуудсан цагт ирдэггүйгээс прокурор мэдэгдэх хуудас хүргүүлж, улмаар албадан ирүүлэх шүүхийн шийдвэр гаргуулах байдлаар ажлаа хийж байна. Хуульд заасан энэхүү процессыг ашиглаад эхлэхээр “Прокурор хүч хэрэглээд,

эрх зөрчиж байна” гэдэг. Хоёрдугаарт, хэргийн материалтай танилцахгүй, сонгосон өмгөөлөгчөө шүүхийн шатанд өөрчилж сольдог, шүүгч, прокурор, өмгөөлөгчөөс үндэслэлгүйгээр татгалзах зэргээр цаг хугацаа хождог зохисгүй байдалцөөнгүй байна. Ял шийтгэлээс мултрах, цаг хугацаа хожих гэж иймэрхүү явуургүй заль хэрэглэх хууль, шүүхийн байгууллагын ажилд хүндрэл учруулж байна. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны оролцогч нар аль аль талдаа хариуцлагатай байх ёстой.

Энэ жил Монгол Улсад Прокурорын байгууллага үүсэж хөгжсөний 90 жилийн түүхт ой тохиож байна. Энэ тухайд?

Прокурорын байгууллага нь Монгол Улсын нутаг дэвсгэрт эрүүгийн болон зөрчлийн хууль тогтоомжийн хэрэгжилтийг нэг мөр хангуулах, хэрэг бүртгэх, мөрдөн байцаах, ял эдлүүлэх ажиллагаанд хяналт тавих, шүүх хуралдаанд төрийн нэрийн өмнөөс оролцох чиг үүрэг бүхий, хараат бус, бие даасан, шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэхэд оролцогч байгууллага юм. Өнөөдөр прокурор Үндсэн хуульд заасан чиг үүргээ хэрэгжүүлж, хараат бусаар ажиллаж байна. БНМАУ-ын Улсын Бага Хурлын Тэргүүлэгчдийн 1930 оны 8 дугаар сарын 14-ний өдрийн 25 дугаар тогтоолоор “Прокурорын дагаж мөрдөх эрх, үүргийн дүрэм”-ийг баталж, Прокурорын байгууллагад улсын нэрийн өмнөөс хуулийн биелэлтэд хяналт тавих хариуцлагатай үүрэг хүлээлгэсэн энэ өдрийг Монгол Улсад Прокурорын байгууллага үүсч байгуулагдсан өдөр гэж тооцдог билээ. Прокурорын байгууллага нь улсын хэмжээнд аймаг, нийслэл, тээвэр, дүүрэг, сум дундын гэсэн 39 нэгж газруудад нийт 510 прокурор, 250 туслах ажилтан, 340 захиргаа, үйлчилгээний алба хаагч ажиллаж байна. Бид түүхт ойгоо Прокурорын албаны өдрөөр буюу энэ оны 8 дугаар сарын 14-ний өдөр тэмдэглэхээр төлөвлөж, ойг угтсан нэлээдгүй бүтээлч ажлууд хийж байна. Ковид-19 цар тахлын улмаас хорио цээрийн дэглэм хэрхэн өөрчлөгдөхийг харж байна. 2019 оны 6 дугаар сард түүхт ойгоо тэмдэглэх бэлтгэл ажлын төлөвлөгөөг гаргаад, Ажлын дэд хэсгүүд байгууллага, хамт олноо сурталчлах, ном товхимол гаргах, илтгэл уралдаан зохиох, баримтат кино хийх, хяналтын ажлын аян зохион байгуулах зэргээр олон хүн цуглуулахгүйгээр, мөнгө зардал багатай ажлуудаа хийгээд явж байна. Нэгж газруудын хувьд, байгууллага, хамт олныхоо ажиллах нөхцөл боломжийг сайжруулахад чиглэсэн цөөнгүй ажлыг хийж байна.

Хүний эрхийн хамгаалагчдын нэг болох прокуроруудын аюулгүй байдал, санхүүгийн хараат бус байдлын баталгаа хэр хангагдсан бэ?

Монгол Улсын Прокурорын тухай хуульд, прокурорын үйл ажиллагааны баталгааг хараат бус байдлын, хууль зүйн, эдийн засгийн нийгмийн, улс төрийн гээд тодорхойлон хуульчилж тогтоосон. Прокурор хүн шүүх хуралдаан болон мөрдөх, хорих байгууллагуудад очиж ажиллахад аюулгүй байдал хангалттай биш, энэ талаар зохион байгуулалтын ажил арга хэмжээ авч байна. Прокурор бол төрийн нэрийн өмнөөс албан үүрэг гүйцэтгэж байгаа

төрийн тусгай алба хаагч. Хэвлэл мэдээллийн хэрэгсэл, цахим сүлжээ ашиглан, нийгэм, олон нийтэд прокурорын нэр хүндийг зориуд харлуулсан, халдсан үйлдэлд хүлээцтэй ханддаг ч бид анхааралтай ажиглаж, шаардлагатай бол хуульд заасан ажил, арга хэмжээг авч хэрэгжүүлнэ. Прокурорын байгууллагыг хүчгүйдүүлэх гэсэн зохион байгуулалттай ажиллагаа байгааг үгүйсгэхгүй. Яриад байгаа этгээдүүд цаанаа хууль зүйн ямар нэгэн асуудалтай, прокурорын шийдвэрт нөлөөлөх зорилготой байдаг.

Шүүх, прокурорын байгууллагын үйл ажиллагаа, шийдвэрийг жирийн иргэнээс эхлээд төрийн өндөр албан тушаалтан нь хүртэл шууд буруутгаж, ял зэм хүртээхээс наагуур шүүмжлэх юм. Энэ талаар таны бодол юу вэ?

Эрүүл шүүмж бол хүлээн авах хамгийн сайн зөвлөгч, харин байгууллага, ажилтныг гүтгэж доромжилж огтоос болохгүй. Прокурорын шийдвэрийн буруу, зөвийг Прокурорын байгууллага л тогтооно, хэрэв эрүүгийн хэрэг шүүхэд шилжсэн бол шүүх дэнслэх учиртай. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад шүүгч, прокурор, мөрдөгчийн хууль зөрчсөн ажиллагааны улмаас учирсан хохирлыг, тэдний гэм бурууг үл харгалзан төр хариуцан арилгана, төр эргээд хуульд заасан хариуцлагаа хүлээлгэнэ гэсэн зарчмаар явах ёстой байтал өнөөдөр төрийг ч төр биш болгоод байна. Прокурорын нэр төр, байгууллагыг хамгаалах бүтэц манайд байдаг, үүнийгээ зөв, үр дүнтэй, шуурхай ашиглах ёстой.

Танай байгууллага Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комисстой хамтран ажиллах Санамж бичгийг олон жилийн өмнө байгуулж, хүний эрх, эрх чөлөөг хангах, хамгаалах, соён гэгээрүүлэх чиглэлээр ажиллаж ирсэн туршлагатай. Өнөөдөр ч хоёр байгууллагын хамтын ажиллагаа үргэлжилж байна. Хүний эрхийн чиглэлээр ахиц дэвшил гарсан гэдэгтэй Та санал нийлэх үү?

Прокурорын үйл ажиллагаа зөв гольдролд байгаа эсэхийг толины тусгал мэт ил тод харуулж өгдөг хараат бус байгууллагын нэг бол Хүний эрхийн Үндэсний Комисс юм. Ямар нэгэн субъектив нөлөөнд автахгүйгээр прокурорын байгууллагын ажлыг харах учраас прокурор зөв явж байна уу, буруу юу гэдгийг Комисс хэлэх байх. Эрх нь зөрчигдсөн хүмүүс Комисст хандах нь их байна. Монгол Улсын Үндсэн хуульд заасан, хүний эрх, эрх чөлөөг хамгаалах, зөрчигдсөн эрхийг хангах үндсэн зорилтын үүднээс хоёр байгууллага хамтран ажиллахаас аргагүй юм. Эрүүдэн шүүхээс урьдчилан сэргийлэх, зөрчигдсөн эрхийг хамгаалах, хүний эрхийн талаар сургалт зохион байгуулах чиглэлээр өргөн хүрээтэй хамтын ажиллагаа чухал байна.

Таны хувьд Улсын Ерөнхий прокурорын орлогчоор томилогдохдоо нэлээд сорилтын дор томилогдож байгаа нь нээлттэй сонголын үед ажиглагдаж байсан. Ажил үүргээ хүлээн авсанаас хойш төлөвлөсөн зүйлээ хийж чадсан уу?

Хуульд заасан шалгуур, нөхцөлийн дагуу томилогдсон. Зарим төрийн бус байгууллагуудын шаардлагын дагуу нийтийн сонголд орсон нь нийгмийн хүсэлт, хүлээлт, салбарын асуудлыг хөндлөнгөөс тандаж мэдэхэд дөхөм байлаа.

Прокурорын байгууллага бол нэгдмэл төвлөрсөн удирдлагатай, бодлого нэг байдаг. Асуудлыг үндэс сууриар нь тавиад явж байгаа гэж боддог. Хоёрдугаарт УИХ-ын чуулганаар хэлэлцэх үед бас захиас даалгаврууд өгсөн. Нийгмийг юу бухимдуулж байна вэ гэвэл авилга, албан тушаалын гэмт хэрэг, улс төрийн өндөр албан тушаалтан холбогдсон хэргүүд шийдвэрлэгдэхгүй байгаа явдал. Бид тодорхой ахиц гаргасан, тоон үзүүлэлтээр харагдаж байгаа. УИХ-ын зарим гишүүд ч энэ талаар олон нийтэд мэдээлсэн. Давхар хяналтын хэргийн тоо ноднин жил ажил хүлээж авах үед 66 байсан бол өнөөдөр 23 болтлоо буурсан, ээдрээ төвөгтэй, олны анхаарал татсан, төрийн өндөр албан тушаалтан холбогдсон хэргүүдийнхээ дийлэнхийг шийдвэрлэсэн байгаа. 2019 оны тайлан мэдээнээс үзвэл, Улсын Ерөнхий прокурорын газарт иргэдээс хандаж гаргасан гомдол 3 дахин өссөн дүн гарсан. Энэ нь шинэ удирдлагуудад найдсан хүлээлт үүссэн байна гэсэн үг. Урьд өмнө нь гарсан, өөрт таалагдахгүй шийдвэрүүдийг дахин шалгуулахаар хандсан тохиолдол ч цөөнгүй байна. Эдгээр нь ажлын ачааллыг нэлээд нэмсэн байгаа. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд сайжруулах зүйл заалт цөөнгүй бий, прокурорын ачаалал, процесс ажиллагаа бодит практикт өмнөх үеэсээ нэмэгдсэн.

Та прокуророор чамгүй удаан ажиллажээ. Энэ ажил мэргэжлийг сонгоход юу нөлөөлөв? Ажил мэргэжлээрээ хэрхэн бахархдаг вэ?


Орон нутгийн Прокурорын байгууллагад анх прокуророор томилогдсоноос хойш 25 дахь жилдээ ажиллаж байна. Биднийг их сургууль төгсөх үед дээд боловсролтой, эрх зүйч мэргэжилтэй хүнийг шууд прокуророор томилдог байсан. Одоо бол хуулийн зохицуулалт, шалгуур өндөр болсон. Прокурор хүн бол харилцааны зөв мэдрэмжтэй, ёс зүйн дүрмээ биелүүлж ажиллах ёстой. Ажлын онцлогоос хамаараад хохирогчтой биш, голдуу болдоггүй хүнтэй харьцаж, ял төлөвлөөд явуулж байгаа болохоор хэн л “баярлалаа” гэж хэлэх билээ. Гэхдээ хэзээд шударга үнэний төлөө ажиллаж байгаадаа баяртай байдаг.

Цаг зав гарган ярилцсан Танд баярлалаа.

Энэ завшааныг ашиглаад, танай сэтгүүлийн хамт олонд ажлын амжилт хүсье. Монгол төрийн Прокурорын байгууллагын түүхт 90 жилийн ойг тохиолдуулан, энэ байгууллагад залуу халуун нас, хөдөлмөр зүтгэлээ зориулж ирсэн ахмадууддаа эрүүл энхийг хүсье. Өнөөдөр прокурорын хариуцлагатай, эрхэм албыг нэр хүндтэй гүйцэтгэж буй нийт прокурор, алба хаагч нартаа түүхт ойн баярын мэндийг дэвшүүлж, Та бүхэнд ажлын амжилт хүсье.

*Ярилцсан: Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний
Комиссын референт З.Бадмаараг*

UIH.MN
СУДАЛГААНЫ САН



UIH.MN
СУДАЛГААНЫ САН

Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комисс
Тусгаар тогтнолын талбай, Засгийн газрын XI байр, V давхар
Утас: 51-266506, 51-262902, Факс: 976-11-320284
Цахим хаяг: www.nhrctm.gov.mn, Цахим шуудан: info@nhrctm.gov.mn
Иргэдээс гомдол хүлээн авах, хууль зүйн зөвлөгөө өгөх утас: 7000-0222
Хүний эрхийн цахим номын сан: <https://lib4u.net/?lib=nhrctm>

ISSN: 2617-9288